9. Худалдагдсан тээврийн хэрэгслийн үнэ тухайн үеийн ижил чанар, төрлийн тээврийн хэрэгслийн зах зээлийн үнээс илт зөрүүтэй бол талууд хөрөнгийн үнийн зөрүүг арилгах үүрэгтэй.

10. Энэ гэрээний нөхцөлийг зөрчсөнөөс аль нэг талд шууд хохирол учирвал нөгөө тал хохирлыг арилгаж, ирээдүйд олох байсан ашгийг тооцон барагдуулна. Хохирол учирсан эсэхийг хохирогч тал нотолно.

11. Давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт)-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

12. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

13. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

14. Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

15. Гэрээг 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

16. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

Худалдагч:

Хаяг: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

Худалдан авагч:

Хаяг: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

ТЭЭВРИЙН ХЭСЭГСЭЛ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Гэрчилгээний дугаар
Улсын бүртгэлийн дугаар

Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсгийг үндэслэн нэг талаас _____ тоотод

оршин суух _____ овогтой _____ би
/цаашид "Худалдагч" гэнэ/, _____ нөгөө _____ талаас

_____ тоотод оршин суух _____
овогтой _____ /цаашид "Худалдан авагч" гэнэ/ бид
харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

1. Худалдагч..... овогтойби, худалдан авагч овогтой.....-д улсаас оруулж ирсэн,улсын дугаартай,.....өнгөтэй маркын,хөдөлгөөртэй,арал, кузовтой тээврийн хэрэгсэлийг худалдаж байна.
2. Уг тээврийн хэрэгсэл нь худалдагчовогтой.....миний хувийн өмч бөгөөд энэ нь-ны Замын Цагдаагийн газраас онысарын.....-ны олгосонсерийн дугаар бүхий Тээврийн хэрэгсэлийн гэрчилгээгээр нотлогдоно.
3. Тээврийн хэрэгсэлийг худалдах үнийг..... /тоогоор//үсгээр/, /төгрөг, ам.доллар, юань, рубль/ байхаар гэрээний хоёр тал харилцан тохиролцсон бөгөөд төлбөрийг оны.....сарын.....-ны өдөр төлж барагдуулна.
4. Уг үл хөдлөх эд хөрөнгийг худалдаагүй, барьцаалаагүй, битүүмжлээгүй, түрээслээгүй болно. Мөн эд хөрөнгөтэй холбогдох төлбөр, тооцооны асуудалгүй болно. Үүнийг гэрчилж /худалдагч тал/ гарын үсэг зурав.
5. Худалдсан тээврийн хэрэгсэлд худалдагдсанаас хойш...../сар, жил/ хугацаагаар буюу.....км-ын ашиглалтын баталгаа олгоно.
6. Худалдан авагч нь гэрээнд заагдсан шаардлага хангаагүй тээврийн хэрэгсэлийн доголдлын талаар Худалдагчид гомдлын шаардлага гаргана.
7. Худалдагч гомдлын шаардлагыг хүлээн авснаас хойш доголдлыг..... хоногийн дотор өөрийн хөрөнгөөр арилгах, гэрээний шаардлагад нийцэх ижил төрлийн тээврийн хэрэгслээр солих эсхүл худалдсан тээврийн хэрэгсэлийг буцаан авч, Худалдан авагчид төлбөрийг нь нэн даруй буцаан олгоно.
8. Худалдагчийн буруугаас тээврийн хэрэгсэлийг хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд үнийн дүнгийн хувиар тогтоон Худалдан авагчид торгууль төлнө.
9. Худалдан авагч төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүй тохиолдолд худалдан авагчид хэтрүүлсэн хоног тутамдалданги төлнө.
10. Худалдаалагдсан тээврийн хэрэгсэлийн үнэ тухайн үеийн ижил чанар, төрлийн тээврийн хэрэгсэлийн зах зээлийн үнээс илт зөрүүтэй бол талууд хөрөнгийн үнийн зөрүүг арилгах үүрэгтэй.
11. Энэ гэрээний нөхцөлийг **зөрчсний** улмаас аль нэг талд шууд хохирол учирвал нөгөө тал хохирлыг арилгаж, ирээдүйд олох байсан ашгийг тооцон барагдуулна. Хохирол учирсан эсэхийг хохирогч тал нотлох үүрэг хүлээнэ.
12. Худалдагч тээврийн хэрэгсэлийг худалдан авагчид шилжүүлэн өгөхдөө хүлээлгэн өгөх акт үйлдэнэ. Тус актанд худалдан авагч талын хүсэлтээр тээврийн хэрэгсэлийн бүрэн бүтэн байдал, эвдрэл гэмтлийг холбогдох байгууллагаар шинжлүүлсэн баримтыг хавсаргана.
13. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.
14. Энэхүү гэрээ нь нотариатчаар гэрчлэгдэн, Тээврийн хэрэгсэлийг өмчлөх эрхийн гэрчилгээ худалдан авагчийн нэр дээр шилжиснээр хүчин төгөлдөр болно.
15. Энэхүү худалдах худалдан авах гэрээг хүчин төгөлдөр болох хүртэл үүнтэй холбогдон гарсан зардлыг Иргэний хуулийн 245 дугаар зүйлийн 245.1-д зааснаар худалдан авагч тал хариуцна.
16. Гэрээг 3 хувь үйлдэж, гэрээний хоёр тал тус бүр нэг нэг хувийг, нотариатч 1 хувийг буюу эх хувийг авч үлдээнэ.
17. Гэрээний нэмэлт нөхцөл:

.....
.....
.....
.....

Талуудын хаяг:

Худалдагч тал:

Регистрийн дугаар №:

.....
Иргэний үнэмлэхийн дугаар:

.....
Оршин сууж буй хаяг:

.....
Холбоо барих утас:

.....

Худалдан авагч тал:

Регистрийн дугаар №:

.....
Иргэний үнэмлэхийн дугаар:

.....
Оршин сууж буй хаяг:

.....
Холбоо барих утас:

.....

Гэрээ байгуулсан:

Худалдагч:

.....ОВОГТОЙ
.....
...../гарын үсэг/

Худалдан авагч:

.....ОВОГТОЙ
.....
...../гарын үсэг/

ГАЗАР ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

/Энэхүү гэрээг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 28.1.1 дэх хэсэгт заасны дагуу зөвхөн Монгол улсын иргэд байгуулна/

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)
Гэрчилгээний дугаар.....
Улсын бүртгэлийн дугаар.....
Нэгж талбарын дугаар.....

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 27.1.1 дэх хэсгийг үндэслэн нэг талаас тоотод оршин суух овогтойби /цаашид “Худалдагч” гэнэ/, нөгө талаас тоотод оршин суух овогтой /цаашид “Худалдан авагч” гэнэ/ бид харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний ерөнхий нөхцөл

1.1. /аймаг, хот/, /сум, дүүрэг/, хороо/-ны нутаг дэвсгэрт орших, тоот газар өмчлөх эрхийн гэрчилгээ тоот

бүртгэлийн дугаартайметр урт,метр өргөн, ам дөрвөлжин метр талбай бүхий газрыг болон түүний өмчлөх эрхийг тус тус худалдах, худалдан авахаар тохиролцов.

1.2. Талууд худалдах, худалдан авахаар тохиролцсон үл хөдлөх хөрөнгө болох уг газрыг

...../тоогоор/...../үсгээр/
төгрөгөөр худалдахаар тохиролцов.

Худалдан авагч үнийг төлөхдөө:

а) Худалдагч талоны дугаар сарын-ны дотор багтаан газрыг Худалдан авагчид шилжүүлэн өгнө.

б) Худалдагч тал Газар өмчлөх эрхийн гэрчилгээ болон түүнтэй холбоотой бусад бичиг баримтыг /Кадастарын зураг, Засаг даргын шийдвэр гэх мэт / худалдан авагчийн нэр дээр шилжүүлсний дараа Худалдан авагч тал төлбөрийг бэлнээр хийж дуусгана.

1.3. Монгол Улсын татварын хуулийн дагуу төлөх ёстой үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны татварыг, мөн "Худалдах, худалдан авах гэрээ"-г нотариатаар гэрчлүүлэхэд гарах зардлыг Иргэний хуулийн 245 дугаар зүйлийн 245.1-д зааснаар худалдан авагч тал хариуцна.

Хоёр. Худалдагчийн эрх, үүрэг

2.1. Худалдан авагч, худалдан авсан газраа хүлээн авах буюу үнийг төлүүлэхээр гэрээгээр тогтоосон хугацааг хожимдуулбал, үүргээ биелүүлэх болон биелэлтийг саатуулснаас учирсан хохирлыг төлөхийг шаардах эрхтэй.

2.2. Худалдагдсан үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэн өгөх хүртэл түүний бүрэн бүтэн байдлыг хариуцах үүрэг хүлээнэ.

2.3. Гэрээний нөхцөлд тохирохгүй эд хөрөнгө шилжүүлэх, биелэлтийг саатуулах тохиолдол гарвал Худалдан авагчид учирсан хохирлыг нөхөн төлнө. Эд хөрөнгийг шилжүүлэн өгөхөд түүний дагалдах бичиг баримт болох үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ болон түүнтэй холбогдох бусад баримт, бичгийг хамтад нь олгоно

Гурав. Худалдан авагчийн эрх, үүрэг

3.1. Худалдан авсан эд хөрөнгийн үнийг тогтоосон хугацаанд бэлнээр, төгрөгөөр төлнө.

3.2. Энэ гэрээнд заасан хугацаанд эд хөрөнгийг хүлээн авна.

3.3. Үүрэг биелүүлэх хугацаа хожимдуулсан тохиолдолд түүнээс шалтгаалан гарсан зардал, хохирлыг Худалдагч талд төлж хохиролгүй болгоно.

3.4. Худалдагч эд хөрөнгийг шилжүүлэх үүргээ хугацаанд нь биелүүлээгүй буюу гэрээний үүргээ биелүүлэх хугацаа хожимдуулснаас учирсан хохирлоо төлөхийг шаардах эрхтэй.

3.5. Эд хөрөнгийг хүлээн авахдаа энэ гэрээнд заасан чанар байдал зэргийг шалгаж, дагалдах бичиг баримтын хамт авах ба хүлээн авах үед илэрсэн дутагдлын талаар Худалдагч талтай тухайн үедээ хэлэлцэн, хэрхэхийг шийдвэрлэж, хүлээн авсан тухай баримтанд тодорхой тусгана.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Энэхүү үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг Газрын харилцаа геодиз зураг зүйн газрын эрхийн улсын бүртгэлийн албанд бүртгүүлнэ.

4.2. Энэ үл хөдлөх эд хөрөнгийг худалдах тухай хамтран өмчлөх эрхтэй гэр бүлийн гишүүдийн зөвшөөрлийг хавсаргана.

Тав. Гэрээ биелүүлэх баталгаа ба хариуцлага

5.1. Гэрээг байгуулагч талууд үүргээ хугацаанд нь шударгаар биелүүлнэ. Хэрвээ үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол Монгол Улсын Газар өмчлүүлэх тухай хуулийн 40 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Гэрээнд заасан хугацаанд үүргээ биелүүлээгүй тал гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн хувиар тооцож хоног тутам алданги төлнө.

5.3. Гэрээний аль нэг тал өөрийн үүргийг хугацаандаа биелүүлэхгүй тохиолдолд нөгөө тал үүргээ биелүүлэх тодорхой хугацаа заах бөгөөд тохиролцсон хугацаанд үүргээ хэрэгжүүлэхгүй бол гэрээг цуцалж, гэрээ байгуулснаас учирсан хохирлыг **хохиросон** этгээдээр тогтоосон анзыг төлүүлнэ.

5.4. Талууд байгуулах гэрээ, худалдагдсан зүйлийн талаар санал, зөрөлдөөн гарвал Иргэний хууль болон Газар өмчлүүлэх тухай хуульд заасан журмын дагуу гомдлын шаардлага гаргах, хариу өгөх зэргээр эвийн журмаар маргааныг зохицуулна.

5.5. Маргааныг зохицуулж чадаагүй тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах замаар шийдвэрлэнэ.

5.6. Гэрээ, талууд гарын үсэг зурж, нотариатаар гэрчлүүлсэн нөхцөлд хүчин төгөлдөр болж, хүлээсэн үүрэг бүрэн биелэгдэж дуустал үргэлжлэнэ.

5.7. Гэрээг талууд тус бүр нэг нэг хувийг авна, Газрын харилцаа геодез зураг зүйн газрын эрхийн улсын бүртгэлийн албанд 1, нотариатч 1 хувийг тус тус авна.

Талуудын хаяг:

Худалдагч тал:

Регистрийн дугаар №:

Иргэний үнэмлэхийн дугаар:

Оршин сууж буй хаяг:

Холбоо барих утас:

Худалдан авагч тал:

Регистрийн дугаар №:

Иргэний үнэмлэхийн дугаар:

Оршин сууж буй хаяг:

Холбоо барих утас:

Гэрээ байгуулсан:

Худалдагч:

.....овогтой

.....

...../гарын үсэг/

Худалдан авагч:

.....овогтой

.....

...../гарын үсэг/

Иргэний хуулийн 128 дугаар зүйлийн 128.2-т зааснаар зөвшөөрөл олгосон хамтран өмчлөгчид:

Хамтран өмчлөгчид:
Эцгийн нэр, нэр, рег№, гарын үсэг
үсэг

Хамтран өмчлөгчид:
Эцгийн нэр, нэр, рег№, гарын

1.....
1.....
2.....
2.....
3.....
3.....
4.....
4.....
5.....
5.....

Гэрээг гэрчилсэн:

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ
/Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл/

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Энэхүү гэрээг нэг талаас _____ ХХК, ХК /улсын
бүртгэлийн дугаар _____, регистр _____/-ийг, цаашид
“Эзэмшигч” гэх, _____-ны өдрийн _____-тоот тушаалын үндсэн
дээр _____ төлөөлж, нөгөө талаас
_____ ХХК,ХК /улсын бүртгэлийн дугаар _____,
регистр _____ /-ийг, цаашид “Худалдан авагч гэх, дүрмийн үндсэн
дээр _____ төлөөлж, Ашигт малтмалын тухай хуулийн
49 дүгээр зүйл, Иргэний хуулийн 260 дугаар зүйлд заасны дагуу дараахь
нөхцлөөр гэрээ байгуулав.

Нэг. Гэрээний зүйл

1.1. Эзэмшигч нь ашигт малтмалын хайгуулын дараахь тусгай зөвшөөрөл
/цаашид “лиценз” гэх/-ийн гэрчилгээгээр олгосон эрхийг худалдан авагчид бүрэн
хэмжээгээр шилжүүлэх, худалдан авагч хүлээн авч үнийг нь төлөхөөр үүрэг
хүлээж байна.

_____-ны өдөр олгосон _____ тоот лицензийн гэрчилгээ,

нэртэй газарт _____ га талбайд хайгуул явуулах. Үүнд:

Дараахь эрхийг эзэмшигч нь худалдан авагчид шилжүүлж, худалдан авагч нь
хүлээн авах болно.

- лицензийн гэрчилгээнд заагдсан хайгуулын талбайн хил хязгаарт ашигт
малтмалын хайгуул хийх онцгой эрх,

- хайгуулын талбайн аль ч хэсэгт ашигт малтмал ашиглах лиценз авах онцгой эрх
- хайгуулын лицензийг бүхэлд нь буюу хэсэгчлэн бусдад шилжүүлэх, барьцаалах эрх,
- хайгуулын ажил хийх, шаардлагатай түр байгууламж барих зорилгоор хайгуулын талбайд нэвтрэн орох, дамжин өнгөрөх эрх,
- дээр дурьдсан эрхээ хэрэгжүүлэх зорилгоор бусдын эзэмшил ашиглалтад байгаа газарт түүний эзэмшигч буюу ашиглагчтай нь байгуулсан гэрээний дагуу нэвтрэн орох, дамжин өнгөрөх эрх,
- ашигт малтмалын хайгуулын лиценз эзэмшигчийн хуулиар тогтоосон бусад эрх.

Хоёр. Лицензээр олгосон эрхийг шилжүүлэхтэй холбогдсон талуудын эрх, үүрэг

2.1. Эзэмшигчийн үүрэг:

2.1.1. Лиценз шилжүүлснийг ашигт малтмалын тухай хуулийн 49-р зүйлд заасны дагуу хүргэх ажиллагаа Геологи, уул уурхайн кадастрын алба сэргээсэн өдрөөс хойш 10 хоногийн дотор, тус албанаас баталсан К-6 маягтын дагуу өргөдөл бөглөж түүнд нэр заасан баримтуудыг үйлдэн хавсаргаж Худалдан авагчид гаргаж өгнө. Ингэхдээ бичиг баримтыг хүлээлцэх актаар шилжүүлнэ. Лицензийн дагуу эрхийг шилжүүлснийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бүртгүүлсэн мөчөөс эхлэн гэрээгээр шилжүүлж байгаа эрх Эзэмшигчээс Худалдан авагчийн эзэмшилд шилжинэ.

2.1.2. Энэ гэрээгээр шилжүүлж буй эрхийн хүчин төгөлдөр байдлыг худалдан авагчийн өмнө хариуцна. Эзэмшигч нь энэ гэрээний 1.1-д заасан лиценз нь түүний эзэмшилд байгаа бөгөөд Худалдан авагчийн нэр дээр шилжүүлснийг хуульд заасан журмын дагуу бүртгүүлэх үед лиценз нь барьцаалагдаагүй, ямар нэг маргаангүй, битүүмжлэгдээгүй ба гуравдагч этгээдийн эрх мэдэл, шаардлагад байхгүй талаар баталгаа гаргана.

2.2. Худалдан авагчийн үүрэг

2.2.1. Энэ гэрээнд заасан лицензийн эрхийг Эзэмшигчээс Худалдан авагчид шилжүүлснийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэхэд өөрийн зүгээс шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн, Геологи, уул уурхайн кадастрын албанд гаргаж өгнө. Худалдан авагч нь эдгээр үйлдлийг гүйцэтгэхдээ, лицензийг Эзэмшигчээс Худалдан авагчид Геологи, уул уурхайн кадастрын албанд өргөдөл өгсөнөөс хойш 14 хоногийн дотор бүртгүүлсэн байхаар бодолцож хийнэ.

2.2.2. Лицензээр шилжүүлж буй эрхийн үнийг энэ гэрээний 3 дахь хэсэгт заасны дагуу Эзэмшигчид төлнө.

2.2.3. Эрх шилжүүлэх үеийн нөхцөл, хэмжээгээр нь энэ гэрээний дагуу эрхийг хүлээн авна.

2.2.4. Лиценз шилжүүлэн авснаар эрх шилжүүлэх үед байгаа хэмжээ, нөхцөлөөр бүхэлд нь хүлээн авна.

2.2.5. Худалдан авагч нь ашигт малтмалын хайгуул явуулж, ихгэхдээ шаардлагатай мэдээ, тайлан гаргах, ариун цэвэр эрүүл ахуйн дүрмийг мөрдөх, ажиллагсдын аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах болон Монгол Улсын хууль тогтоомжид заасан бусад үүргийг хүлээнэ.

Гурав. Гэрээний нийт үнэ, төлбөр тооцоо хийх журам

3.1. Гэрээний нийт үнэ нь _____ /төгрөг, ам.доллар/
байх ба энэ нь шилжүүлж буй лицензийн эрхийн үнэ _____
/төгрөг, ам.доллар/ болон НӨАТ-ын _____ /төгрөг,
ам.долларын/ нийлбэр дүнгээс бүрдэнэ.

3.2. Энэ гэрээний 3.1-д заасан хэмжээний мөнгөн төлбөрийг Худалдан авагч нь гэрээний 7 дахь хэсэгт заасан Эзэмшигчийн харилцах дансанд бэлнээр дараахь хугацаанд төлнө:

3.2.1. _____ /төгрөг, ам.долларыг/ 200__оны__ -
ны өдрийн дотор

3.2.2. _____ /төгрөг, ам.долларыг/ Худалдан авагчийн нэр дээр шилжүүлсэн лицензийг Геологи, уул уурхайн кадастрын албанаас хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор

3.3. Энэ гэрээний дагуу лиценз шилжүүлснийг бүртгүүлэхтэй холбогдон гарсан зардлыг эзэмшигч хариуцна.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

4.1. Талууд энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

4.2. Талууд урьдчилан таамаглаж, боломжийн аргаар зайлуулах аргагүй онцгой үйл явдал гэрээ байгуулсны дараа болсноос үүссэн давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал /форс-мажор/-ын улмаас энэ гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн буюу бүхэлд нь биелүүлээгүй тохиолдолд талууд хариуцлагаас чөлөөлөгдөнө. Гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаа энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно. Форс мажорын нөхцөл байдал бий болсныг төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан актаар баталгаажуулна. Эдгээр нөхцөл байдлаас шалтаглаж буй тал нь энэхүү байдал бий болсноос хойш ажлын 5 хоногийн дотор нөгөө талдаа мэдэгдэх үүрэгтэй. Форс-мажорын нөхцөл байдал ажлын 30 хоногоос илүү хугацаагаар үргэлжлэх тохиолдолд талууд энэ гэрээг биелүүлэх журмыг харилцан зөвшилцөж шийдвэрлэх үүрэг хүлээнэ.

4.3. Энэ гэрээний 3.2.1-д заасан мөнгөн дүнг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Эзэмшигч нь гэрээг дангаараа цуцлах эрхтэй болно.

4.4. Энэ гэрээний дагуу төлбөрийг хугацаанд нь хийгээгүй тохиолдолд Худалдан авагч хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлбөр хийгээгүй мөнгөн дүнгийн 0,1%-тай тэнцэх алдангийг Эзэмшигчид төлнө.

4.5. Байгаль орчныг хамгаалах, түүний дотор нөхөн сэргээлт хийх үүргээ Худалдан авагч хугацаанд нь биелүүлээгүй буюу уг үүргээ биелүүлээгүй тохиолдолд тэрээр зохих /түүний дотор хяналт шалгалтын/ байгууллагуудын өмнө хариуцлага бүрэн хэмжээгээр хүлээнэ. Лицензийн дагуу эрх Худалдан авагчид шилжсэнийг бүртгэсэн мөчөөс эхлэн Эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, түүний дотор нөхөн сэргээлт хийх үүргийн биелэлтийн талаар зохих /түүний дотор хяналт шалгалтын/ байгууллагуудын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

4.6. Энэ гэрээнээс үүссэн маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Талууд харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд шүүхэд хандаж маргааныг шийдвэрлүүлнэ.

Тав. Гэрээний үйлчлэх хугацаа

5.1. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээгээр хүлээсэн үүргээ талууд бүрэн биелүүлж дуустал үйлчилнэ.

6. Бусад нөхцөл

6.1. Талууд харилцан зөвшилцсөнөөр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, түүнийг цуцалж болно.

6.2. Энэ гэрээний дагуу лиценз шилжүүлэхтэй нэгэн зэрэг уг лицензээр олгосон хайгуулын талбайн байрлаж буй эдэлбэр газрыг эзэмших ба ашиглах эрх нь Эзэмшигч тухайн газрыг эзэмшиж, ашиглаж байсан хэмжээ, нөхцлөөр Худалдан авагчид шилжих болно.

6.3. Энэ гэрээнд тусгагдаагүй бусад асуудлаар талууд Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг баримтална.

6.4. Энэ гэрээгээр хүлээсэн эрх буюу үүргээ аль нэг тал зөвхөн нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрлөөр гуравдагч этгээдэд шилжүүлж болно.

6.5. Энэ гэрээг хууль зүйн хувьд адил хүчинтэй дөрвөн эх хувь монгол хэл дээр үйлдсэн бөгөөд талууд тус бүр нэг хувийг хадгалж, нэг хувийг Геологи, уул уурхайн кадастрын албанд өгөх ба нэг хувийг нотариатчид хадгалуулна.

Талуудын албан ёсны хаяг, гарын үсэг

Худалдан авагч:

тамга

Эзэмшигч:

тамга

БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг)

(цаашид “Бэлтгэн нийлүүлэгч” гэнэ), түүнийг _____
(итгэмжлэл)

үндсэн дээр төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нөгөө талаас _____
(иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг)

(цаашид “Худалдан авагч” гэнэ), түүнийг _____
(итгэмжлэл)

үндсэн дээр төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

дараахь гэрээг байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Бэлтгэн нийлүүлэгч нь _____-г
(бүтээгдэхүүний нэр)

бэлтгэн худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэн өгч уг бүтээгдэхүүнийг гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан тоо хэмжээгээр болон тогтоосон хугацаанд худалдан авагч хүлээн авч, үнийг төлнө.

1.2. Бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай харилцан тохиролцсоны үндсэн дээр бүтээгдэхүүнийг хугацаанаас нь өмнө тээвэрлэн илгээж болно. Хугацаанаас өмнө нийлүүлэгдсэн бүтээгдэхүүн нь хавсралтад заасан графикийн дагуу нийлүүлэлтийн дараагийн үед тооцогдоно.

2. Чанар, иж бүрдэл

2.1. Бэлтгэн нийлүүлж буй бараа бүтээгдэхүүн нь чанарын хувьд _____

(Улсын стандарт, техникийн нөхцөл гэх мэт)

нийцсэн байна.

2.2. Бараа бүтээгдэхүүний чанар, иж бүрдэл нь _____

(чанар, иж бүрдлийн сертификат)

нийцсэн байна.

3. Гэрээний үнэ

3.1. Бэлтгэн нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний үнийг _____

(валют, төгрөг)

_____ -Д

(үсгээр)

төлнө.

3.2. Бүтээгдэхүүний үнэд _____ -ний

(сав, баглаа боодол, _____)

үнэ _____.

(орно; орохгүй)

3.5. Мөнгөн дүн нь гэрээнд гарын үсэг зурах үед _____

байна.

(дүнг үсгээр)

4. Ачаа тээвэрлэх журам

4.1. _____ -Г

(бараа бүтээгдэхүүний нэр)

_____ -ээс

(ачаа илгээх цэг)

_____ -аар

(тээврийн хэрэгслийн төрөл)

ачиж илгээнэ.

4.2. Бараа бүтээгдэхүүнийг _____ хэмжээгээр

(хэмжих нэгж)

бэлтгэн нийлүүлнэ.

4.3. Ачиж илгээх хамгийн бага хэмжээ нь _____ байна.

Үүнээс бага хэмжээгээр ачвал дутуу бэлтгэн нийлүүлэлт гэж үзнэ.

5. Баглаа, боодол

5.1. Бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэлт, хадгалалтын явцад хамгаалж чадахуйц

_____ -Р

(баглаж боох хэрэгсэл)

баглаж бооно.

5.2. Худалдан авагч бохирдсон, эвдэрч гэмтсэн баглаа боодолтой бараа бүтээгдэхүүнийг хүлээн авсан үеэс хойш _____ өдрөөс илүүгүй хугацаанд Бэлтгэн нийлүүлэгчийн хаягаар буцааж илгээнэ.

5.3. Баглаа боодол нь _____

_____ -Д

(Улсын стандарт, техникийн нөхцөл)

нийцсэн байна.

6. Тооцооны журам

Худалдан авагч тооцоог _____ үеэс

(гэрээнд гарын үсэг зурсан; бараа илгээсэн өдөр, хүлээж авсан гэх мэт)

хойш _____ хоногийн дотор _____
(хугацаа) (урьдчилгаа төлбөрөөр, бэлтгэн нийлүүлэгчийн тооцооны
_____ хийнэ.
дансанд гуйвуулах гэх мэт)

7. Гэрээний үйлчлэх хугацаа

Гэрээ нь _____ оны _____ сарын _____ өдрөөс хүчин төгөлдөр болж _____ оны _____ сарын _____ хүртэл үйлчилнэ.

8. Өмчлөх эрх шилжих

Өмчлөх эрх нь Бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авагчид _____
_____ үед шилжинэ.
(бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах, өгөх актанд гарын үсэг зурсан үе)

9. Талуудын хариуцлага

9.1. Бэлтгэн нийлүүлэгч нь гэрээг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол:

Гэрээний нөхцөл зөрчсөнөөс учирсан хохирлыг худалдан авагчид нөхөн төлнө. Дутуу бэлтгэн нийлүүлсэн бол бэлтгэн нийлүүлээгүй бараа бүтээгдэхүүний үнийн _____ хувиар тооцон торгууль төлнө.

зохих ёсны чанар бүхий бараа бүтээгдэхүүн нийлүүлээгүй бол чанаргүй бараа бүтээгдэхүүний үнийг нөхөн төлөх ба дутуу нийлүүлсэн бүтээгдэхүүний хэмжээтэй адил хэмжээгээр торгууль төлнө.

Бэлтгэн нийлүүлэлтийн хугацаа хожимдуулсан бол Худалдан авагчид тийнхүү хугацаа хожимдуулсан өдрөөс эхлэн хоног тутам бараа бүтээгдэхүүний үнийн _____ хувиар тооцон анз төлнө.

Түүнээс гадна Бэлтгэн нийлүүлэгч Худалдан авагчид олоогүй буюу дутуу олсон ашгийн хохирлыг нөхөн төлнө.

9.2. Худалдан авагч нь гэрээг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол: Гэрээний нөхцөл зөрчсөнөөс учирсан хохирлыг Бэлтгэн нийлүүлэгчид нөхөн төлнө.

Төлбөр төлөх хугацаа хожимдуулсан бол Бэлтгэн нийлүүлэгчид тийнхүү хугацаа хожимдуулсан өдрөөс эхлэн хоног тутам хугацаа хожимдуулсан үнийн _____ хувиар тооцон торгууль төлнө.

Баглаа боодлыг буцааж олгоогүй бол баглаа боодлын үнийн _____ - ийг төлнө.

Баглаа боодлыг буцаах хугацаа хожимдуулсан бол тийнхүү хугацаа хожимдуулсан өдрөөс эхлэн хоног тутам _____ төгрөгийн хэмжээтэй торгууль төлнө.

(үнийг үсгээр)

10. Нэмэлт нөхцөл

11. Гэрээг өөрчлөх, цуцлах

11.1. Талууд гэрээний дээр дурдсанаас _____ бусад нөхцөлийг өөрчлөхөд санал нийлэхгүй бол маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

11.2. Гэрээг дараахь тохиолдолд цуцална:

- талуудын тохиролцсоноор;
- эрх бүхий байгууллагын шийдвэрээр;
- давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлөөр.

11.3. Гэрээг нэг талын санаачилгаар цуцалж үл болно.

12. Маргааныг шийдвэрлэх

12.1. Маргаан үүссэн тохиолдолд талууд хэлэлцээ хийх замаар зохицуулна.

12.2. Маргааныг хэлэлцээ хийх замаар шийдвэрлэж болохгүй бол хариуцагчийн оршин суугаа газрын шүүхээр шийдвэрлүүлнэ.

13. Гэрээний хавсралт

13.1. Хавсралт № _____ хуудас.

13.2. Хавсралт № _____ хуудас.

14. Талуудын хаяг

Бэлтгэн нийлүүлэгч:

Хаяг: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

Захиалагч:

Хаяг: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

№ ____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг)

(цаашид "Худалдагч" гэнэ), түүнийг _____
(итгэмжлэл)

үндсэн дээр төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нөгөө талаас _____
(иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг)

(цаашид "Худалдан авагч" гэнэ), түүнийг _____
(итгэмжлэл)

үндсэн дээр төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

дараахь гэрээг байгуулав.

1. Нийтлэг заалт

Худалдагч тал энэ гэрээний нэг хэсэг болох (хавсралт №____) тодорхойлогдон заагдсан барааг (цаашид "бараа" гэх) Худалдан авагч талд худалдан нийлүүлэх нөхцөлөөр нийлүүлнэ.

2. Гэрээний үнэ

2.1. Энэ гэрээний нийт үнэ _____ төгрөг байна.
(дүнг үсгээр)

2.2. Энэ гэрээний 3.1-т заасан хугацаанаас өмнөх үнэ тогтвортой буюу хатуу байна. Заагдсан хугацаанаас хойш барааг Худалдан авагч талд нийлүүлээгүй тохиолдолд нийлүүлээгүй барааны үнийн дүнг дурдсан өдрөөс эхлэн _____ хоногийн хугацаанд _____ хувиар нэмэгдүүлнэ. Энэ нь Худалдагч талын буруутай үйлдлээс шалтгаалаагүй байна.

3. Нийлүүлэлтийн хугацаа

3.1. Барааг 200__ оны ____ дугаар сарын __-ны өдрийг дуустал нийлүүлнэ. Хэрэв Худалдан авагч тал энэ гэрээний 5.2-т заасан урьдчилсан төлбөрийг 5.1-т заасан хугацаанд хийгээгүй бол Худалдагч тал энэ гэрээний биелэлтийн үүргийг хангах үүрэг хүлээхгүй. Худалдан авагч талын дээрхи буруутай үйлдлийн улмаас бараа нийлүүлэх хугацаа хожимдсон тохиолдолд Худалдагч тал бараа нийлүүлэх хугацааг нөхөн сунгах эрхтэй. Хэрвээ ийм хэлбэрээр дээр дурдсан бараа нийлүүлэх хугацаа өөрчлөгдвөл Худалдан авагч тал 2.2-т заасан нөхцөлөөр төлбөр хийх үүрэгтэй.

Энд Худалдан авагч талын зүгээс холбогдох тусгай зөвшөөрөл авахтай холбогдсон хугацаа хамаарахгүй.

3.2.Худалдагч талын нийлүүлсэн барааны тоог _____(ачаа-тээврийн, барааны) падаан болон баглаа боодлын заагдсан байршлаар тогтооно.

4. Хугацаа хожимдуулсны торгууль

4.1.Хэрэв Худалдагч талаас үл шалтгаалан энэ гэрээний 3.1-т заасан хугацаанд барааг нийлүүлэх боломжгүй бол Худалдагч тал Худалдан авагч талд нийлүүлээгүй нийт барааны үнийн дүнгийн __ хувиар торгуулийг долоо хоног тутам төлөх ба торгуулийн хэмжээ цаашид дараагийн _____ долоо хоногийн туршид _____ хувиас илүүгүй байна.

4.2.Хоёр талаас хамтран тохиролцсон хугацаа хэтэрсний торгуулийг Худалдан авагчийн нэхэмжлэлийн дагуу Худалдагч тал хийнэ.

5. Төлбөр төлөх нөхцөл

5.1. Худалдан авагч нь энэхүү гэрээнд заасан төлбөрийг Худалдагчид тооцооны баримтыг хүлээж авсан үеэс хойш _____ хугацаанд урьдчилгаа
(хоног)

хэлбэрээр төлнө.

5.2.Урьдчилсан төлбөрийн хэмжээ _____ байна. Энэ нь нийт
(үсгээр)

гэрээний үнийн дүнгийн _____ хувь байх бөгөөд нэхэмжлэлийн эх хувь болон хуулбар 2 хувь байна.

5.3.Худалдагч тал бараа нийлүүлсний дараа нэхэмжлэлийг явуулна. Худалдан авагч тал 5.1, 5.2-т урьдчилан заасан хэмжээнд барааг нийлүүлсэн тухай өөрийн гарын үсгээр баталгаажуулна.

5.4.Худалдагч тал нэхэмжлэлд _____ (ачаа-тээврийн, барааны) падаан 2 хувь, баглаа боодлын тодорхойлолтыг тус тус хавсаргана.

5.5.Хэрэв 5.1-т заасан хугацаанд Худалдагч талын нэхэмжлэлийн төлбөрийг Худалдан авагч тал хийгээгүй тохиолдолд Худалдагч тал хугацаа хэтрүүлсэний төлөө хоног тутам _____ хувийн алданги тооцно.

6. Давагдашгүй хүчин зүйл

6.1.Энэхүү гэрээг гүйцэтгэхэд нөлөөлөх давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл (гал түймэр, усны үер, газар хөдлөх, нийгмийг хамаарсан самуун үймээн болон бусад онц байдлын нөхцөл гэх мэт)-үүд бий болсон тохиолдолд талууд графикаар тогтоосон бараа нийлүүлэлтийг дээрхи нөхцөл байдлын хэв шинжээс хамаарч хойшлуулна.

6.2.Талууд гэрээний нөхцөлийг биелүүлэхэд саад болж буй давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал бий болсон буюу дууссаныг харилцан нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

6.3.Хэрвээ давагдашгүй хүчин зүйлийн үр дагавраар _____ хоног хугацаа хожимдвол талууд гэрээний биелэгдээгүй үүргийг гүйцэтгэхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд гэрээний аль ч тал нөгөө талаас учирсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах эрхгүй.

6.4.Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал бий болсныг урьдчилан мэдсээр байж гэрээний үүргээ биелүүлээгүй Тал хожим дээрхи нөхцөл байдлын улмаас хамаарч биелүүлээгүй гэсэн шалтгаан заах эрхгүй. Гэхдээ урьдчилан мэдсэн гэдгийг нөгөө тал нотлох үүрэгтэй.

7. Баталгаа

7.1. Худалдагч тал гэрээний дагуу нийлүүлсэн бараа нь техникийн нөхцөлийг хангасан, стандартад нийцсэн тухай баталгаа гаргана. Худалдагч тал Худалдан авагч талд _____ (үйлдвэрлэлийн чанарын сертификат) гаргаж өгнө.

7.2. Барааг нийлүүлсэн өдрөөс хойш баталгаат хугацаа _____
_____ (хугацааг заах) байна.

8. Баглаа боодол

8.1. Барааг тогтоосон (стандарт) загварын холбогдох шошготой баглаагаар бооно.

8.2. Шошгыг тод өнгийн, угаагддаггүй будгаар тэмдэглэсэн байх ба дараахь зүйлийг агуулна:

Худалдан авагч тал: _____

Гэрээний №: _____

Байршил №: _____

Ачаа хүлээн авагч: _____

Ачаа хүлээн авагчийн хаяг: _____

Байрлал №: _____

Цэвэр жин: _____ (кг)

Бохир жин: _____ (кг)

Савны хэмжээ: _____

Ачаа илгээгч: _____

8.3. Барааны баглаа(сав) дахь зарим хэсэгт онцгой анхааралтай хэсэгт нэмэлт тэмдэглэгээ хийнэ. “Анхаар”, “Болгоомжил”, “Дээш нь харуулах”, “Дулаалгатай вагон” зэрэг барааны онцлог шинжийг тодорхойлсон бүх төрлийн тэмдэглэгээг хийнэ.

9. Мэдэгдэл

9.1. Бараа ачуулсан болон хүлээн авсан тухай мэдэгдлийг Худалдагч, Худалдан авагч хоёр тал тогтоосон хугацаанд хийнэ.

10. Маргаан шийдвэрлэх журам

10.1. Худалдагч, Худалдан авагч талууд энэ гэрээ болон түүнтэй холбогдуулан гарах бүхий л маргаантай асуудал, саналын зөрүүг харилцан хэлэлцэх замаар шийдвэрлэх бүхий л арга хэмжээг авна.

10.2. Хэрэв талууд маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

11. Нэмэлт нөхцөл

_____.

12. Бусад нөхцөл

12.1. Гэрээний бүх хавсралт энэ гэрээний салшгүй хэсэг мөн. Энэ гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлт нь бичгээр үйлдэгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

12.2. Аль ч тал энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

13. Гэрээ хүчин төгөлдөр болох

13.1. Гэрээнд _____ дугаартай хавсралтын хамт ____ оны ____ сарын ____ өдөр гарын үсэг зурж хоёр хувь үйлдсэн болно.

13.2. Энэхүү гэрээ нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

14. Гэрээний хавсралт

14.1. Хавсралт № _____ хуудас.

14.2. Хавсралт № _____ хуудас.

15. Талуудын хаяг

Худалдагч:

Хаяг: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

Худалдан авагч:

Хаяг: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

**БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УДААН ХУГАЦААНД АЖ АХУЙН
ХАРИЛЦААНЫ ДАГУУ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ**

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг)

(цаашид “Бэлтгэн нийлүүлэгч” гэнэ), түүнийг _____
(итгэмжлэл)

үндсэн дээр төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нөгөө талаас _____
(иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг)

(цаашид “Худалдан авагч” гэнэ), түүнийг _____
(итгэмжлэл)

үндсэн дээр төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

дараахь гэрээг байгуулав.

1. Бэлтгэн нийлүүлэх зүйл

1.1. Бэлтгэн нийлүүлэгч дараахь бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх ба Худалдан авагч түүнийг хүлээн авч үнийг төлөх үүрэг хүлээнэ:

№	Нэр	Хэмжих нэгж	Бэлтгэн нийлүүлэх хэмжээ	Бүгд	Он

1.2. Бараа бүтээгдэхүүний нэрийн жагсаалт (ассортимент) болон тоо хэмжээг талууд хэлэлцэж энэ гэрээний салшгүй хэсэг болох тусгай тодорхойлолт – жагсаалтаар тохиролцоно.

1.3. Гэрээний үнэ _____ төгрөг (валют) байна.
(үсгээр)

1.4. Худалдан авагч хүлээн авах бүтээгдэхүүний тодорхойлолт – жагсаалтыг _____ хугацаанд
(хугацааг заах)

Бэлтгэн нийлүүлэгчид гаргаж өгнө.

1.5. Худалдан авагчийн тодорхойлолт – жагсаалтыг Бэлтгэн нийлүүлэгч хүлээн авснаас хойш _____ хоногийн дотор эс зөвшөөрч шүүхээр
(хугацааг заах)

шийдвэрлүүлэх талаар хариу мэдэгдээгүй бол уг тодорхойлолт – жагсаалтыг хүлээн авсанд тооцно. Саналын зөрүүг хянан үзэж шийдвэрлэх хүртэл бэлтгэн нийлүүлэх ажлыг талуудын тохиролцсон тодорхойлолт – жагсаалтын дагуу явуулна.

2. Чанар, иж бүрдэл

2.1. Бэлтгэн нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний чанар, иж бүрдэл нь:

_____ (хэм хэмжээ тогтоосон техникийн баримт бичиг: стандарт, техникийн нөхцөл болон

бусад баримт бичиг, тэдгээрийн дугаар, индекс)

_____ -д нийцсэн байна.

2.2. Батлагдсан (тохиролцсон) техникийн баримт бичигт дурдаагүй чанар, иж бүрдлийн талаар тавих нэмэлт шаардлага болон техникийн шинж чанарыг нарийвчлан тогтоох талаар талууд дор дурдсан журмаар тохиролцов.

(Чанарыг сайжруулах, иж бүрдэлд өөрчлөлт оруулах талаар

саналын хуудас, зураг зэргийг нэг талаас нөгөө талдаа илгээх,

түүнийг талууд авч хэлэлцэх журам, хугацааг заах)

2.3. Бэлтгэн нийлүүлэгч өөрийн бэлтгэн нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний чанар, найдвартай байдлыг тогтоосон _____

(баталгаат хугацааг тогтоосон

_____ хугацаанд батлан хариуцна.
стандарт, техникийн нөхцөл болон бусад баримтын нэр, дугаарыг заах)

2.4. Бүтээгдэхүүний шошгын талаар тавигдах нэмэлт шаардлага: _____ болно.

2.5. Бэлтгэн нийлүүлэгчээс бүтээгдэхүүний чанарыг хариуцан гаргасан нэмэлт баталгаа: _____

2.6. Баталгаат хугацааны дотор бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах, угсрах, ашиглах үед согог дутагдал илэрвэл Бэлтгэн нийлүүлэгчийн төлөөлөгчийг заавал дуудна.

2.7. Согог дутагдлыг арилгах эсвэл өөр бүтээгдэхүүнээр солих хугацаа: _____ байна.

3. Бэлтгэн нийлүүлэх хугацаа, журам

3.1. Бараа бүтээгдэхүүнийг энэ гэрээнд хавсаргасан тодорхойлолт – жагсаалтанд дурьдсан хугацаанд бэлтгэн нийлүүлнэ. Бэлтгэн нийлүүлэгч тогтоосон хугацаанаас өмнө бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх эрхтэй. Бэлтгэн нийлүүлэгч хэрэв бололцоо байгаа бол Худалдан авагчаас бүтээгдэхүүнийг яаралтай (хугацаанаас өмнө) бэлтгүүлэх захиалга хүлээн авч болох бөгөөд уг захиалгыг хүлээн авсан тухайгаа хариу мэдэгдэнэ. Бараа бүтээгдэхүүнийг яаралтай бэлтгэнэ гэдэг нь захиалга өгсөн өдрөөс хойш _____ хоногийн дотор бэлтгэн нийлүүлэхийг хэлнэ.

3.2. Бараа бүтээгдэхүүнийг _____
(тээврийн хэрэгслийн төрөл, бүтээгдэхүүн ачих

арга болон ачиж илгээх графикийг тохиролцох журам)

_____ ачиж илгээнэ.

3.3. Ачиж илгээх доод хэмжээ нь _____ байна.
(вагон, чингэлэг, бусад тээврийн хэрэгсэлд ачих ачааны доод хэмжээ)

3.4. Худалдан авагчийн захиалгын дагуу тодорхойлолт – жагсаалтад орсон ачуулах доод хэмжээнээс бага хэмжээтэй бүтээгдэхүүнийг уг жагсаалтад зааснаар бэлтгэн нийлүүлнэ.

3.5. Бэлтгэн нийлүүлэгч бараа бүтээгдэхүүнийг хэсэг хэсгээр ачуулж болно.

3.6. Бараа бүтээгдэхүүн нь тодорхойлолт – жагсаалтад заасан дугаар, индекс бүхий стандарт, техникийн нөхцөлд нийцсэн баглаа боодолтой байна. Үүнд:

_____ (ачиж илгээх үед бүтээгдэхүүнийг баглаж боох хэрэгсэл,

_____ тусгай чингэлэгт, эсвэл ачааг бэхлэх зорилгоор төмөрлөг болон

_____ бусад хэрэгслээр боох эсэх, буцаах журам, хугацаа, тооцоо хийх нөхцөл гэх мэтийг заах)

4. Үнэ, тооцоо хийх журам

4.1. Худалдан авагч Бэлтгэн нийлүүлэгчид бүтээгдэхүүний үнийг талуудын _____

(үнийн хэмжээ)

_____ - ээр

(үнийн талаар тохиролцсон протоколын огноо, дугаар)

тохирсон хэмжээгээр төлнө.

4.2. Төлбөр төлөх хугацаа: _____

4.3. Бараа бүтээгдэхүүний бөөний үнэд доорхи нэмэлт төлбөр, хөнгөлөлт тогтооно. _____

4.3.1. Захиалгыг яаралтай гүйцэтгэсний нэмэлт төлбөр нь бэлтгэн нийлүүлсэн бөөний үнийн _____ хувь байна.

4.3.2. _____
(шаардлагатай бол талууд тохиролцсоны үндсэн дээр тогтоосон нэмэлт төлбөрийн төрөл, хэмжээг заах, эсвэл ийм тохиролцоонд хүрсэн албан ёсны баримт бичгийг заах)

4.4. Талуудын хоорондын тооцоог _____ хийнэ.
(тооцоо хийх арга замыг заах)

4.5. Бүтээгдэхүүний тооцоог _____
(бүтээгдэхүүнийг бүхэлд нь хүлээн авсны эцэст тоног төхөөрөмж, техник оруулсан хэмжээгээр)

4.6. Тусгай баглаа боодол, мөн бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд зориулан хийсэн хэрэгслийн өртгийг үндэслэн Бэлтгэн нийлүүлэгчийн тооцоолон тодорхойлсон үнийг Худалдан авагч төлнө.

5. Талуудын удаан хугацааны аж ахуйн харилцааг хангах хамтын ажиллагаа

5.1. Бэлтгэн нийлүүлэгч: _____
(бэлтгэн нийлүүлэлтийг хугацаанд нь хийх,

техникийн нөхцөл, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх зэрэг Бэлтгэн нийлүүлэгчийн үүргийг заах,

мөн Худалдан авагчид үзүүлэх нэмэлт үйлчилгээ: бүтээгдэхүүнийг бэлтгэх болон тээвэрлэх

хугацааг мэдээлэх, бүтээгдэхүүнийг угсрах, ашиглах явцад техникийн туслалцаа үзүүлэх

_____ үүрэг
хүлээнэ.

(баталгаат болон техникийн үйлчилгээ г.м.)

5.2. Захиалагч: _____

_____ үүрэг хүлээнэ.

5.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд хамтын ажиллагааг алдагдуулахгүй байх, ажил хэрэгч харилцааг дэмжих, аж ахуйн хэлхээ холбоог хөгжүүлэх, үр дүнг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6. Эд хөрөнгийн хариуцлага

6.1. _____

6.2. Гэрээгээр тогтоож буй нэмэлт хариуцлага: _____

7. Маргааныг шийдвэрлэх

7.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

7.2. Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

8. Нэмэлт нөхцөл

9. Бусад нөхцөл

9.1. Энэхүү гэрээнд оруулах бүх нэмэлт өөрчлөлт нь бичгээр үйлдэгдэж, талууд гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр байна.

9.2. Гэрээ нь 200__ оны __ сарын __ өдрөөс хүчин төгөлдөр болж 200__ оны __ сарын __ хүртэл үйлчилнэ.

9.3. Талуудын албан ёсны хаяг, харилцах дансны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд _____ өдрийн дотор харилцан бие биедээ мэдэгдэнэ.

10. Гэрээний хавсралт

10.1. Хавсралт № _____ хуудас.

10.2. Хавсралт № _____ хуудас.

11. Талуудын хаяг

Бэлтгэн нийлүүлэгч:

Худалдан авагч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

БАРААГ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГААР ДАМЖУУЛАН БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200__ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____

(хуулийн этгээдийн нэр, хаяг)

(цаашид “Зуучлагч” гэнэ), түүнийг _____

(итгэмжлэл)

үндсэн дээр төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)
нөгөө талаас _____
(хуулийн этгээдийн нэр, хаяг)
(цаашид “Худалдан авагч” гэнэ), түүнийг _____
(итгэмжлэл)
үндсэн дээр төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)
дараахь гэрээг байгуулав.

1. Нийтлэг заалт

- 1.1. Зуучлагч дараахь бараа бүтээгдэхүүнийг (цаашид энэхүү гэрээний салшгүй хэсэг болох барааны нэрийн жагсаалт, тусгай тодорхойлолт – жагсаалтад “бараа” гэх) _____
_____ бэлтгэн нийлүүлэх үүрэг хүлээнэ.
- 1.2. Худалдан авагч нийлүүлсэн барааг хүлээн авч үнийг төлнө.
- 1.3. Бэлтгэн нийлүүлэх хугацаа, журмыг талууд сар бүр тохиролцож энэхүү гэрээний салшгүй хэсэг болох графикт тодорхойлно.
- 1.4. Зуучлагч барааг тохиролцсон барааны нэрийн жагсаалтын дагуу тавьж олгоно.
- 1.5. Барааг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан шаардлагын дагуу зэрэглэн ялгаж, баглаж, бэлтгэн нийлүүлнэ.
- 1.6. Худалдан авагч барааны баглаа боодлыг дараахь хугацаанд буцаан олгоно: _____.

2. Бараа бэлтгэн нийлүүлэх байгууллага

- 2.1. Худалдан авагч Зуучлагчид агуулахаар бэлтгэн нийлүүлэх барааны тодорхойлолт – жагсаалтыг 2 хувь үйлдэж сар бүрийн _____-ний дотор хүргүүлнэ.
- 2.2. Зуучлагч тодорхойлолт – жагсаалтыг хүлээн аваад гарын үсэг зурж бэлтгэн нийлүүлэх хугацаа эхлэхээс _____ хоногийн өмнө буцааж өгнө.
- 2.3. Шаардлагатай бол Зуучлагч Худалдан авагчтай тохиролцсон хугацаа, хэмжээгээр нэмэлт барааг бэлтгэн нийлүүлнэ.
- 2.4. Баглаа боодол бүхий барааны бэлтгэн нийлүүлэлт дараахь журмаар явагдана: _____

_____.
- 2.5. Худалдан авагч барааг хүлээн авахын тулд Зуучлагчид албан ёсны бичгээр үйлдсэн захиалга өгнө. Зуучлагч захиалгыг хүлээн авснаас хойш _____
_____ (хугацааг заах) _____-ны дотор Худалдан авагчид шаардсан барааг нь илгээнэ.
- 2.6. Худалдан авагч тодорхойлолт – жагсаалтад заасан барааг татгалзах, эсвэл хугацааг өөрчлөх эрхтэй бөгөөд энэ тухайгаа Зуучлагчид бэлтгэн нийлүүлэх хугацаанаас _____ (хугацааг заах) _____ хоногийн өмнө заавал мэдэгдэнэ.
- 2.7. Зуучлагч Худалдан авагчид тодорхойлолт – жагсаалтад заасан болон барааг бэлтгэн нийлүүлэхтэй холбогдсон төрөл бүрийн үйлчилгээ үзүүлнэ.
- 2.8. Худалдан авагч Зуучлагчид үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай баримт бичгийг тухайлсан ажил үйлчилгээ эхлэхээс _____ (хугацааг заах) _____ хоногийн өмнө гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

2.9. Ажлын гүйцэтгэлд алдаа дутагдал гарвал Зуучлагчийн бүрэн эрхт төлөөлөгчийг байлцуулан дахин шалгалт хийгдэнэ.

2.10. Зуучлагч алдаа дутагдлыг дахин шалгалтаас хойш _____ хоногийн дотор засаж залруулна.

3. Тооцоо хийх журам

3.1. Төлбөрийг талуудын улирал тутам тохиролцож энэ гэрээний салшгүй хэсэг болох протоколд тэмдэглэсэн үнээр хийнэ.

3.2. Үйлчилгээ үзүүлсний төлбөрийг Худалдан авагч дараахь журмаар хийнэ:

3.3. Худалдан авагч төлбөрийг Зуучлагчийн төлбөрийн шаардлагыг хүлээн авах замаар сар тутам хийнэ.

4. Нэмэлт нөхцөл

5. Эд хөрөнгийн хариуцлага

5.1. Дутуу буюу чанарын шаардлага хангаагүй бараа бэлтгэн нийлүүлсэн, эсвэл хугацаа хожимдуулсан бол Зуучлагч дутуу буюу чанарын шаардлага хангаагүй барааны үнийн дүнгийн _____ хувьтай тэнцэх хэмжээний, гэхдээ _____

_____ төгрөгөөс илүүгүй торгууль төлнө.

(дүнг үсгээр)

5.2. Төлбөрийг _____ хугацаанд хожимдуулсны төлөө

(хугацааг заах)

Худалдан авагч төлөгдөөгүй үний дүнгийн _____ хувийг төлнө. _____ -ны өдрөөс эхлэн хугацаа хэтэрсэн хоног тутамд

_____ хувийг төлөх бөгөөд нийт торгуулийн үнийн дүн _____ төгрөгнөөс илүүгүй байна.

5.3. Талууд үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талд учирсан хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.

6. Маргааныг шийдвэрлэх

6.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

6.2. Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

7. Гэрээний үйлчлэх хугацаа

7.1. Гэрээ нь 200__ оны __ сарын __ өдрөөс хүчин төгөлдөр болж 200__ оны __ сарын __ хүртэл үйлчилнэ.

8. Гэрээний хавсралт

7.1. Хавсралт № _____ хуудас.

7.2. Хавсралт № _____ хуудас.

9. Талуудын хаяг

Зуучлагч:**Худалдан авагч:**

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БЭЛТГЭХ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**№**_____ хот
(аймаг, сум, дүүрэг)200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____

(хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)

(цаашид "Аж ахуй" гэнэ), түүнийг _____ үндсэн дээр

төлөөлөн _____,

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нөгөө талаас дор жагсаасан үйлдвэрүүд:

№	Бэлтгэх, худалдах үйлдвэрийн нэр	Гэрээнд гарын үсэг зурсан албан тушаалтны албан тушаал, овог, нэр	Гэрээ байгуулах эрх олгох үндэслэл болох баримт бичгийн нэр
1.			
2.			
3.			

(Цаашид "Бэлтгэгч" гэх) бид нар дор дурьдсан гэрээ байгуулав. Үүнд:

1. Аж ахуйн энэ гэрээний салшгүй хэсэг болох _____ -р хавсралтад дурьдсан тоо, чанар, нэр төрлийн бүтээгдэхүүнийг мөн тэнд өгүүлсэн хугацаанд, гэрээгээр тогтоосон үнээр бэлтгэж Бэлтгэгчид худалдана.

2. Бэлтгэгчийн үүрэг хүлээнэ:

а) Гэрээнд дурьдсан барааг гэрээгээр тохирсон хугацаанд хүлээн авч, тогтоосон журмаар барааны болон түүнийг хүргэж өгсний үнийг төлөх.

б) Аж ахуйн нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй улсын стандарт, техникийн нөхцөл, бараа хүлээн авах, худалдан авч буй бүтээгдэхүүнийг үнэлэх, тооцоо хийх тухай болон бусад холбогдох дүрэм журмаар хангах.

в) Аж ахуйд _____ -ээс өмнө _____ хугацаанд _____ төгрөгний урьдчилгаа төлбөр өгнө.

г) Аж ахуйг зохих баглаа боодлоор хангана.

3. Хэрэв энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол талууд дараахь хариуцлага хүлээнэ:

а) Хэрэв аж ахуй бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанаас хожимдуулж нийлүүлсэн буюу нийлүүлээгүй бол хугацаанаас хожимдуулсан хоногт тутамд нийлүүлээгүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн _____ хувьтай тэнцэх хэмжээгээр бэлтгэгчид алданги төлнө.

Хэрэв 10-аас дээш хоногоор хугацаа хэтрүүлбэл алданги төлөхийг зогсоох боловч дээрхи дурьдсан алдангаас гадна нийлүүлээгүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн _____ хувьтай тэнцэх хэмжээгээр торгууль төлнө.

Хэрэв бэлтгэгчийн буруу буюу давагдашгүй хүчин зүйлтэй тулгарснаас болж гэрээний үүргээ биелүүлж чадаагүй бол аж ахуйн хариуцлагаас чөлөөлөгдөнө.

б) Аж ахуйгаас энэ гэрээний нөхцөл, шаардлагыг хангасан бүтээгдэхүүнийг тохиролцсон хуваарийн дагуу нийлүүлж байхад түүнийг хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзсан, эсвэл тогтоосон хугацаа хожимдуулан хүлээж авсан бол бэлтгэгч аж ахуйд тийнхүү хүлээн аваагүй буюу хугацаа хожимдуулан хүлээн авсан бүтээгдэхүүний үнийн дүнгийн _____ хувьтай тэнцэх хэмжээний торгууль, мөн бүтээгдэхүүнийг аж ахуйгаас бэлтгэгчид хүргэсэн, мөн тэндээс буцаасан зардал, түүнчлэн аж ахуйд учирсан хохирол (малын ашиг хорогдох, бүтээгдэхүүний чанар дордох, бүтээгдэхүүнийг хүлээн авахыг хүлээж тээврийн хэрэгслийг сул зогсоох зэрэг)-ийг төлнө.

Бэлтгэгч түргэн гэмтэх бүтээгдэхүүнийг хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзсан бол аж ахуйд торгуулиас гадна уул бүтээгдэхүүний үнийг, түүнийг хүргэж өгөхтэй холбогдуулж гаргасан зардлын хамт төлнө.

в) Бэлтгэгч хүлээн авсан бүтээгдэхүүний үнийг төлөхгүйгээр хугацаа хожимдуулсан бол тийнхүү хожимдуулсан хоног тутамд төлөөгүй үнийн дүнгийн _____ хувийн хэмжээтэй тэнцэх алдангийг аж ахуйд төлнө.

Хэрэв бэлтгэгч үнэ төлөхийг 10 хоногоос дээш хугацаагаар хожимдуулбал алданги төөөхийг зогсоож, харин урьд төлсөн алданги дээр төлөөгүй үнийн дүнгийн _____ хувийн хэмжээтэй тэнцэх торгууль төлнө.

г) Хэрэв аж ахуйг зохих тэнцэх баглаа боодлоор хангаагүй бол тийнхүү хангаагүй баглаа боодлын үнийн _____ хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгууль төлнө.

д) Хэрэв бүтээгдэхүүний тоо, чанарыг буруу тодорхойлох буюу бүтээгдэхүүний үнийг дутуу тооцон төлсөн бол аж ахуйд төлөөгүй мөнгийг түүний жилд _____ хувийн нэмэгдэлтэйгээр төлнө.

4. Буруутай тал нөгөө талдаа торгууль, алданги төлснийг харгалзахгүйгээр талуудын аль нэгэн талын буруугаас болж нөгөө талд учирсан хохирлыг арилгаж өгнө.

5. Энэ гэрээнд дурьдаагүй асуудлыг шийдвэрлэхэд талууд хууль тогтоомжийн заалтыг удирдлага болгоно.

6. Гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдсэн бөгөөд хувь тус бүр хүчин төгөлдөр байна.

7. Талуудын хууль ёсны хаяг:

Аж ахуй:

Хаяг: _____
утас _____ факс _____
Банкны харилцах дансны дугаар: _____

№	Худалдаа, бэлтгэлийн байгууллагын нэр.	Хаяг	Банкны харилцах дансны дугаар.	Гарын үсэг. Тэмдэг.
1.				
2				
3				

Аж ахуй:

(гарын үсэг, тэмдэг)

БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ МАТЕРИАЛ, ТҮҮХИЙ ЭДИЙГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг)

(цаашид “Бэлтгэн нийлүүлэгч” гэнэ), түүнийг _____
(итгэмжлэл)

үндсэн дээр төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нөгөө талаас _____
(иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг)

(цаашид “Дахин боловсруулагч” гэнэ), түүнийг _____
(итгэмжлэл)

үндсэн дээр төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

дараахь гэрээг байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1.Бэлтгэн нийлүүлэгч Дахин боловсруулагчид түүхий эд материал (цаашид “түүхий эд” гэх) нийлүүлэх, Дахин боловсруулагч түүхий эдийг бэлтгэн Бэлтгэн нийлүүлэгчид дараахь бүтээгдэхүүнийг шилжүүлнэ: _____

1.2.Түүхий эд болон бүтээгдэхүүний хэмжээ, чанар, нэрсийн жагсаалтыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох талуудын сар бүр тохиролцох тодорхойлолт – жагсаалтад тэмдэглэнэ.

1.3.Түүхий эд болон бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, түүвэрлэх хугацааг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох талуудын сар бүр хамтран батлах графикт тодорхойлно.

2. Чанарын дагуу, тогтоосон хэмжээгээр хүлээн авах

2.1.Түүхий эд болон бэлэн болсон бүтээгдэхүүнийг _____

(бараа ашиглах баримт бичиг, чанарын гэрчилгээ, түргэн муудах түүхий эд,

_____ дагалдана.

бүтээгдэхүүний чанарын шинжилгээний дүгнэлт)

2.2.Шинжилгээний дүгнэлт ирээгүй тохиолдолд түүхий эд, эсвэл бүтээгдэхүүнийг хүлээн авагч нь нөгөө талын төлөөлөгчийг байлцуулан түүний зардлаар шаардлагатай шинжилгээг хийнэ. Хэрвээ нөгөө тал төлөөлөгчөө явуулаагүй бол эрх бүхий хөндлөнгийн байгууллагаас төлөөлөгч авна.

3. Тооцоо хийх журам

3.1.Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн түүхий эдээс бүтээгдэхүүн бэлтгэсэн ажлын төлбөрийг өмнөх сарын _____ дотор тохиролцсон үнээр сар бүрийн _____-аас хэтрэхгүй хугацаанд хийнэ.

3.2.Төлбөрийг Дахин боловсруулагчийн тооцооны дансанд шилжүүлэх замаар хийнэ.

3.3.Хэрвээ Бэлтгэн нийлүүлэгч бэлэн болсон бүтээгдэхүүнийг түүвэрлэх ажлыг _____ хоногоор хожимдуулбал Дахин боловсруулагч түүвэрлээгүй

(хугацааг заах)

бүтээгдэхүүнийг борлуулах эрх эдэлнэ.

3.4.Баглаа боодлын тооцоог дараахь журмаар хийнэ: _____

3.5.Шинэ улирал эхлэх бүр сарын _____ дотор өмнөх улирлын ажлыг хэлэлцэж дүнг тооцох бөгөөд протоколд тэмдэглэнэ.

4. Эд хөрөнгийн хариуцлага

4.1.Дутуу буюу чанарын шаардлага хангаагүй түүхий эд бэлтгэн нийлүүлсэн, эсвэл бэлтгэсэн бүтээгдэхүүний төлбөр хийх хугацааг хожимдуулсан бол Бэлтгэн нийлүүлэгч дутуу буюу чанарын шаардлага хангаагүй түүхий эдийн эсвэл хугацаанд нь төлбөр төлөөгүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн ____ хувьтай тэнцэх хэмжээний, гэхдээ _____ төгрөгөөс илүүгүй торгууль төлнө.

4.2.Хэрвээ Дахин боловсруулагч Бэлтгэн нийлүүлэгчийн түүхий эдээс бэлтгэсэн бүтээгдэхүүнийг түүнийг түүвэрлэх ажил _____ хоногоор хойшилсноос бусад тохиолдолд борлуулсан бол бэлтгэсэн бүтээгдэхүүний үнийн дүнгийн _____ хувийн хэмжээтэй торгууль төлнө.

4.3.Дахин боловсруулагч чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, өөрөө бие даан борлуулахдаа түүхий эдийн төлбөр хийх хугацаа хожимдуулсан бол тийнхүү чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн _____ хувийн хэмжээтэй торгууль төлнө.

4.4.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол олох байсан ашгийг тооцон барагдуулна. Хохирол учирсан эсэхийг хохирогч тал нотлоно..

4.5. _____

5. Нэмэлт нөхцөл

6. Маргаан шийдвэрлэх журам

6.1.Маргаан үүсэх тохиолдолд талууд асуудлыг зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.2.Талууд зөвшилцөлд хүрэхгүй бол маргааныг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхээр шийдвэрлүүлнэ.

7. Гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа

7.1.Гэрээ нь гарын үсэг зурсан үеэс хүчин төгөлдөр болж _____ хүртэл үйлчилнэ.

7.2.Гэрээний үйлчлэх хугацаа дуусахаас өмнө _____ хоногийн дотор аль нэг талаас гэрээг цуцлах санал тавихгүй бол гэрээг _____ хугацаатай сунгасанд тооцно.

8. Гэрээний хавсралт

8.1.Хавсралт № _____ хуудас.

8.2.Хавсралт № _____ хуудас.

9. Талуудын хаяг

Бэлтгэн нийлүүлэгч:

Дахин боловсруулагч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

№

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(үйлдвэр, байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)

(цаашид "Захиалагч" гэнэ), түүнийг _____
үндсэн дээр төлөөлөн _____

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нөгөө талаас _____
(байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)

(цаашид "Гүйцэтгэгч" гэнэ), түүнийг _____
үндсэн дээр төлөөлөн _____

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

бид дор дурьдсан гэрээг байгуулав. Үүнд:

1. Гэрээний зүйл

1.1. Гүйцэтгэгч нь захиалагчид _____ энэ гэрээнд 1-р хавсралтанд дурьдсан бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч болон гэрээ байгуулагч бусад этгээдийг сонгон авах, тэдэнтэй гэрээ байгуулах талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх үүргийг хүлээнэ.

1.2. Гүйцэтгэгч, захиалагч ба түүнтэй гэрээ байгуулагчийн хооронд тохтролцож болох гэрээний нөхцөл болон уг тохиролцооны томъёололыг боловсруулан бэлтгэнэ.

1.3. Захиалагч нь энэ гэрээнд заасан үйлчилгээ үзүүлсний нь төлөө захиалагч ба түүнтэй гэрээ байгуулагчийн хооронд байгуулсан гэрээний үнийн _____ хувьтай тэнцэх хэмжээний хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

2. Гүйцэтгэгчийн үүрэг

2.1. Гүйцэтгэгч доорхи үүргийг хүлээнэ. Үүнд:

- Энэ гэрээний 1-р хавсралтанд дурьдсан байгаа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх (худалдан авах) боломж бүхий гэрээ багуулагчдыг олохын тулд зах зээлд судалгаа явуулах;
- Захиалагч ба гэрээ байгуулагчдын төлөөлөгчдийн хооронд уулзалт, хэлэлцээр зохион байгуулах;
- Захиалагч гэрээ байгуулагчдын хооронд харилцан ашигтай гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- Захиалагчийн байгуулж буй гэрээтэй холбогдох эрх зүй болон худалдааны асуудлаар зөвлөлгөө өгөх;
- Захиалагчийн ашиг сонирхлын үүднээс түүнтэй хамтран үйлдвэр, хоршоо байхуулах, сонирхол бүхий үйлдвэр, түүний дотор гадаадын үйлдвэр олох, эдгээр асуудлаар захиалагч гэрээ байгуулахад тусламж үзүүлэх.

3. Захиалагчийн үүрэг

3.1. Захиалагч доорхи үүрэг хүлээнэ. Үүнд:

- Захиалагч ба түүнтэй гэрээ байгуулагчдын хооронд зохих гэрээ байгуулагдаснаас хойш _____ хоногийн дотор гүйцэтгэгчил зохих хэмжээний шагнал олгоно.
- Чухал тохиолдолд өөрийн төлөөлөгчдийг гүйцэтгэгчээс гэрээ байгуулагч талтай хэлэлцээр хийхэд оролцуулах, гүйцэтгэгчийг мөн техникийн ба худалдааны зохих материалаар хангах;
- Гүйцэтгэгчид түүний энэ гэрээнд заасны дагуу санал болгосон талтай байгуулсан гэрээний хуулбарыг өгөх.

4. Ажиллах нөхцөл

4.1. Талууд ажиллахдаа гэрээний агуулагад дурьдсан асуудлаар бие бие өгсөн үнэлэлт, зөвлөмжийг анхааралдаа авна.

4.2. Талууд шаардлагатай арга хэмжээг авхуулах зорилтын үүднээс гүйцэтгэхэд саад болж буй бэрхшээлийн тухай бие биедээ нэн даруй мэдэгдэнэ.

4.3. Хэрэв гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу хагас, эсвэл зохих хугацаанд биелүүлж чадахгүй бол талууд энэ тухай бие биедээ бичгээр мэдэгдэнэ.

4.4. Хэрэв Захиалагч үндэслэлгүйгээр энэ гэрээг биелүүлэхийг зогсоовол үүнээс болж гүйцэтгэгчид учирсан хохирлыг төлж өгнө.

Гүйцэтгэгч өөрийн буруугаар гэрээнд заасан үүргээ биелүүлж чадаагүй бол үүнээс болж өөрт учирсан хохирлыг төлүүлхээр бусдаас нэхэмжлэх эрхгүй.

4.5. Захиалагч зохих талтай гэрээ байгуулж, гарын үсэг зурмагц энэ гэрээнд дурьдсан ажлыг бүрэн биелэгдсэнд тооцно.

4.6. Энэ гэрээний 1-р хавсралтад дурьдсан зүйлийг захиалагчаас гүйцэтгэгчид өгсөн захиалгын үндсэн дээр тогтоосон журмын дагуу хянан үзэж нарийвчлан тогтооно.

4.7. Энэ гэрээний үүргийг биелүүлэх явцад гүйцэтгэгч захиалагчийн төлөөлөгчийн нэгэн адил ажиллана.

Гүйцэтгэгч энэ гэрээний хүрээнд захиалагчийн итгэмжлэх бичиггүйгээр захиалагчийн ашиг сонирхлын үүднээс, түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх, бусад ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд харин захиалагчийн нэрийн өмнөөс гэрээнд гарын үсэг зурах эрхгүй байна.

5. Нууцыг хадгалах

5.1. Талууд энэ гэрээний дагуу хүлээн авсан мэдээлэл, баримт бичгийн нууцыг чанд хадгална.

5.2. Талуудын хооронд шилжүүлэн өгсөн нууцын чанартай мэдээлэл, баримт бичигтэй захиалагч, гүйцэтгэгч зөвхөн гэрээний дагуу хийж байгаа ажилтай шууд холбоо бүхий хүмүүс танилцана.

6. Тооцооны журам

6.1. Захиалагч үйлчилгээ хийсний төлөө гүйцэтгэгчид өгөх төлбөрийг гүйцэтгэгчийн харилцах дансанд шилжүүлэх журмаар төлнө.

7. Хариуцлага

7.1. Захиалагч, гүйцэтгэгчийн аль аль нь энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол хууль тогтоомжинд заасан хариуцлага хүлээлнэ.

7.2. Гүйцэтгэгч нь захиалагчийн бусадтай байгуулсан гэрээг бүрэн биелүүлээгүйтэй холбогдох хаируцлагыг хүлээхгүй.

8. Бусад заалт

8.1. Энэ гэрээний дагуу хийсэн ажлыг шаардлагатай гэж үзвэл талуудын хамтран үйлдсэн акт (протокол) болон үйлчилгээ үзүүлсэн тухай бусад баримт бичигт тусган тодорхойлно.

8.2. Талуудын гэрээгээр хүлээсэн үүрэг бүрэн биелсэн, харилцан хийх тооцоог зохицуулж дууссан нөхцөлд гэрээг биелж дууссанд тооцно.

8.3. Хэрэв энэ гэрээнд заасан болон түүнтэй холбогдох асуудлаар маргаан гарвал талууд түүнийг хэлэцээний замаар шийдвэрлэхийн тулд бүхий л арга хэмжээг авна.

8.4. Хэрэв уул маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэж чадахгүйд хүрвэл хууль тогтоомжинд заасны дагуу шийдвэрлүүлнэ.

8.5. Гэрээ талууд гарын үсэг зурмагц гэрээ хүчин төгөлдөр болно.

8.6. Гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

8.7. Талуудын хууль ёсны хаяг:

Захиргаа:

Хаяг: _____

Утас: _____ факс _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Гүйцэтгэгч:

Хаяг: _____

Утас: _____ факс _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Захиаргаа :

Гүйцэтгэгч: _____ :

(гарын үсэг)
тэмдэг

(гарын үсэг)
тэмдэг

АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

Улаанбаатар хот. Дугаар _____ оны __ -р сарын __

Нэг талаас _____
(аудитын үйлчилгээгээр үйлчлүүлж буй байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)
(цаашид "Захиалагч" гэнэ), түүнийг _____ үндсэн дээр
төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

негөө талаас _____
(байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)
(цаашид "Аудит" гэнэ), түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

бид дор дурьдсан гэрээг байгуулав. Үүнд:

1. Захиалагч өөрийн санхүүгийн (улирал, хагас жил, жилийн) ажиллагаандаа дүгнэлт хийх, мөн бусад _____ үйлчилгээ үзүүлэхийг

Аудитад _____
(бусад үйлчилгээний нэрийг бичих)

даалгаж, Аудит уг даалгаврыг биелүүлэхээр хүлээн авав.

2. Санхүүгийн тайланд дүгнэлт өгөх хугацаа: _____
Бусад үйлчилгээнд үзүүлэх хугацаа: _____

3. Үзүүлж буй үйлчилгээний үнэ _____ төгрөг болно.

4. Талууд хоорондохь тооцоог дараахь журмаар хийнэ. _____

5. Захиалагчийн үүрэг:

- Аудитэд нягтлан бодох болон анхан шатны бүртгэлийн мэдээлэл, баримтууд, баримт бичиг, төлөвлөгөө, тушаал болон бусад чухал мэдээллийг цаг тухайд нь өгөх,

- Аудитын ажилтанд ажиллах байр, баримт бичиг хадагалахад зориулан сейф, шкаф гарагж өгөх.

- Шаардлагатай үед өөрийн материалын хариуцлага бүхий хүмүүсийг бэлэн байлгаж, Аудитын ажилтантай уулзуулах, Аудитын бэлтгэсэн бичиг баримтыг машиндах.

- Энэ гэрээний нөхцөлд дурьдсан үйлчилгээ үзүүлсний төлөө зохих төлбөрийг төлөх,

6. Аудитын үүрэг:

- Захиалагчийн үйлдвэр (байгуулага)-ийн дотоод зүрмийн шаардлагыг сахин биелүүлэх.
- Үйлчилгээ үзүүлэхдээ хууль ёсны бөгөөд бодитой арга хэрэгслийг ашиглах дүгнэлтээ баримтжуулах,
- Аудитын ажлын явцад илрүүлсэн буюу түүнд мэдэгдсэн Захиалагчийн худалдааны болон бусад нууц шинж чанар бүхий баримт , мэдээллийг гадагш тараахгүй байх.

7. Энэ гэрээний онцгой нөхцөлд: _____ болно.

8. Гэрээнд дурьдсан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй Тал хууль тогтоомжинд заасан хариуцлага хүлээнэ.

9. Талуудын хооронд гарсан маргааныг хэлэлцээний замаар штйдвэрлэнэ.

10. Хэрэв хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол хууль тогтоомжинд зааснаар шийдвэрлүүлхээр шүүх(арбитр)-д хандах болно.

11. Талуудын хууль ёсны хаяг:

Захиалагч:

Хаяг: _____
Утас: _____ факс: _____
Тооцооны дансны дугаар _____

Аудит:

Хаяг: _____
Утас: _____ факс: _____
Тооцооны дансны дугаар _____

Захиалагч :

Аудит:

:

(гарын үсэг)
тэмдэг

(гарын үсэг)
тэмдэг

МАРКЕТИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

№

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(байгуулага, үйлдвэрлэл, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)
(цааашид “Захирагч” гэнэ), түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн

_____ (төлөөлсөн хүний албан тушаал, нэр)
нөгөө талаас _____
(байгуулага, үйлдвэрлэл, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)
(Цаашид “Гүйцэтгэгч” гэнэ), түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн

_____ (төлөөлсөн хүний албан тушаал, нэр)
бид дор дурвдсан гэрээ байгуулав.

1. Гэрээний зүйл

1.1. Захиалагч өөрийн сонирхлын үүднээс маркетинг (зах зээл судлах)-ийн судалгаа явуулахыг Гүйцэтгэгчид даалгаж, Гүйцэтгэгч уг үүргийг биелүүлэхээр тохиролцов.

2. Судалгаа явуулах газар нутаг

2.1. _____
(Аль орон нутаг, газарт явуулсныг бичнэ)

3. Маркетингийн судалгааны чиглэл

3.1. Маркетингийн судалгааг дор дурьдсан чиглэлээр явуулна:

- а) Худалдааны үйл ажилгаа явуулах хэтийн төлөв, боломж,
- б) Одоо ажиллаж буй хүчтэй өрсөлдөгчийг тодорхойлох,
- в) Өрсөлдөгчийн ажлын нөхцлийн ерөнхий байдал(түүхий эд олох үндэс, ханган нийлүүлэх-борлуулах сүлжээний бүрдэл зэрэг),
- г) Өрсөлдөгчийн бүтээгдэхүүний гүйлгээний ерөнхий байдал(саналын хэмжээ, чанар, үнэ, тооцоо, сезвис зэрэг),
- д) Үнийн байдал, түүний _____ хугацааны өсөлт, бууралтын хэмжээ,
- е) Зах зээлийн туслах бүтцийн хөгжлийн хэр хэмжээ (тээвэр, агуулах, холбоо, сүлжээ зэрэг),
- ж) Худалдааны туслах бүтцийн хөгжлийн хэр хэмжээ (зах, бөөний худалдаа, дуудлагын худалдаа, зуучлалт зэрэг),
- з) Бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ, түүний ирээдүй төлөв,
- и) Эдийн засгийн талаар хүчтэй хэрэглэгчдийн тухай мэдээлэл,
- к) Реклам сурталчилгааны ажлыг хийх бололцоо, зохимж, үр дүн,
- л) _____ хугацаанд байдал ямар болох талаар урьдчилан дүгнэлт хийх,
- м) Аж ахуйн хууль тогтоомжийн байдал, түүнийг хэрэглэж буй практик.

5. Гүйцэтгэгчийн үүрэг

5.1. Гүйцэтгэгч нь дор дурьдсан үүрэгтэй:

- а) Энэ гэрээнд гарийн үсэг зурсанаас хойш _____ хугацаанд судалгааны үр дүнг өгөх.
- б) Судалгааны үр дүнг судалгаа хийсэн чиглэлийн дагуу тодорхой, бүрэн бичиж өгөх.
- в) Судалгааны үр дүнг тодорхой тооцоо шаардагдах зураг схем зэргийг үйлдсэн байх.
- г) Судалгааны ажилд хөндлөнгийн этгээд оролцуулсан нөхцөлд Захиалагчаас хүлээн авсан мэдээллийн нууцыг хадгалах арга хэмжээ авах.

6. Захиалагчийн үүрэг

6.1. Захиалагч дор дурьдсан үүрэгтэй:

- а) Гүйцэтгэгчийн шаардлагаар өөртөө байгаа бөгөөд судалгааны үр дүнд тус болох бүх мэдээллийг өгөх.
- б) Гүйцэтгэгчийн хийсэн судалгааны үр дүнг нэн дариу хүлээн авах.
- в) Гүйцэтгэгчид зохих шагналыг олгох.

7. Судалгаа явуулах журам ба түүний үр дүнг шилжүүлэн өгөх

- 7.1. Гүйцэтгэгч судалгаа, ажлыг бие даан зохион байгуулж явуулна.
- 7.2. Гүйцэтгэгч судалгааны үр дүнг бичгийн хэлбэрээр өгнө.
- 7.3. Судалгааны ажлын үр дүнг хүлээлгэн, хүлээн авахдаа энэ тухай актыг хёор хувь үйлдэж тал тус бүр нэг хувийн хадаглана.
- 7.4. Захиалагч судалгааны ажлын үр дүнг хүлээн авснаас хойш _____ хоногийн дотор зарим нэгэн нэмэлт ажлыг хийж өгөхийг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй бөгөөд түүнийг Гүйцэтгэгч _____ хугацаанд багтааж гүйцэтгэж өгнө. Хэрэв ажлын үр дүнг хүлээн авахаас хойш _____ хугацааны дотор Захиалагч нэмэлт ажил иихийг шаардахгүй бол уг судалгааны ажлын үр дүнг нэхэмжлэл, гомдолгүйгээр хүлээлгэн өгсөнд тооцоно. Нэмэлт ажлыг хүлээлгэн өгөх, хүлээн авах ажлыг мөн энэ тухай акт үйлдэж гүйцэтгэнэ.

8. Гүйцэтгэгчийн шагнал, тооцоо хийх журам

- 8.1. Захиалагч Гүйцэтгэгчид _____ төгрөгийн шагнал олгоно.
- 8.2. Төлбөр (шагнал) төлөх хугацаа:
 - а) Гэрээнд гарийн үсэг зурсанаас хойш _____ хугацааны дотор урьдчилгаа болгон _____ төгрөг:
 - б) Судалгааны үр дүнг хүлээлгэн өгөх, авах актанд гарын үсэг зурсанаас хойш _____ хоногийн дотор (нэмэлт ажил хийх болсон тохиолдолд хүлээлгэн өгөх, хүлээн авах актанд гарын үсэг зурсанаас хойш _____ хоногийн дотор) эцсийн тооцоог хийж дуусгана.Тооцооны төрөл: _____
(бэлэн , бэлэн бус, холимог)
- Тооцооны хэлбэр: _____

- 8.3. Төлбөр эцэслэн төлөх үндэслэл нь судалгааны ажлын үр дүнг хүлээлгэн өгөх, хүлээн авах акт бөгөөд нэмэлт ажил хийх болсон тохиолдолд бол түүнийг мөн хүлээлгэн өгсөн, хүлээн авсан акт болно.
- 8.4. Захиалагч төлбөрийг бэлэн бус журмаар, төлбөрийн даалгавраар Гүйцэтгэгчийн харилцах дансанд шилжүүлнэ.

9. Баталгаат хугацаа

9.1. Энэ гэрээгээр баталгаат хугацаа хүлээлгэн өгөх, хүлээн авах актанд шарийн үсэг зурсан мөчммс эхлэнэ. Баталгаат хугацааны дотор Гүйцэтгэгч энэ гэрээний 1-д заасан асуудлаар Захиалагчид зөвлөгөө өгөх ажлыг үнэ төлбөргүй хийнэ.

10. Талуудын хариуцлага

10.1. Гүйцэтгэгч энэ гэрээгээр дор хариуцлагыг хүлээнэ:

10.2. Захиалагч энэ гэрээгээр дор хариуцлагыг хүлээнэ:

10.3. Энэ гэрээний үүргийг биелүүлэхээс нэг талын журмаар үндэслэлгүйгээр татгалзсан бол буруутай тал _____

_____ хэмжээний торгууль төлнө.

11.Талуудын хоорондоо холбоо барих нөхцөл

11.1. Энэ гэрээгээр Талуудын эрх бүхий төлөөлөгчдөөр доорхи хүмүүс томилогдов. Үүнд:

Захиалагч: _____ утас: _____
Гүйцэтгэгч: _____ утас: _____

12. Энэ гэрээний онцгой нөхцөл

12.1. _____

13. Бусад нөхцөл

13.1. Энэ гэрээг хёор хувь үйлдсэн бөгөөд тал тус бүр нэг хувийг хадгална.

13.2. Талууд энэ гэрээнд дурьдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль тогтоомжийг удирдлага болгоно.

13.3. Энэ гэрээнд гарын үсэг зурмагц түүнд холбогдох асуудлаар урьд хийсэн бүх хэлцэл, захидал, урьдчилсан тохиролцоо болон протоколууд хүчингүй болно.

13.4. Энэ гэрээтэй холбогдон гарсан шаардлагыг Талууд хүлээн авсан өдрөөс хойш _____ хоногийн дотор хянан үзнэ.

13.5. Талууд хууль ёсны хаяг, банкны хаяг, гарын үсэг.

Захиалагч:

Хаяг: _____

Утас: _____ факс: _____

Тооцооны дансны дугаар: _____

Гүйцэтгэгч:

Хаяг: _____

Утас: _____ факс: _____

Тооцооны дансны дугаар: _____

Захиалагч :

Гүйцэтгэгч:

(гарын үсэг)
тэмдэг

(гарын үсэг)
тэмдэг

ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот Дугаар _____ оны__ -р сарын __

Нэг талаас _____
(байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)

(цаашид "Захиалагч" гэнэ), түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нөгөө талаас _____
(зуучлах үйлчилгээ үзүүлэх байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)

(цаашид "Зуучлагч" гэнэ), түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

бид дор дурьдсан гэрээг байгуулав. Үүнд:

1. Гэрээний агуулга

1.1. Захиалагч доорхи ажил гүйцэтгэхийг Зуучлагчид даалгаж, зуучлагч түүнийг биелүүлэхээр хүлээн авна.

Захиалагчийн санал болгосон нөхцлөөр түүний бэлэн бүтээгдэхүүнийг гэрээ байгуулж, худалдан авах сайн түнш олох зорилгоор тодорхой үйл ажиллагаа явуулах (бүтээгдэхүүн болон түүнийг худалдах нөхцлийг Захиалагч тодорхойлж, энэ гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон 1-р хавсралтанд тодорхойлсон болно).

1.2. Худалдан авагчтай худалдах, худалдан авах гэрээ байгуулах нь Захиалагчид дэмжлэг үзүүлнэ.

2. Зуучлагчийн үүрэг, түүнийг биелүүлэх журам

2.1. Зуучлагч өөрт ноогдсон үүргийг хоёр шаттайгаар биелүүнэ.

2.2. Нэгдүгээр шат: Худалдан авагчийг эрэх, олох.

2.3. Хоёрдугаар шат: Захиалагч, Худалдан авагч хоёрын хооронд гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

2.4. Зуучлагчийн нэгдүгээр шатны үүргийг биелүүлэх журам:

2.4.1. Зуучлагч худалдан авагчийг эрэхдээ дараахи ажил гүйцэтгэнэ:

а) Макетингийн (зах зээлийн) судалгаа хийх,

б) Захиалагчийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн тухай өөрт байгаа болон бусад байгаа худалдааны мэдэллийг цуглуулж ашиглах,

в) Шаардагдах зар сурталчилгааны ажил явуулах,

г) Захиалагчийн бүтээгдэхүүний зохих чадвар бүхий Худалдан авагчтай хэлэлцээ хийж захидал бичиж солилцох,

2.4.2. Зуучлагч Захиалагчийн бэлэн бүтээгдэхүүнийг худалдан авах түншийг олсноос хойш _____ хоногийн дотор Захиалагчид дараахи мэдэллийг өгнө:

а) Энэ гэрээний 1-р хавсралтанд дурьдсан нөхцлөөр Захиалагч бэлэн бүтээгдэхүүнийг худалдан авах этгээдийн нэр,

б) Худалдан авагчийн оршиж байгаа хаяг,

в) Хэлцэл хийх үед худалдан авагчаас Зуучлагчид болон улмаар Захиалагчид тавьж буй бөгөөд энэ гэрээний 1-р хавсралтанд дурьдсан нөхцөлтэй нийцэхгүй байгаа сөрөг шаардлага,

г) Худалдан авагчаас Зуучлагчтай гэрээ байгуулах журмын талаар (хугацаа, уулзах газар, нөхцлийг тохиролцох журам зэрэг) болон Захиалагчид тавьж буй санал,

2.4.3. Зуучлагч Захиалагчийн бүтээгдэхүүнийг худалдан авах гэрээ байгуулахад бэлэн байгаагаа баталсан Худалдан авагчийн захидал буюу зохих өөр баримт бичгийг Захиалагчид ирүүлнэ.

2.4.4. Мэдээллийг шилжүүлэн өгөх үед Захиалагч, Зуучлагч хоёр, Зуучлагч Захиалагчийн өмнө хүлээсэн 1-р шатны үүрээ биелүүснийг гэрчилсэн мэдээлэл хүлээлгэн өгөх, хүлээн авах тухай акт үйлдэж гарын үсэг зурна.

2.5. Зуучлагч 2-р шатны үүргийг биелүүлэх журам:

2.5.1. Зуучлагч мэдээллийг Захиалагчид өгч энэ мэдээллийг хүлээлгэн өгөх, хүлээн авах актанд гарийн үсэг зурсанаас хойш _____ хугацааны дотор хэлэлцээ хийх, байгуулах гэж буй гэрээний нөхцөлийн талаар ярилцахад зориулан Захиалагч, Худалдан авагч нарын уулзалт хийх ажлыг зохион байгуулж, тэрчлэн тийнхүү уулзалт хийхэд орчуулагч, хууль зүйн зөвлөгөө зэрэг шаардагдах зүйлээр хангаж өгнө.

2.5.2. Зуучлагч нь Захиалагч, Худалдан авагч нарын уулзалт хийхэд байлцаж тэдгээрэнийн ярианы протокол хөтөлж, түүний нэг хувийг өөртөө хадгална.

2.5.3. Захиалагч, Худалдан авагч хоёр санаа бодлын тухай протокол үйлдэхэд Захиалагч энэ протоколд гарын үсэг зурахад Зуучлагч байлцсан тухай мэдээллийг оруулж өгөх шаардлагыг хангах үүрэгтэй.

2.5.4. Байгуулах гэж буй гэрээний үндсэн нөхцлийн талаар Захиалагч ба Худалдан авагч нар тохиролцсоны дараа Зуучлагч доорхи үүргийг биелүүлнэ:

а) _____ хугацааны дотор Захиалагч, Худалдагч нарын байгуулах гэрээний төслийг бэлтгэх,

б) Энэ гэрээг байгуулахтай холбогдуулан Захиалагчид хууль зүйн, эдийн засаг, зохион байгуулалтын асуудлаар зөвлөгөө өгөх,

в) Захиалагч, Худалдан авагч нарын гэрээнд гарын үсэг зурхад зориулсан уулзалтын зохион байгуулах .

2.5.5. Захиалагч, Худалдан авагч нар байгуулсан гэрээнд гарын үсэг зурсаны дараа Захиалагч, Зуучлагч нар хамтран Зуучлагч 2-р шатны үүргээ биелүүлсэн тухай акт үйлдэнэ (энэ гэрээнд Зуучлагчаас Захиалагчид цаашид үйлчлэх 3-р шатны үүргийн тухай тохиролцон зааж болно, тухайлбал, Зуучлагч даатгалын хэлцэл хийх, агуулах түрээслэх, тээвэрлэлтийг зохион байгуулах, барааг ачуулах талаар Худалдан авагчийн зааварчлагыг Захиалагчид хүргүүлэх, барааны хөдөлгөөн болон түүнийг худалдан авсан тухай мэдээлэл өгөх зэрэг үүргийг Зуучлагч цаашид гүйцэтгэж болно).

3. Захиалагчийн үүрэг

Захиалагч энэ гэрээгээр доорхи үүрэг хүлээнэ:

3.1. Зуучлагчид түүний үүргээр биелүүлэхэд нь шаардагдах бүхий л мэдээлэл, баримт бичиг, түүний дотор Зуучлагчийн шаардлагаар байгаа барааны тухай агуулахын баримтыг гаргаж өгөх.

3.2. Гэрээний нөхцөлд заасан ёсоор Зуучлагчид зохих хөлс төлөх.

4. Гэрээний хугацаа

4.1. Энэ гэрээ _____ оны _____-р сарын ____ - ээс _____ оны _____-р сарын _____ хүртэл хүчинтэй болно.

5. Зуучдагчид төлөх хөлс, тооцоо хийх журам

5.1. Зуучлагч үйлчилгээ үзүүлсний төлөө дор дурьдсан хэмжээ, журмаар хөлс авна.

5.2. Нэгдүгээр шатны үүргээ биелүүлсний төлөө _____ төгрөгийн хөлс авна. Хөлс төлөх үндэслэл нь Худалдан авагч олж, мэдээлэл хүлээлгэн өгөх, хүлээн авах актан д гарын үсэг зурсан явдал болно. Төлбөрийг мэдээлэл хүлээлгэн өгөх, хүлээн авах актан д гарын үсэг зурсанаас хойш _____ хоногийн дотор төлнө.

5.3. 2-р шатны үүргээ биелүүлсний төлөө:

- Хэлцлийн үнийн дүнгийн _____ хувьтай тэнцэх хэмжээний хөлс авна. Энэ төлбөрийг төлөх үндэслэл нь талуудын хооронд гэрээнд гарын үсэг зурагдсан явдал байх болно. Төлбөрийг гэрээнд гарын үсэг зураснаас хойш _____ хоногийн дотор төлнө. (Зуучлагч Захиалагчийн тогтоосон үнэ, Зуучлагчийн дэмжлэгтэйгээр олсон Худалдан авагчийн худалдан авсан үнэ хоёрын хоорондох зөрүүгийн хэмжээгээр төлбөр авч болно.) Төлбөр төлөх өөр үндэслэл, журам тогтоож болно. Үүнд:

а) Төлбөрийг Зуучлагч зөвхөн 1, 2-р шатны үүргээ бүхэлд нь биелүүсний дараа буюу Захиалагч, Худалдан авагч хоёрын хооронд гэрээ байгуулсан нөхцөлд төлж болно.

б) Төлбөрийг Захиалагчийн бүтээгдэхүүний үнийг Худалдан авагч төлсөний дараа буюу Худалдан авагчаас Захиалагчийн харилцах дансанд зохих мөнгө орж ирсэн нөхцөлд төлж болно.

6. Талуудын хариуцлага

6.1. Зуучлагч энэ гэрээгээр доорхи хариуцлага хүлээнэ:

а) Мэдээлэл өгөх хугацаа хожимдуулсан бол _____ төгрөгийг торгууль,

б) Гэрээний бусад үүргийг зөрчсөний төлөө _____ төгрөгийг торгууль,

6.2. Захиалагч энэ гэрээгээр доорхи хариуцлага хүлээнэ:

а) Төлбөр төлөх хугацааг хожимдуулсан бол төлөх төлбөрийн дүнгийн _____ хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр,

б) Энэ гэрээг хугацаанаас нь өмнө цуцласан бол, тэрчлэн энэ гэрээний 2-д дурьдсан хугацаанд Захиалагчийн шилжүүлэн өгсөн мэдээллийг хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзсан бол _____ төгрөгийн торгууль.

6.3. Зуучлагч нь Захиалагч Худалдан авагч хоёрын хооронд байгуулсан гэрээ биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээхгүй.

7. Энэ гэрээгээр Зуучлагчид зориулсан баталгаа

7.1. Зуучлагч нь Захиалагчийн даалгаварыг биелүүлэх онцгой эрх эдлэнэ. Захиалагч нь Зуучлагчид даалгасан асуудлаар өөр хэнтэй ч тийм гэрээ байгуулахгүй.

7.2. Захиалагч нь энэ гэрээний 1-р хавсралтанд дурьдсан эд юмыг худалдах, худалдан авах гэрээ нь уг гэрээний үйлчлэх хугацааны дотор байгуулах бол түүнийг Зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулагдсанд тооцно. Энэ тохиолдолд Зуучлагч зохих шагналыг маргаангүй авна.

8. Энэ гэрээний бусад нөхцөл

8.1. Талуудын хууль ёсны хаяг, банкны харилцах данс, гарын үсэг.

Захиалагч:

Хаяг: _____
Утас: _____ факс: _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Зуучлагч:

Хаяг: _____

Утас: _____ факс: _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Захиалагч :

Зуучлагч:

:

(гарын үсэг)
тэмдэг

(гарын үсэг)
тэмдэг

КОМИССИЙН ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас “Комисс” _____ түүнийг _____

үндсэн дээр төлөөлөн _____ (аж ахуйн нэгжийн нэр) _____ (итгэмжлэл)
_____,
нөгөө талаас “үйлчлүүлэгч” _____ (албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)
түүнийг _____ (аж ахуйн нэгж, иргэний нэр) үндсэн дээр төлөөлөн _____
_____, (албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)
нар доорх гэрээг байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Комисс үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс түүний эрх ашиг, шаардлагад нийцүүлэн, гуравдагч этгээдийн зардлаар _____ барааг _____ төгрөгөөр борлуулах, эрх хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулна.

1.2. Үйлчлүүлэгч нь барааг ____ оны ____ дугаар сарын ____ -ны өдрөөс эхлэн харилцан тохиролцож нийт үнийн _____ хувиар бодож борлуулсан тохиолдолд шимтгэлийг комисст төлнө. Комисс тухайн барааг борлуулж олсон ашгаа үйлчлүүлэгчид төлнө.

2. Комиссийн эрх, үүрэг

2.1. Комисс доор дурдсан үүргийг хүлээнэ.

2.1.1. Худалдан авагчтай өөрийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах,

2.1.2. Шаардлагатай гэж үзвэл үйлчлүүлэгчийг худалдан авагчтай хэлэлцээ хийхэд байлцуулах

2.1.3. Комисс үйлчлүүлэгчид ашигтай нөхцөлөөр хэлцэл байгуулах үүрэгтэй.

2.2. Комисс үйлчлүүлэгчийг шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

2.3. Үйлчлүүлэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд комисс нь хөлс, шагнал шаардах эрхтэй.

2.4. Комисс даалгаврыг биелүүлж дууссаны талаар тайланг холбогдох бүх материалын хамт үйлчлүүлэгчид хүлээлгэн өгнө.

2.5. Худалдагдсан эд зүйлийн үнийг хүлээж авснаас хойш _____ хоногийн дотор үйлчлүүлэгчид комисст суутгах шимтгэлийг авч шилжүүлнэ.

2.6. Комисс барааг үйлчлүүлэгчийн тогтоосон үнээс өөр үнээр худалдах тохиолдолд үйлчлүүлэгчид даруй мэдэгдэнэ.

3. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

3.1. Комисст хугацаатай даалгаврыг өгөх үүрэгтэй.

3.2. Гуравдагч этгээдийн өмнө комиссийн үүрэг хүлээнэ.

3.3. Даалгавар гүйцэтгэхийн тулд гаргасан зардлыг комисст нөхөн төлнө.

3.4. Үйлчлүүлэгч барааг борлуулсан тохиолдолд үнийн дүнгийн _____ хувийг шагнал болгож өгөх.

3.5. Комиссийн явцыг тухай бүр шалгаж үзэх эрхтэй.

4. Талуудын хариуцлага

4.1. Гэрээ болон түүнтэй холбогдох асуудлаар гарсан маргааныг талууд хэлэлцэн тохиролцоно.

4.2. Хэрэв талууд хэлэлцээний замаар маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл хуулийн дагуу (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

5. Бусад заалт

- 5.1. Гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 5.2. Талууд харилцан үүргээ бүрэн биелүүлж дууссан буюу тооцоог хийж гүйцэтгэснээр гэрээ дуусгавар болно.
- 5.3. Гэрээнд өөрчлөлт, нэмэлт оруулахдаа талууд харилцан тохиролцож бичгээр үйлдэнэ.
- 5.4. Гэрээг хоёр хувь үйлдэж талууд тус нэг нэг хувийг хадгална.

6. Талуудын хаяг

Комисс:

Үйлчлүүлэгч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Энэхүү гэрээг нэг талаас Зээл өгөгч _____ хотын (аймгийн)
_____ дүүргийн (сумын) _____ хорооны (багийн) _____ тоот

иргэний үнэмлэхтэй _____ -ийн _____, нөгөө талаас
Зээл авагч _____ хотын (аймгийн) _____ дүүргийн
(сумын) _____ хорооны (багийн) _____ тоот иргэний үнэмлэхтэй
_____ -ийн _____ нар харилцан тохиролцож, Монгол
улсын Иргэний хуулийн 281-285 дугаар зүйлүүдийг үндэслэн дараахь
нөхцөлтэйгээр байгуулав.

1. Зээл өгөгч нь _____ (төгрөг, доллар, юань, рубль, евро) -г
200_ оны __ сарын __ өдөр зээл авагчид 200_ оны __ сарын __ өдөр хүртэл
_____ хугацаатайгаар зээлдүүлж байна.
2. Зээл авагч нь авсан зээл болох _____ (төгрөг, доллар, юань,
рубль, евро)-д _____ (сар, жил) бүр _____ хувийн хүү төлнө.
3. Энэхүү гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахын тулд барьцааны зүйл болгон
_____ эд хөрөнгийг барьцаанд авав. (барьцааны
эд хөрөнгийн жагсаалтыг хавсаргав. Хавсралт нь энэ гэрээний салшгүй хэсэг
болно) Жич: энэ хэсгийг зөвхөн барьцаатай зээлийн гэрээнд хэрэглэнэ.
4. Зээл авагч тал энэ гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ, хүүгийн хамт
төлөх үүрэгтэй.
5. Гэрээнд заасан хугацаанд зээлийг хүүгийн хамт төлөөгүй тохиолдолд
хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөөгүй үлдсэн мөнгөний үнийн дүнгийн
_____ хувиар бодож алдангийг зээл өгөгчид төлөх үүрэгтэй.
6. Зээл авагч тал авсан зээлээ хугацаандаа буцаан төлөөгүй тохиолдолд
гэрээний хугацаа дууссанаас хойш _____ хоног өнгөрмөгц Зээл өгөгч нь
барьцаанд авсан хөрөнгийг захиран зарцуулж, түүний үнийн дүнгээс үндсэн
зээл, хүү, алданги, хохирлоо гаргаж авах эрхтэй.
7. Барьцааны эд хөрөнгийг борлуулж энэ гэрээний 6-д заасан төлбөрийг
барагдуулж дуусаад мөнгө үлдэх тохиолдолд зээл авагчид буцаан өгөх
үүргийг зээл өгөгч хүлээнэ. Барьцааны эд хөрөнгийг худалдахад зээл өгөгч
хамт байхыг шаардах эрхтэй.
8. Энэ гэрээтэй холбоотой маргааныг (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ
(доогуур нь зур).
9. Зээл өгөгч гэрээнд заасан мөнгийг зээл авагчид шилжүүлэн өгснөөр энэхүү
гэрээг байгуулсанд тооцно.
10. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд гарын үсэг зуран нэг нэг хувийг хадгална.

Гэрээний тал:

Зээл өгөгч:

Эцэг/эх/-ийн нэр _____ нэр _____ оршин суугаа хаяг
_____ утас
_____ иргэний үнэмлэхийн дугаар _____ регистрийн
дугаар _____ Банкны харилцах данс _____
Гарын үсэг _____

Зээл авагч:

Эцэг/эх/-ийн нэр _____ нэр _____ оршин суугаа хаяг
_____ утас
_____ иргэний үнэмлэхийн дугаар _____
регистрийн дугаар _____ Банкны харилцах данс _____
Гарын үсэг _____

АГУУЛАХАД ЭД ХӨРӨНГӨ ХАДГАЛУУЛАХ ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____

(иргэн, хуулийн этгээдийн нэр)
(цаашид “хадгалуулагч” гэх)-ийг _____ үндсэн дээр
(дүрэм, итгэмжлэлийн)
төлөөлж _____ ажилтай _____,
нөгөө талаас _____ (цаашид “хадгалагч гэх”)-ийг
(иргэн, хуулийн этгээдийн нэр)
_____ үндсэн дээр төлөөлж _____
(дүрэм, итгэмжлэлийн)

ажилтай _____ нар харилцан тохиролцож, Монгол улсын Иргэний хуулийн 428-430 дугаар зүйлийг үндэслэн гэрээг дараахь нөхцөлтэйгээр байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Хадгалуулагч гэрээнд заасан эд хөрөнгийг хадгалуулагчид хүлээлгэн өгнө.

1.2. Хадгалах эд хөрөнгийн тухай өгөгдөл:

1.2.1. Эд хөрөнгийн товч тодорхойлолт: _____

Эд хөрөнгийн тоо, хэмжээ, жин, өнгө, чанар, боодлын тодорхойлолт

Эд хөрөнгийн зарласан үнэ _____

1.3. Хадгалах газар: хаяг _____

1.4. Хадгалах нөхцөл: Дулааны хэмжээ _____ чийглэг _____ хувь

1.5. Хадгалуулагч эд хөрөнгөө хадгалах газар хүлээлгэн өгөх хугацаа: _____ он _____ сар _____ өдөр

1.6. Хадгалуулагчийн төлөөлөгч эд хөрөнгө хадгалах цэгт очих цаг _____

1.7. Хадгалуулагч хадгалуулсан эд хөрөнгөө буцаан авах хугацаа: _____ он _____ сар _____ өдөр (график)

2. Эд хөрөнгийг хадгалахаар хүлээн авах, хадгалах, буцаан өгөх журам

2.1. Хадгалуулагч _____ (нотлох баримт бичгийн нэр) -ийг үзүүлсэн тохиолдолд Хадгалагч гэрээнд заасан эд хөрөнгийг хүлээн авна.

2.2. Эд хөрөнгийг хадгалахаар хүлээн авах, буцаан өгөх үед ачих, буулгахад хадгалагч тал _____

үүрэг гүйцэтгэнэ. Хадгалуулагч тал _____ үүрэг хүлээнэ.

2.3. Хадгалагч эд хөрөнгийг хадгалахаар хүлээн авмагц хадгалуулагчид агуулахын баримт олгоно. Агуулахын баримтад (олгосон огноо, бүртгэлийн дугаар, гэрээний талуудын нэр хаяг, эд хөрөнгийг хадгалах газар, хадгалах эд хөрөнгийн тоо, хэмжээ, жин, өнгө, чанар, боодлын тодорхойлолт, хадгалалтын хөлс, бусад зайлшгүй зардлын хэмжээ, эд хөрөнгийг даатгах бол даатгалын үнэ, гэрээний хугацаа, хадгалагчийн гарын үсэг, тамга, тэмдэг) шаардлагатай зүйлийг заавал тусгана.

2.4. Хадгалуулагч агуулахын баримт бичгийн үндсэн дээр эд хөрөнгөө буцаан авах бөгөөд хадгалагч энэ баримтыг үндэслэн хадгалсан эд хөрөнгийг буцаан өгнө.

2.5. Хадгалуулагч хүсвэл эд хөрөнгө болон түүний баглаа боодлыг ломбодож болох бөгөөд энэ тохиолдолд ломбоны зураг, ломбодсон аргыг бичиж гэрээнд хавсаргана.

3. Талуудын эрх, үүрэг

- 3.1. Хадгалагч энэ гэрээний 1.4-д заасан хадгалах нөхцөлийг сахиж биелүүлнэ.
- 3.2. Хадгалуулагчийн төлөөлөгч эд хөрөнгөө үзэж, хянахын тулд хадгалсан газарт орох, бараагаа буцаан авах боломжоор хангах үүргийг хадгалагч тал хүлээнэ.
- 3.3. Эд хөрөнгийг хадгалж байх үед талуудын аль нэг нь эд хөрөнгө, түүний баглаа боодол, ломбо эвдэрч гэмтсэн, эсвэл үгүй болсныг илрүүлбэл энэ тухай нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Бараа үгүй болсон үед хоёр тал хамтран акт үйлдэж үгүй болсон эд хөрөнгө, түүний үнийг тогтоон тодорхойлно. Хадгалагч эд хөрөнгө үгүй болсон тухай акт бичигдсэн өдрөөс хойш ___ хоногийн дотор уг үгүй болсноос болж учирсан хохирол, түүний дотор олох ёстой байсан орлогыг хадгалуулагчид төлж өгнө.
- 3.4. Хадгалагч эд хөрөнгөнд ямар нэгэн гаж буруу (эвгүй үнэр, радио идэвхийн нөлөөлөл г.м) байдал байгааг илрүүлбэл энэ тухай хадгалуулагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд мэдэгдсэн тухай баримтыг өөртөө авч үлдэнэ. Хэрэв хадгалуулагч илэрч буй гаж буруу байдлыг арилгах боломжгүйн дээр хадгалагч шаардаж байгаа нөхцөлд дээрхи мэдэгдлийг хүлээн авснаас хойш ...хоногийн дотор уг эд хөрөнгийг хадгалсан газраас зайлуулах үүрэг хүлээнэ. Энэ нөхцөлийг хадгалуулагч биелүүлэхгүй тохиолдолд хадгалагч дангаар уг эд хөрөнгийг хадгалсан газраас зайлуулж, энэ тухайгаа хадгалуулагчид мэдэгдэх эрхтэй. Ийм тохиолдолд гэрээ хүчингүй болсонд тооцогдох бөгөөд хадгалагч барааны бүрэн бус байдлын төлөө хариуцлага хүлээхгүй.
- 3.5. Иргэний хуулийн зүйл 429.6–429.10-т зааснаар хадгалагч зөвшөөрсөн бол хадгалуулагч агуулахын баримтыг бичилт хийж гуравдагч этгээдэд шилжүүлж болно.
- 3.6. Хэрэв хууль хяналтын болон захиргааны байгууллагаас хадгалалтад байгаа эд хөрөнгийн баглаа, лац ломбо тогтоосон журам зөрчиж байгаатай холбогдуулан үзлэг, шалгалт хийх шаардлага тавивал, хадгалагч энэ тухай хадгалуулагчид нэн даруй мэдэгдэнэ.

4. Тооцоо хийх журам

- 4.1. Хадгалуулагч эд хөрөнгийг хадгалуулсны хөлсөнд хадгалагчид _____ төгрөгийн хөлс төлнө.
- 4.2. Төлөх хугацаа: _____ он _____ сар _____ өдөр
- 4.3. Төлбөр төлөх хэлбэр: Хадгалагчийн _____ банкны _____ салбар дахь _____ тоот дансанд шилжүүлэх эсвэл бэлнээр төлөх (доогуур нь зурах)
- 4.4. Энэ гэрээний 4.2-т заасан төлбөр төлөх хугацааг хожимдуулсан тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн _____ хувьтай тэнцэх алданги төлнө (хоногт тооцох алдангийн хэмжээ 0.5 хувиас хэтрэхгүй байна).
- 4.5. Хадгалуулагч гэрээгээр тохирсон хугацаанд эд хөрөнгөө буцаан авах үед хадгалагчийн буруутайгаас эд хөрөнгөө авч чадаагүй хугацаа хожимдсон бол учирсан хохирлоо төлүүлэхээр шаардах эрхтэй.
- 4.6. Эд хөрөнгийн хадгалалттай холбогдон үүссэн зардлыг төлүүлэхээр Иргэний хуулийн зүйл 429.17-т зааснаар хадгалагч тухайн эд хөрөнгийг барьцаалах эрхтэй.

5. Бусад нөхцөл

- 5.1. Хэрэв гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас хадгалж буй эд хөрөнгө үгүй болсон буюу чанар нь дордсон тохиолдолд хадгалагч уг хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөнө.

5.2. Хадгалалтын гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө, хугацаа тогтоогоогүй бол эд хөрөнгө хадгалуулахаар шилжүүлсэн өдрөөс эхлэн гурван сарын дотор хадгалагч эд хөрөнгөө буцаан авахыг хадгалуулагчаас шаардах эрхгүй.

5.3. Хадгалалтын хугацаа дуусгавар болсны дараа агуулахын бичиг баримт эзэмшигч буюу хадгалуулагч нь эд хөрөнгийг агуулахаас гаргах арга хэмжээ авахгүй бол хадгалагч түүнд 14 хоногийн нэмэлт хугацаа олгох бөгөөд энэ хугацаанд эд хөрөнгийг буцаан авахгүй бол хадгалагч түүнийг худалдах эрхтэй.

5.4. Дээрхи эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хадгалалтын явцад гарсан зайлшгүй зардал, хөлсийг хасаж, үлдсэн хэсгийг хадгалуулагчид шилжүүлнэ.

5.5. Энэ гэрээтэй холбогдох маргааныг талууд эвлэрлийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд ингэж шийдвэрлэж чадаагүй нөхцөлд (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

5.6. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэх бөгөөд энэ нь бичгийн хэлбэрээр илэрхийлэгдэн гарсан байна.

5.7. Энэхүү гэрээ талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээг 2 хувь үйлдэж, талууд нэг нэг хувийг хадгална.

6. Гэрээний хавсралт

6.1. Хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.

6.2. Хавсралт № _____ хуудас.

6.3. Хавсралт № _____ хуудас.

Хавсралтыг үйлдсэн _____ он ___ сар ___ өдөр

7. Талуудын хаяг

Хадгалагч:

Хаяг, индекс: _____

Утас: _____

Факс: _____

Цахилгаан шуудангийн хаяг: _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Гарын үсэг _____

Тэмдэг

Хадгалуулагч:

Хаяг, индекс: _____

Утас: _____

Факс: _____

Цахилгаан шуудангийн хаяг: _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Гарын үсэг _____

Тэмдэг

ДААЛГАВРЫН ГЭРЭЭ (хууль зүйн туслалцаа үзүүлэх)

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____ (цаашид

(хуулийн этгээдийн нэр, иргэний эцэг/эх/-ийн нэр, нэр)

“итгэмжлэгч” гэнэ) -ийг _____ баримт бичгийн үндсэн дээр _____
ажилтай _____ -ийн _____ төлөөлөн, нөгөө
талаас _____ (цаашид
(хуулийн этгээдийн нэр, иргэний эцэг/эх/-ийн нэр, нэр)

“итгэмжлэгдэгч” гэнэ)-ийг _____ баримт бичгийн үндсэн дээр _____
ажилтай _____ -ийн _____ нар төлөөлөн энэхүү
гэрээг Монгол улсын Иргэний хуулийн 399-405 дугаар зүйлийг үндэслэн дараахь
нөхцөлтэйгээр харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Энэхүү гэрээгээр итгэмжлэгдэгч нь итгэмжлэгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар хууль зүйн дараахь үйлдлийг гүйцэтгэнэ. Үүнд:

(гүйцэтгэх хууль зүйн үйлдлийг жагсааж бичнэ үү)

1.2. Гэрээгээр тохиролцсон хууль зүйн үйлдлийг хийсний төлбөрт _____
төгрөгийн хөлс олгоно.

1.3. Хөлсний _____ хувийг энэ гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш
_____ хоногийн дотор, үлдэх _____ хувийг энэ гэрээ дуусгавар болоход гэрээний
үүргийн биелэлтийг талууд дүгнэснээс хойш _____ хоногийн дотор олгоно. Энэ
хугацаанд олгоогүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөөгүй үлдсэн
хөлсний үнийн дүнгийн _____ хувиар алданги төлнө.

2. Итгэмжлэгдэгчийн эрх, үүрэг

2.1. Итгэмжлэгдэгч нь итгэмжлэгчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

2.2. Итгэмжлэгдэгч нь даалгаврыг гүйцэтгэхдээ итгэмжлэгчийн өгсөн зааврын дагуу гүйцэтгэх үүрэгтэй.

2.3. Итгэмжлэгчийн ашиг сонирхлын үүднээс түүний өгсөн зааврыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ талаар урьдчилан мэдэгдэх боломжгүй байсан, эсхүл мэдэгдсэн боловч _____ хугацаанд хариу аваагүй бол итгэмжлэгдэгч уг зааврыг өөрчлөх эрхтэй.

2.4. Итгэмжлэгдэгч нь итгэмжлэгчийн шаардлагаар гүйцэтгэж байгаа ажлын явцын талаар мэдээлэх, үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан түүнээс хүлээж авсан бүх зүйлийг нэн даруй буцааж өгөх үүрэгтэй.

2.5. Шаардлагатай тохиолдолд даалгавар биелүүлэх ажиллагаанд итгэмжлэгчийг оролцуулна.

2.6. Гэрээгээр тохирсон хөлс, даалгавар гүйцэтгэхэд гарах зайлшгүй зардал, гэрээний үүргийг биелүүлэхтэй холбоотой мэдээ, материал, бусад баримтыг итгэмжлэгчээс шаардах эрхтэй.

3. Итгэмжлэгчийн эрх, үүрэг

3.1. Итгэмжлэгч нь өгсөн даалгаврынхаа гүйцэтгэлийг хугацаанд нь хүлээн авах, даалгавар гүйцэтгэхтэй холбогдох өөрөөс хамааралтай мэдээ, материал, бусад баримт, зардлыг итгэмжлэгдэгчид хугацаанд нь өгөх үүрэгтэй.

3.2. Гэрээнд заасан хөлсийг итгэмжлэгдэгчид төлнө.

3.3. Итгэмжлэгдэгчийн явуулж байгаа үйл ажиллагаатай танилцах, зааварчилгаа өгөх, өөрчлөх эрхтэй.

3.4. Итгэмжлэгдэгчийн явуулж байгаа үйл ажиллагаанд даалгавар өгөгч биечлэн оролцох шаардлагатай тохиолдолд өөрөө биечлэн эсвэл боломжгүй үед өөрийн төлөөлөгчийг оролцуулах үүрэгтэй.

4. Бусад заалт

4.1. Энэ гэрээ талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээг дүгнэх хүртэл (даалгавар биелүүлэх, талуудын тооцоо хийх) бүх хугацааны турш үйлчилнэ.

4.2. Гэрээг 2 хувь үйлдэж талууд нэг нэг хувийг хадгална.

4.3. Итгэмжлэгч өгсөн даалгавраа цуцалсан, итгэмжлэгдэгч нь даалгавар биелүүлэхээс татгалзах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд Иргэний хуулийн 402-р зүйлд зааснаар нэг тал нөгөө талдаа учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

4.4. Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарвал талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

5. Талуудын хаяг:

Итгэмжлэгч:

Хаяг, индекс: _____

Утас: _____

Факс: _____

Цахилгаан шуудангийн хаяг: _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Гарын үсэг _____

Тэмдэг

Итгэмжлэгдэгч:

Хаяг, индекс: _____

Утас: _____

Факс: _____

Цахилгаан шуудангийн хаяг: _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Гарын үсэг _____

Тэмдэг

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

(хувь хүмүүсийн хоорондох гэрээ)

№

_____ (хот, аймаг)
_____ (сум, дүүрэг)

200_ оны__ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____ ажилтай _____
(үйлдвэр, байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, хаяг) (эцгийн/эхийн нэр)

_____ (цаашид "А тал" гэнэ), нөгөө талаас _____
(нэр) (хууль зүйн товчоо, компанийн нэр)
ажилтай _____ (цаашид "Б тал"
гэнэ),
(эцгийн/эхийн нэр) (нэр)

бид дор дурьдсан гэрээг байгуулав. Үүнд:

1. Гэрээний зүйл

1.1. Энэхүү гэрээгээр Б тал нь А талын нэрийн өмнөөс, түүний зардлаар хууль зүйн үйлчилгээ үзүүлнэ. Хууль зүйн үйлчилгээний жагсаалтыг энэ гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон 1-р хавсралтаар батлана.

1.2. Гэрээгээр тохиролцсон хууль зүйн үйлдлийг хийсний дараа төлбөрт _____ (төгрөг, ам.доллар)-н хөлс олгоно.

2. Төлбөр хийх журам

2.1. Хийсэн ажлыг хүлээлгэн өгч, хүлээн авсан тухай актанд хоёр талын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурснаас хойш _____ хоногийг дотор А тал нь төлбөрийг Б талд төлнө.

2.2. Гэрээгээр тохиролцсон хууль зүйн үйлдэлтэй холбоотой гарсан нэмэлт зардлыг санхүүгийн баримтыг үндэслэн Б талд төлнө.

3. Талуудын үүрэг

3.1. Талууд үйлчилгээг хийж дууссанаас хойш _____ хоногийн дотор түүнийг хүлээлгэн өгч, хүлээн авсан тухай акт үйлдсэн гарын үсэг зурах бөгөөд энэ тухай гүйцэтгэгч захиалагчид амаар буюу бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

3.2. Талууд энэ гэрээг биелүүлэх явцад иргэний болон эрх зүйн маргаанд хамаарагдах асуудлаар бие биедээ өгсөн зөвлөмжийг анхааралдаа авч ажиллана.

3.3. А талын даалагавараар Б тал энэ гэрээнд болон түүний хавсралтад дурьдсан нөхцөлд тайлбар хийсэн, нэмэлт төлбөр төлсний үндсэн дээр нэмэлт ажил хийж болно.

4. Гэрээний хариуцлага

4.1. Хэрэв А тал нь Б талд зохих төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол хугацаа хожимдуулсан өдөр бүр _____ төгрөгийн торгууль гүйцэтгэгчид төлөх бөгөөд гэхдээ уг торгууль нь нийт төлбөрийн хэмжээнээс хэтэрч болохгүй.

4.2. Хэрэв А тал ажил хүлээлгэн өгч, хүлээн авсан тухай актанд гарын үсэг зурахаас үндэслэлгүйгээр татгалзвал, түүний төлбөр төлөх хугацаа хожимдуулсны нэг адилаар үзэж энэ зүйлд заасан торгууль төлөх болно.

4.3. Талууд энэ гэрээний үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бусад тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

5. Бусад нөхцөл

5.1. Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.2. Энэ гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг

хадгална. Гэрээг нотариатаар баталгаажуулна.

5.3. Гэрээний үүрэг бүрэн биелж, холбогдох тооцоог хийж дуусмагц гэрээний үйлчилгээ дуусна.

6. Талуудын хууль ёсны хаяг

А тал:

Хаяг, индекс:

Утас _____

Факс: _____

Мэйл хаяг: _____

Банкны харилцах дансны дугаар:

Гарын үсэг

Тэмдэг

Б тал:

Хаяг, индекс:

Утас _____

Факс: _____

Цахилгаан шуудангийн хаяг:

Банкны харилцах дансны дугаар:

Гарын үсэг

Тэмдэг

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ (хуулийн этгээдийн хоорондох гэрээ)

№

Энэхүү гэрээг 200 ____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр
_____ д нэг талаас _____

(хот, аймаг) _____ (улс, мужийн нэр)
улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан _____
тоот гэрчилгээтэй _____ (цаашид “А
тал” гэнэ),

(байгуулага, аж ахуйн нэгжийн албан ёсны нэр)
нөгөө талаас Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан
_____ тоот гэрчилгээтэй

_____ (байгуулага, аж ахуйн нэгжийн албан ёсны нэр)
(цаашид “Б тал” гэнэ) энэхүү гэрээг байгуулж байна.

Энэхүү гэрээгээр А талын эрх, ашиг сонирхолын дагуу Б тал хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр талын харилцан зөвшилцөл, бие биенийхээ өмнө өгсөн үүрэг амлалтыг бататган талууд дараахь нөхцөлтэйгээр энэхүү гэрээг харилцан тохиролцож байгуулав

1. Гэрээний зүйл

1.1. Энэхүү гэрээгээр Б тал нь А талын нэрийн өмнөөс, түүний зардлаар хууль зүйн үйлчилгээ үзүүлнэ. Хууль зүйн үйлчилгээний жагсаалтыг энэ гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон 1-р хавсралтаар батлана.

1.2. Гэрээгээр тохиролцсон хууль зүйн үйлдлийг хийсний дараа төлбөрт сард _____ (төгрөг, ам.доллар)-н хөлс олгоно. Хөлсийг сар бүрийн _____-ны өдөр олгоно.

1.3. Шүүхэд иргэний нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох тохиолдолд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд тухай бүр гэрээ байгуулж хөлсийг тохирно.

2. Төлбөр хийх журам

2.1. Хийсэн ажлыг хүлээлгэн өгч, хүлээн авсан тухай актанд хоёр талын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурснаас хойш _____ хоногийг дотор А тал нь төлбөрийг Б талд төлнө.

2.2. Гэрээгээр тохиролцсон хууль зүйн үйлдэлтэй холбоотой гарсан нэмэлт зардлыг санхүүгийн баримтыг үндэслэн Б талд төлнө.

3. Талуудын үүрэг

А талын үүрэг

3.1. А тал нь өгсөн даалгаврынхаа гүйцэтгэлийг хугацаанд нь хүлээн авах, даалгавар гүйцэтгэхтэй холбогдох өөрөөс хамааралтай мэдээ, бусад баримт, зардлыг Б талд хугацаанд нь өгөх үүрэгтэй.

3.2. Гэрээнд заасан хөлсийг Б талд төлнө.

3.3. Б талын явуулж байгаа үйл ажиллагаатай танилцах, зөвлөгөө өгөх эрхтэй.

3.4. Б тал нь А талын шаардлагаар гүйцэтгэж байгаа ажлын явцын талаар мэдээлэх, үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан түүнээс хүлээж авсан бүх зүйлийг нэн даруй буцааж өгөх үүрэгтэй.

Б талын үүрэг

3.5. Б тал нь даалгаврыг гүйцэтгэхдээ А талын өгсөн зааврын дагуу гүйцэтгэх үүрэгтэй.

3.6. А талын даалагаварыг энэ гэрээнд болон түүний хавсралтад дурьдсан нөхцөлд тайлбар хийсэн, нэмэлт төлбөр төлсний үндсэн дээр нэмэлт ажил хийж болно

3.7. Б тал хууль зүйн үйлчилгээ хийж дууссанаас хойш _____ хоногийн дотор түүнийг хүлээлгэн өгч, хүлээн авсан тухай акт үйлдсэн гарын үсэг зурах бөгөөд энэ тухай А талд амаар буюу бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

3.8. А талын ашиг сонирхлын үүднээс түүний өгсөн зааврыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ талаар урьдчилан мэдэгдэх боломжгүй байсан, эсхүл мэдэгдсэн боловч _____(хоног, сар, жил)-ийн хугацаанд хариу аваагүй бол Б тал уг зааврыг өөрчлөх эрхтэй.

3.9. Шаардлагатай тохиолдолд даалгавар биелүүлэх ажиллагаанд А талыг оролцуулна.

4. Гэрээний хариуцлага

4.1. Хэрэв А тал нь Б талд зохих төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол хугацаа хожимдуулсан өдөр бүр _____ төгрөгийн торгууль гүйцэтгэгчид төлөх бөгөөд гэхдээ уг торгууль нь нийт төлбөрийн хэмжээнээс хэтэрч болохгүй.

4.2. Хэрэв А тал ажил хүлээлгэн өгч, хүлээн авсан тухай актанд гарын үсэг зурахаас үндэслэлгүйгээр татгалзвал, түүний төлбөр төлөх хугацаа хожимдуулсны нэг адилаар үзэж энэ зүйлд заасан торгууль төлөх болно.

4.3. Талууд энэ гэрээний үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бусад тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

5. Бусад нөхцөл

5.1. Талууд энэ гэрээг биелүүлэх явцад иргэний болон эрх зүйн маргаанд хамаарагдах асуудлаар бие биедээ өгсөн зөвлөмжийг анхааралдаа авч ажиллана. Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл шүүхээр шийдвэрлүүлнэ..

5.2. Энэ гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалана.

5.3. Энэ гэрээ талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээг дүгнэх хүртэл (гэрээний үүрэг биелүүл дуусах, талуудын тооцоо хийх) бүх хугацааны турш үйлчилнэ

6. Талуудын хууль ёсны хаяг

А тал:

Хаяг, индекс:

Утас _____

Факс: _____

Цахилгаан шуудангийн хаяг:

Банкны харилцах дансны дугаар:

Төлөөлж:

Б тал:

Хаяг, индекс:

Утас _____

Факс: _____

Цахилгаан шуудангийн хаяг:

Банкны харилцах дансны дугаар:

Төлөөлж:

(гарын үсэг зурж буй хүний эцгийн нэр,
нэр)

(албан тушаал)

Гарын үсэг
Тэмдэг

(гарын үсэг зурж буй хүний эцгийн
нэр, нэр)

(албан тушаал)

Гарын үсэг
Тэмдэг

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

№ ____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(цаашид “А” тал гэнэ), түүнийг төлөөлж _____
(төлөөлсөн хүний албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)

нөгөө талаас _____
(цаашид “Б” тал гэнэ), түүнийг төлөөлж _____
(төлөөлсөн хүний албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)

бид дараахь нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний талууд _____

чиглэлээр _____ хэлбэрээр
_____ хамтран ажиллана.

1.2. Хамтын үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой хөрөнгийн эх үүсвэрийг талууд дараахь байдлаар хариуцан гаргана (Хөрөнгийн төрөл хэмжээ, бэлэн болгох хугацаа зэргийг тодорхой заана):

- “А” тал
- “Б” тал

1.3. Хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг талууд дараахь байдлаар хариуцан зохион байгуулна (хийх ажлын чиглэл, төрөл, хийгдэх хугацааг заана):

- “А” тал
- “Б” тал

1.4. Гэрээний хугацаа _____ жил байна. Гэрээний хугацааг талууд тохиролцон сунгаж болно.

2. Хамтын ажиллагааны удирдлага, хяналт

2.1. Энэхүү гэрээний 1.1.-д заасан чиглэл хэлбэрийн хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг дараахь журмаар удирдан явуулна (дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно):

- “А” тал нь дангаар төлөөлөх
- “Б” тал нь дангаар төлөөлөх
- “А” болон “Б” талууд хамтран
- “А” болон “Б” талууд өөр этгээдийг томилох замаар

2.2. Хамтын ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлж буй тал хэрэгжүүлсэн ажлын үр дүн, хөрөнгө мөнгөний зарцуулалтыг _____ бүрийн хугацаанд тогтмол тайлагнах үүрэгтэй.

2.3. Гэрээний аль ч тал гэрээний хэрэгжилт, бусад талуудын гэрээний талаархи үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.

2.4. Гэрээний аль нэг тал бусад талын шаардсан үед хамтын ажиллагаатай холбоотой өөрийн хийсэн ажлын талаар тайлан тавих үүрэгтэй.

3. Эд хөрөнгө

3.1. Хамтын үйл ажиллагаатай холбоотой санаа, зардал, олсон орлого, өр, авлага, бусад зүйлс нь талуудын дараахь өмчлөлд байна (дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно):

- хамтран өмчлөх дундын өмчид
- хэсгээр өмчлөх дундын өмчид, дараахь хувь хэмжээгээр:

3.2. Үйл ажиллагааны орлогоос бий болсон орлогын өөрт ногдох хэсгийг талууд өөрийн үзэмжээр захиран зарцуулна.

3.3. Хамтын үйл ажиллагааг үргэлжлүүлэхтэй холбоотой гарах зардлыг талууд тухай бүр харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

3.4. Хамтын ажиллагаанд зориулан хуримтлуулсан хөрөнгө мөнгийг зөвхөн хамтын ажиллагааны зорилгод нийцүүлэн зарцуулна.

4. Хариуцлага

4.1. Хамтын үйл ажиллагааны үр дүн, алдагдал хохирол, бусад этгээдийн өмнө үүссэн хариуцлагыг талууд дараахь зарчмаар хариуцна:

(дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно)

- хувь тэнцүү хэмжээгээр хамтран хариуцна.
- хэсгээр өмчлөх хувь хэмжээний дагуу хариуцна.

4.2. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй үед нөгөө талдаа дараахь торгууль эсхүл алданги төлнө (дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно):

- үүргийн үнийн дүнгийн ___ хувийн торгууль төлнө.
- үүргийн гүйцэтгэлийг хожимдуулсан хоног тутам __ хувийн (0.5-аас ихгүй байх) алданги төлнө.

5. Бусад заалт

5.1. Талууд үйл ажиллагаандаа Монгол улсын Иргэний хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

5.2. Хамтын үйл ажиллагааны тайланг талууд жил тутам, явцын тухай шаардлагатай тохиолдолд хэлэлцэж байна.

5.3. Талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

6. Гэрээ хүчин төгөлдөр байх

6.1. Талууд гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хүчин төгөлдөр болно.

6.2. Гэрээг хуульд зааснаас бусад тохиолдолд талууд (дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно)

- харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.
- аль нэг тал нь ___ сарын өмнө урьдчилан мэдэгдэх замаар гэрээнээс татгалзаж болно. Энэ тохиолдолд тодорхой шалтгаан заагаагүй байж болно
- онцгой нөхцөл шалтгаан бий болсон үед гэрээний аль нэг тал _____ сарын өмнө мэдэгдэж гэрээнээс татгалзаж болно.

6.3. Талууд тохиролцвол гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7. Талуудын хаяг:

“А” тал:

“Б” тал:

Хаяг, индекс: _____

Хаяг, индекс: _____

Утас: _____
Факс: _____
Цахилгаан шуудангийн хаяг: _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Гарын үсэг _____

Тамга, тэмдэг

Утас: _____
Факс: _____
Цахилгаан шуудангийн хаяг: _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Гарын үсэг _____

Тамга, тэмдэг

АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

Тайлбар:

- Иргэний хуульд зааснаар ачаа тээвэрлэлтийн гэрээг дагалдах бичгийн хэлбэрээр байгуулна.

- Дагалдах бичгийг гурван хувь үйлдэж, талууд гарын үсгээ зурж эхний хувийг ачаа илгээгчид үлдээж, хоёр дахь хувийг ачаанд хавсаргаж, гурав дахь хувийг тээвэрлэгчид өгнө.
- Ачаа нь хэд хэдэн тээврийн хэрэгслээр, эсхүл өөр өөр төрөл буюу тодорхой хэсэгт хуваагдаж тээвэрлэгдэхээр бол тээвэрлэгч, ачаа илгээгч талууд ачааны төрөл, тээврийн хэрэгслийн тоогоор дагалдах бичиг үйлдэнэ.
- Дагалдах бичиггүй, түүнийг дутагдалтай үйлдсэн, эсхүл үрэгдүүлснээс үл хамааран Иргэний хуулийн холбогдох заалт тээвэрлэлтийн гэрээний агуулга, хүчинтэй байх нөхцөлд нэгэн адил хамаарна.
- Иргэний хуулиар (380-398 дугаар зүйлүүд) тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийг тодорхой нарийвчлан зохицуулсан байдгийг анхаарах хэрэгтэй.
- Дагалдах бичгийг зарим тохиолдолд барааны зарлагын падаан, ачааг тээвэрлэлтэд хүлээлгэн өгсөн бусад баримтаар орлуулах боломжтой.

Тээврийн дагалдах бичиг (ачаа тээвэрлэлтийн гэрээ)

1. дагалдах бичиг үйлдсэн газар, он, сар, өдөр
2. тээврийн хэрэгслийн нэр, төрөл, дугаар
3. ачаа илгээгчийн нэр, хаяг _____
4. тээвэрлэгчийн нэр, хаяг _____
5. ачааг тээвэрлэгчид шилжүүлэх он, сар, өдөр, газар _____
ачааг хүргэх газар _____
6. хүлээн авагчийн нэр, хаяг _____
7. ачааны болон сав, баглаа, боодлын ердийн нэр, түүнчлэн аюултай ачаа тээвэрлэх үед түүний нийтээр хүлээн зөвшөөрсөн тэмдэг, тэмдэглэгээ

8. тээвэрлэх ачааны тоо, хэмжээ, тэмдэг, дугаар:

9. ачааны жин буюу хэмжээний талаарх бусад тэмдэглэл _____
10. тээвэрлэлттэй холбогдсон зардал (тээврийн хөлс, нэмэлт зардал, гаалийн хураамж ба гэрээ байгуулснаас ачааг хүргэх хүртэл гарах бусад зардал)

11. бусад нөхцөл (тухайлбал, ачуулсан барааны нийт үнэ, тээвэрлэгчийн хариуцлагыг тодруулан зааж болно)

12. Шаардлагатай гэж үзвэл талууд дагалдах бичигт дараахь зүйлийг тусгаж болно:
 - 12.1. ачааг өөр тээврийн хэрэгсэлд шилжүүлэх, ачихыг хориглосон заалт
 - 12.2. тээвэрлүүлэгч хариуцах зардал

- 12.3. ачаа илгээх үед төлөх нэмэгдэл үнийн хэмжээ
- 12.4. ачааны өртөг, түүнийг дурдсан газарт хүргэх онцгой сонирхол
- 12.5. тээвэрлүүлэгчээс ачааг даатгуулах тухай тээвэрлэгчид өгсөн заалт
- 12.6. тээвэрлэлтийг дуусгахаар тохиролцсон хугацаа
- 12.7. тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн баримт бичгийн жагсаалт

Тээвэрлэгч:

Ачаа илгээгч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

ТЭЭВЭР ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

№

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____

(тээвэрлэгч байгууллагын нэр, хаяг)

(цаашид "Түрээслүүлэгч" гэнэ), түүнийг _____
_____ үндсэн дээр төлөөлөн _____

негөө талаас _____

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

(цаашид "Түрээслэгч" гэнэ), түүнийг _____
_____ үндсэн дээр төлөөлөн _____

(ачаа тээвэрлүүлэх байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)

_____ (төлөөлсөн хүний албан тушаал, нэр)
бид дор дурьдсан гэрээг байгуулав. Үүнд:

1. Тээвэрлэгч нь захиалагчийн захиалгын дагуу түүний хүссэн газарт (цэг)-т ачаа болон зорчигчийг тээдэрлэхэд зориулан өөртөө байгаа хөнгөн автомашиныг хүрэлцэхүйц хэмжээгээр гараж өгнө.

2. Тээвэрлэгч ачаа (зорчигч)-г тээвэрлүүлэх тухай захиалагийн захиалгыг хүлээн авмагц автомашин гаргаж өгөх, уул тээвэрлэлтийг хийх үүрэгтэй. Захиалгыг ачаа тээвэрлүүлэгч өөрөө буюу түүний эрх олгосноор бусад хүмүүс (байгууллага) гүйцэтгэж болно.

3. Захиалагч нь тээвэрлэгчид тээвэр хийсний хөлсөнд ачааны хэмжээ болон зорчигчдын тоог харгалзахгүйгээр нэг км бүрт _____ төрөг төлнө. Түүнээс гадна захиалагч захиалагчийн захиалгыг биелүүлэхийн тулд сул гүйсэн километрт гарсан зардал, ачаа ачих (буулгах) үед машин зогссон цаг тутамд _____ төгрөгийг тээвэрлэгчид төлнө. Захиалагч нь тээвэрлэгчид хэрэв тээвэрлэгч тээвэрлэлт экспедиторын нэмэлт үйлчилгээ тусалцаа (ачих буулгах ажил, ачаа тээврийн баримт бичиг үйлдэх, захиалагчийн итгэмжлэлийн үндсэн дээр ачааг хүлээн авах, хүлээлгэн өгөх зэрэг) үзүүлсэн бол тэдгээрийн хэмжээ шинж чанарыг харгалзан талууд тохирсон хэмжээгээр зохих хөлсийг төлнө.

4. Захиалагч нь тээврийн болон бусад ажлын хөлсийг тээвэрлэгчид тээвэр хийж буй сарын _____ өдрөөс хожимдуулахгүй төлнө.

5. Талууд гэрээний үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол дор дурьдсан журам, хэмжээгээр хариуцлага хүлээлгэнэ.

а) Тээвэрлэгч нь захиалагчийн захиалсан цагт автомашиныг өгч чадаагүй бол захиалагчид хожимдуулсан цаг тутамд _____ төгрөг, тэгэхдээ нэгэн тохиолдолд _____ төгрөгөөс хэтрүүлэхгүйгээр торгууль төлнө.

б) Тээвэрлэгч нь ачаа алдагдаж үрэгдсэн, дутагдсан, гэмтсэний төлбөрийг хууль тогтоомжинд заасан хэмжээгээр төлнө.

в) Захиалагч нь гэрээний 4-д дурьдсан тээврийн болон бусад үйлчилгээ тусалцааны хөлсийг төлөх хугацааг зөрчвөл тийнхүү хугацаа хожимдуулсны төлөө хууль тогтоомжинд зааснаар хариуцлага хүлээнэ.

6. Тээвэрлэгч нь зорчигчдын амь нас үрэгдэх, эрүүл мэндэд хохирол учирсны төлөө хууль тогтоомжинд заасан харуцлага хүлээнэ.

7. Талууд өөрсдийн хууль ёсны хаяг (оршин байгаа хаяг)-ын өөрчлөлтийг бие биедээ мэдэгдэж байна.

8. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Үйлчлэх хугацаа нь _____ оны ____-р саян _____ хүртэл байна.

9. Талууд хууль ёсны хаяг, банкны реквизитүүд, гарын үсэг, тэмдэг.

Тээвэрлэгч:

Хаяг: _____

Утас: _____ факс: _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Захиалагч:

Хаяг: _____

Утас _____ факс: _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Тээвэрлэгч:

Түнш:

(Гарын үсэг)
тэмдэг

(Гарын үсэг)
тэмдэг

ЭД ХӨРӨНГИЙН БҮРЭН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(байгууллагын нэр, хаяг)

түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн _____,
(төлөөлсөн хүний нэр, албан тушаал)

нөгөө талаас _____
хаягаар оршин суух _____ тоот иргэний үнэмлэхтэй _____
тоот регистрийн дугаартай _____ нар ажил
олгогч _____ байгууллагын
эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, ажилтан _____-ны
эд хөрөнгийн сахилгыг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Хөдөлмөрийн тухай
хуулийн 21, 135 дугаар зүйлийн 3, 4-т заасныг үндэслэн дор дурдсан нөхцөлөөр
энэхүү нэмэлт гэрээг хэлэлцэн байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь _____ байгууллагад
ажиллагч _____-д эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх
нэмэлт гэрээ бөгөөд 200_ оны __ сарын __-нд хэлэлцэн тохиролцсон
_____ тоот хөдөлмөрийн гэрээний салшгүй хэсэг мөн.

1.2. Эд хөрөнгийн хариуцлагын энэхүү гэрээ нь ажилтан _____,
ажил олгогч _____ нарын хооронд үүсэх эд хөрөнгийн
харилцаатай холбоо бүхий харилцааг зохицуулах үндэслэл бөгөөд гэрээнээс
үүссэн маргааныг зөвхөн шүүхээр зохицуулна.

1.3. Гэрээний хугацаа 200_ оны __ сарын __-нд хэлэлцэн тохирсон _____
тоот хөдөлмөрийн гэрээний _____ дугаар зүйлд зааснаар зохицуулагдана.

2. Ажил олгогчийн хүлээх үүрэг

2.1. Ажилтан _____-нд _____ жил ашигласан _____
төгрөгийн үнэ бүхий _____
эд зүйлийг _____ баримтаар хүлээлгэн өгч
түүнийг хэвийн байдлаар ашиглах, хамгаалахын тулд _____

гэх мэт зайлшгүй нөхцөлөөр хангана.

2.2. Ажилтан _____-нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай
хуулийн 135 дугаар зүйл, _____
журамд зааснаар хүлээн авсан эд хөрөнгийг ариг гамтай, зориулалтын дагуу
ашиглах, хадгалах, тээвэрлэх, захиран зарцуулах эрхтэй болохыг танилцуулна.

2.3. Ажилтан _____-нд албаны зориулалтаар хүлээлгэн
өгсөн _____ эд зүйлсийг
_____ хугацаанд тоолон бүртгэж, эд
хөрөнгийн бүртгэл (санхүүгийн), эд хариуцагч этгээдийн картад тусгана.(тоо
хэмжээ, чанар, элэгдэл хорогдол, үнийг нэг бүрчлэн дурдана)

2.4. Ажилтан _____-ны буруугаас хүлээлгэн өгсөн эд
зүйлс _____ байдлаар
дутагдах, үгүй болох тохиолдолд ажил олгогчид учруулсан _____

_____ хохирлыг
комиссийн акт, ажил олгогчийн тушаал гаргах журмаар нөхөн төлүүлнэ.

2.5. Бусад үүрэг _____

3. Ажилтны хүлээх үүрэг

3.1. _____ баримтаар албан ажлын зориулалтаар хүлээн авсан _____ эд зүйлсийг зориулалтын дагуу, ариг гамтай ашиглана.

3.2. Ажил олгогч _____-ны _____ зориулалтаар олгосон _____ эд зүйлсийг хадгалах, тээвэрлэх, ашиглах бусад тохиолдолд гарч буй дутагдал (зохисгүй тал), ашигтай байдлыг ажил олгогч этгээдийн төлөөлөгч _____-нд яаралтай мэдэгдэнэ.

3.3. Эд хөрөнгийн ашиглалтын талаархи Монгол Улсын хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

3.4. Ажил олгогч _____-аас _____ зориулалтаар олгосон _____ эд зүйлсийг тооллого, бүртгэлд үнэн зөвөөр бүртгүүлэх, эд зүйлсийн орлого, зарлага, элэгдэл, хорогдол, нэмэлт хөрөнгө оруулалтыг тухай тухайн үед нь эд хөрөнгийн бүртгэл тооцоонд тусгаж байна.

3.5. Хариуцсан эд зүйлийг тоолох, бүртгэхэд биечлэн оролцож, бүртгэсэн баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулна.

3.6. Өөрийн буруугаас ажил олгогчид учруулсан _____ хохирлыг бүрэн төлнө.

3.7. Байгалийн давагдашгүй хүчин зүйлс _____-ийн талаар ажил олгогчийн төлөөлөгчид яаралтай мэдэгдэх үүрэгтэй.

3.8. Ажилтны бусад үүрэг _____

4. Гэрээний бусад нөхцөл

4.1. _____ үндэслэлээр энэхүү гэрээнд _____ нэмэлт өөрчлөлт оруулав.

4.2. _____ нөхцөлд ажилтны эд хөрөнгийн хариуцлагаас _____ байдлаар чөлөөлөхөөр тохиролцов.

4.3. Ажил олгогчид учруулсан эд хөрөнгийн хохирлыг _____ хэлбэрээр нөхөн арилгана.

Гэрээ байгуулсан:

Ажил олгогч:

Ажилтан:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(иргэнийг хөлслөн авч ажиллуулах байгууллагын нэр)

түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн _____,
(төлөөлсөн хүний нэр, албан тушаал)

нөгөө талаас _____
хаягаар оршин суух _____ тоот иргэний үнэмлэхтэй _____ тоот
регистрийн дугаартай _____ нар
нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 21-24 дүгээр зүйлийг үндэслэн
200__ оны __ сарын __ -ны өдөр хэлэлцэн тохирч, энэхүү гэрээг дараахь
нөхцөлөөр байгуулж байна.

1. Гэрээний үндсэн нөхцөл

1.1. Эрхлэх ажил, албан тушаал _____

1.2. Ажиллах нэгж, хэсэг буюу ажил үүргээ гүйцэтгэх газар _____

1.3. Гүйцэтгэх үндсэн үүрэг _____
(ажлын ачаалал хэмжээ буюу _____)

ажил, албан тушаалын зааврыг нэрлэж болно)

1.4. Ажлын газрын байршил _____

1.5. Сарын үндсэн хөлсний хэмжээ _____

1.6. Төрийн хууль тогтоомжоор болон хамтын гэрээнд заасан нэмэгдэл хөлсний
хэмжээ _____

1.7. Хөдөлмөрийн нөхцөл _____

1.8. Ажлын нэг өдрийн буюу долоо хоногийн ажлын цаг _____

1.9. Хөдөлмөрийн гэрээний хугацаа _____

2. Гэрээний нэмэгдэл нөхцөл

2.1. Захиргааны зүгээс олгох боломжтой нэмэгдэл хөлсний (мэргэжлийн
зэргийн, ур чадварын, ахуй амьдралыг нь харгалзан олгох гэх мэт) хэмжээ _____

(сар тутам, улирал тутам, хагас, бүтэн жилийн алинд олгохоо зурах)

2.2. Хөдөлмөрийн гэрээний хугацаа сунгах тохиолдол _____

2.3. Сахилгын ноцтой зөрчилд тооцон хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах
тохиолдол _____

2.4. Захиргааны чөлөө олгох тохиолдол _____

2.5. Буцалтгүй тусламж олгох тохиолдол _____

2.6. Хоол, унааны зардалд өгөх нөхөх олговрын хэмжээ _____

2.7. Бусад _____

3. Захиргааны хүлээх үүрэг

3.1. Ажилтныг хөдөлмөрийн гэрээ байгуулсан үеэс нь гэрээнд заагдсан _____
ажлаар нь хангах, ажлын талаар зайлшгүй _____

(гүйцэтгэх ажил бүрийг нэг бүрчлэн дурдах)
шаардлагатай зааварчилга өгнө.

3.2. Ажилтан _____
үүргийг гүйцэтгэхийн тулд _____

(ажлын байрны ба бусад хэрэгслийг заана)

багаж хэрэгслээр хангана.

3.3. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгааг нь үндэслэн ажилтанд олгох ажлын хувцас _____, багаж _____, бие хамгаалах хэрэгслийг _____ нь шилжүүлнэ.

3.4. Ажилтныг хэвийн ажиллах нөхцөлөөр нь хангана _____

3.5. Хөдөлмөрийн үр дүнд тохирсон хөлс олгоно. _____

3.6. Ажилтны мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхэд туслана. _____

3.7. Ажилтныг өөр ажилд шилжүүлэх буюу байгуулсан гэрээг цуцлах асуудлыг зөвхөн хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

3.8. Ажилтан хуульд заасан эрхээ эдлэх, нийгмийн _____ баталгаагаар хангагдах бололцоогоор бүрдүүлнэ.

3.9. Ажилтныг нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамжийн асуудлын захиргаа бүрэн хариуцна.

4. Ажилтны хүлээх үүрэг

4.1. _____ байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ чанд биелүүлэхийн тулд _____

(юу хийх, яаж ажиллахыг нэг бүрчлэн заана)

ажиллана.

4.2. Ажил үүрэгтэй холбогдсон бүх шаардлагыг бүрэн хангаж, хариуцна.

4.3. Хөдөлмөр хамгааллын заавар, зааварчлагыг нарийн мөрдөнө.

4.4. Хамт олны уур амьсгалыг хэвийн байлгах, дэг журмыг хангахад анхаарч ажиллана.

4.5. Мэргэжил, ур чадвараа байнга дээшлүүлэн идэвх санаачлагатай ажиллана.

4.6. Энэхүү гэрээний 3.3-т заасан ёсоор олгосон хувцас, багаж, хэрэгслийг норм, ашиглах журмын дагуу эдэлнэ.

4.7. Ажилтан _____ буруугаас ажил олгогчид учруулсан эд хөрөнгийн хохирлыг Хөдөлмөрийн тухай хуулийн 135 дугаар зүйлд заасан үндэслэл, журмаар нөхөн төлнө.

4.8. Ажилтан өөрийн цалин хөлснөөс хуульд заасан журмын дагуу нийгмийн болон эрүүл мэндийн зохих шимтгэл төлнө.

5. Талуудын хүлээх хариуцлага

5.1. Захиргаа үүргээ биелүүлээгүйгээс ажилтанд учруулсан хохирлыг Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасны дагуу арилгана.

5.2. Энэхүү гэрээний 2.3-т заасан зөрчил гаргасан ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээ захиргаа хөдөлмөрийн тухай хуулийн дагуу цуцлана.

5.3. Сахилгын жижиг зөрчил гаргасан ажилтанд хөдөлмөрийн тухай хуульд заагдсан сахилгын шийтгэл ногдуулна.

Хөдөлмөрийн гэрээ байгуулсан:

Ажил олгогч:

Ажилтан:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

ХӨЛСӨӨР АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(байгууллагын нэр, хаяг)

түүнийг төлөөлөн _____,
(төлөөлсөн хүний нэр, албан тушаал)

нөгөө талаас _____
хаягаар оршин суух _____ тоот иргэний үнэмлэхтэй _____ тоот
регистрийн дугаартай _____ (цаашид
(хөлсөөр ажиллаж буй хүний овог, нэр)

“хөлсөөр ажиллагч” гэх) нар Монгол Улсын Иргэний хуулийн 359-368 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтлан дор дурдсан нөхцөлөөр энэхүү гэрээг хэлэлцэн байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

1.1. Захиалагч, хөлсөөр ажиллагч аль аль нь хамтарч ажиллах, эрх тэгш байх, харилцан ашигтай байх, түншлэлийн зарчмыг баримтлан ажиллана.

1.2. Энэхүү гэрээ нь 200__ оны __ сарын __-нээс эхлэн _____ хугацаанд _____ ажил, үүргийг хийж гүйцэтгэх хүртэл үргэлжилнэ.

1.3. Энэхүү гэрээнд зааснаас бусад тохиолдолд хөлсөөр ажиллах үйл ажиллагааг Монгол Улсын Иргэний хууль тогтоомжийг баримтлан явуулна.

1.4. Хөлсөөр ажиллагчийн нийгмийн даатгалын шимтгэл, ажлын цагийн горимыг гэрээний талуудын хэлэлцээрээр эсвэл Монгол Улсын Иргэний хуульд заасны дагуу зохицуулна.

2. Захиалагчийн хүлээх үүрэг

2.1. Хөлсөөр ажиллагч иргэн _____-ээр _____ ажил, үүрэг гүйцэтгүүлнэ.

2.2. _____ ажил (үүрэг)-ыг гүйцэтгүүлэхийн тулд _____ байр, тоног төхөөрөмж, _____ түүхий эд материал, _____ багаж хэрэгсэл, _____ бусад зүйлсээр хангана.

2.3. _____ ажил гүйцэтгүүлэхийн тулд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны _____ нөхцөлөөр хангана.

2.4. _____ ажил гүйцэтгүүлэхийн тулд _____ ажилд _____ төгрөгийн хөлс, _____ нөхцөлд _____ хэмжээний урамшил (нэмэгдэл) олгоно.

2.5. Хөлсөөр ажиллагч _____-ны хүсэлтээр _____ нөхцөлд _____ хувийн урьдчилгаа хөлс олгоно.

2.6. Хөлсөөр ажиллагч _____-нээс
1. _____
2. _____

3. _____

4. _____

зөрчил дутагдал гаргасан тохиолдолд гэрээг цуцална.

2.7. Бусад үүрэг _____

3. Хөлсөөр ажиллагчийн хүлээх үүрэг

3.1. _____-ны захиалгаар _____

үүргийг _____ хугацаанд _____ чанарын түвшинд гүйцэтгэнэ.

3.2. _____ үүргийг энэхүү гэрээнд зааснаар _____ байранд гүйцэтгэнэ.

3.3. _____ ажлыг _____

байдалд гүйцэтгэнэ.

3.4. Энэхүү гэрээнд тусгайлан тохиролцоогүй бол ажлын цагийн горим, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журмыг өөрөө хариуцна.

3.5. Гэрээнд заасан нөхцөлөөр хангахыг захиалагчаас шаардах, захиалагчийн буруугаас _____ ажлыг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд _____

_____ ажлыг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.

2.5. Хөлсөөр ажиллагчийн бусад үүрэг _____

4. Гэрээг дүгнэх журам, хариуцлага

4.1. Гэрээг _____

нөхцөлд биелэгдсэн гэж үзэж, _____ хоногийн дотор хөлсөөр ажилласны төлбөр болох _____ төгрөгийг _____ банкны _____ тоот дансанд шилжүүлэх, эсвэл бэлнээр олгоно.

4.2. Гэрээний биелэлтийг _____

_____ нар харилцан дүгнэж гэрээ, протокол үйлдэнэ.

4.3. Захиалагч энэхүү гэрээний _____ дугаар зүйлд заасан _____ үүргийг биелүүлээгүй

тохиолдолд:

1. Хоног тутамд _____ торгууль төлнө

2. _____

_____ хариуцлага хүлээнэ.

Хөлсөөр ажиллагч нь гэрээний _____ дугаар зүйлд заасан _____

_____ үүргийг биелүүлээгүй

тохиолдолд:

1. Чанаргүй гүйцэтгэсэн _____
ажил, дутуу гүйцэтгэсэн _____
_____ ажлыг үнэ хөлсгүйгээр гүйцэтгэнэ.
2. _____
ажлыг хугацаа хэтрүүлсэн, эсвэл чанаргүй гүйцэтгэсний төлөө хоног
тутамд _____ хувь буюу _____ төгрөгийн торгууль хүлээнэ.
- 4.4. Энэхүү гэрээтэй холбоотой маргааныг эвийн хэлэлцээгээр юуны өмнө
зохицуулах, тохиролцоогүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.
- 4.5. Бусад хариуцлага _____

5. Талуудын хаяг

Захиалагч:

Хөлсөөр ажиллагч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

**ИРГЭНИЙ ГОЦ БУЮУ ХОВОР АВЪЯАС,
ӨНДӨР УР ЧАДВАРЫГ ХӨЛСЛӨН
АШИГЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____ байгууллагыг төлөөлөн
(Хөлслөн авагч байгууллагын албан ёсны хаяг)
_____ ажилтай _____, нөгөө талаас _____
_____ мэргэшил, чиглэлийн гоц буюу ховор авъяас, өндөр
ур чадвартай (эдгээрийн аль нь болохыг нөхөн зурж тэмдэглэнэ) _____
хот (аймаг), сум, дүүргийн _____ хорооны харъяат _____
тоот иргэний үнэмлэх бүхий _____ овогт _____
-ний _____ хооронд иргэний _____-н
гоц буюу ховор авъяас, өндөр ур чадварыг _____
байгууллага, хамт олны үйл ажиллагаанд ашиглаж, _____
компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Хөдөлмөрийн тухай Монгол
Улсын хуулийн 22, 25, 41, Монгол Улсын Иргэний хуулийн 32 дугаар бүлгийг
үндэслэн дор дурдсан нөхцөлөөр энэхүү гэрээг хэлэлцэн байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү гэрээний зорилго нь иргэн _____-ний
_____ чиглэлийн гоц буюу ховор авъяас, _____
өндөр ур чадварыг _____ компанийн үйл
ажиллагаанд ашиглан хамтарч ажиллан харилцан туслалцахад чиглэгдэнэ.
2. Энэхүү гэрээний хугацаа 200__ оны __ сарын __-ний өдрөөс эхлэн __
жилийн хугацаатай байна. Талууд харилцан тохиролцсоноор гэрээний хугацааг
сунгана.
3. Гэрээнээс үүссэн маргааныг юуны өмнө эвийн хэлэлцээрээр зохицуулах ба
энэ нь үр дүнгүй бол шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

2. Ажилтны хүлээх үүрэг

1. _____ авъяастан _____ нь
өөрийн _____ чадварыг ашиглан _____
_____ компанийн (байгууллагын)
_____ салбар, нэгжид
_____ ажил, үүргийг дараахь
зорилтыг хангах зорилгоор хэрэгжүүлнэ.

2. _____ авъяастан _____ нь
гэрээгээр ажиллахдаа _____ хүнийг дагалдуулан
ажиллуулж өөрийн мэдлэг чадварыг уламжлуулах арга хэмжээ авна.

3. _____ авъяастан нь өөрийн үүргийг гүйцэтгэхдээ
хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, _____
байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, энэхүү гэрээг мөрдлөг болгоно.

4. _____ авъяастан _____-ний
хүлээх бусад үүрэг.

1. _____
2. _____
3. _____
4. _____
5. _____
6. _____

**3. Ажил олгогч буюу авъяастныг
ажиллуулагчийн гүйцэтгэх үүрэг**

1. _____ авъяастан _____-д
_____ төрлийн үүргийг
гүйцэтгүүлэхийн тулд _____

_____ төхөөрөмж, багтаамж бүхий _____ байраар,
_____ багаж хэрэгсэл, ажлын
ширээ, бусад төхөөрөмжөөр хангах (Гоц буюу өндөр ур чадвартай хүнтэй
холбоотойгоор шаардагдах ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг
дурдана).

2. _____ авъяастан _____-д
сарын үндсэн цалинг _____ төгрөг, нэмэгдэл цалин _____
төгрөгийг сар бүрийн _____ -нд олгоно. Хөдөлмөрийн хөлс, нэмэгдлээс
нийгмийн даатгалын шимтгэлийг Монгол Улсын хуульд заасны дагуу авах арга
хэмжээг зохион байгуулна.

3. _____ авъяастан _____-д
_____ өрөө бүхий орон сууц, _____ унаа, бусад _____
_____ хангамжаар хангана (буцалтгүй
тусламж, саалийн мал, унадаг дугуй болон бусад хангамж).

4. _____ авъяастан _____-д
_____ үүргээ гүйцэтгэх
хугацаанд ажлын хэрэгцээнд зориулан гар утас, факс, телекс, компьютер, бусад
_____ зэрэг техник хэрэгсэл олгоно.

5. _____ авъяастан _____-д
туслах _____ ажилтныг ажиллуулах,
шаардлагатай бусад тохиолдолд нэмэгдэл хүч, хөрөнгө гаргана.

6. _____ авъяастан _____-нийг
гэрээний хугацаа дуусахад _____ газарт хүргэх
зардлыг хариуцна.

7. Ажил олгогчийн бусад үүргүүд:

1. _____
2. _____
3. _____
4. _____
5. _____
6. _____

4. Гэрээг дүгнэх, хариуцлага

1. Талууд гэрээний биелэлтийг хагас жил болон жилийн эцэст дүгнэнэ.
2. Хөдөлмөрийн хуулийн 41 дүгээр зүйлд заасан үндэслэлээр гэрээг цуцална.
3. Ажил олгогч үүргээ биелүүлсээр атал _____
авъяастан _____ нь энэхүү гэрээгээр
тохиролцсон үүргээ өөрийн буруугаас болж биелүүлээгүй бол ажил олгогчийн

зүгээс үзүүлсэн хөнгөлөлт, нэмэгдлүүдийг буцаан төлнө. Энэ нь ажил олгогчийн буруутай үйлдэлд хамаарахгүй.

Ажил олгогч:

Хаяг: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

Авъяастан:

Хаяг: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

БАЙР ДАМЖУУЛАН ТҮРЭЭСЛЭХ ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(иргэн, хуулийн этгээдийн нэр)
(цаашид “Түрээслэгч” гэнэ.)-ыг _____ үндсэн дээр
(байгууллагын дүрэм, итгэмжлэл)
_____ төлөөлж, нөгөө талаас
(эцэг/эх/-ийн нэр, нэр, албан тушаал)
_____ (цаашид “Дамжуулан түрээслэгч” гэнэ.)
(иргэн, хуулийн этгээдийн нэр)
-ыг _____ үндсэн дээр _____
(байгууллагын дүрэм, итгэмжлэл) (эцэг/эх/-ийн нэр, нэр, албан тушаал)
төлөөлөн дараахь гэрээг байгуулав.

1. Нийтлэг заалт

- 1.1. Энэ гэрээний салшгүй хэсэг болох хавсралт №__-ийн дагуу түрээслэгч нь байрыг түр хугацаагаар дамжуулан түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад шилжүүлнэ.
- 1.2. Түрээслэгч түр хугацааны эзэмшил, ашиглалтад байгаа байрыг дамжуулан түрээслэхдээ “Түрээслүүлэгч”, “Түрээслэгч”-ийн хооронд байгуулсан байр түрээслэх тухай 200__ оны __ дугаар сарын __-ны өдөр байгуулсан гэрээ №__-ийн нөхцөлийг мөрдлөг болгоно.

2. Дамжуулан түрээслэх зорилго

_____.

3. Талуудын эрх, үүрэг

- 3.1. Түрээслэгч нь дамжуулан түрээслэгчид зориулалтын дагуу ашиглаж болох байрыг шилжүүлнэ.
- 3.2. Түрээслэгч нь дамжуулан түрээслэгдэж байгаа байрыг дамжуулан түрээслэгч хэрхэн ашиглаж байгаа байдалд хяналт тавих эрхтэй.
- 3.3. “Дамжуулан түрээслэгч”-ийн үүрэг:
 - 3.3.1. Түрээсийн байрыг зөвхөн гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглана.
 - 3.3.2. Түрээсийн байрыг бүрэн бүтэн байлгах, эрүүл ахуйн цэвэр байдлыг болон галын аюулгүй байдлыг хангана.
 - 3.3.3. Түрээсийн байранд өөрийн зардлаар цаг хугацаанд нь урсгал болон бусад засварыг хийнэ.
 - 3.3.4. Сантехникийн, цахилгааны болон бусад тоног төхөөрөмжийн ослын шинж байдал илэрсэн тохиолдолд түрээслэгчид нэн даруй мэдэгдэнэ.
 - 3.3.5. Түрээслэгчийн зөвшөөрөлгүйгээр дамжуулан түрээсэлж байгаа байранд урсгал ба их засварын ажил хийхгүй, сантехникийг өөрчлөн тоноглохгүй байна.
 - 3.3.6. Дамжуулан түрээсэлж байгаа байранд салшгүй сайжруулалтын засварыг зөвхөн түрээслэгчийн бичгээр хийсэн зөвшөөрлөөр хийнэ.
 - 3.3.7. Дамжуулан түрээслэж байгаа байранд түүний ашиглалтыг шалгах түрээслэгчийн төлөөлөгчийг саадгүй нэвтрүүлнэ.

3.4. Дамжуулан түрээслэгчийн буруутай үйлдлээс болон шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь аваагүйн улмаас дамжуулан түрээслэж байгаа байр ослын байдалтай болсон тохиолдолд дамжуулан түрээслэгч өөрийн хүч, зардлаар сэргээх буюу хохирлыг хууль тогтоомжийн дагуу барагдуулна.

3.5. _____

4. Дамжуулан түрээслэх байрыг шилжүүлэх

4.1. _____
(гэрээнд гарын үсэг зурсан, хүлээн авах ,хүлээлгэн өгөх баримтад гарын үсэг зурсан)
мөчөөс эхлэн _____ хоногийн хугацаанд түрээслэгч нь дамжуулан түрээслэгчид байрыг шилжүүлэн өгнө.

4.2. Байр шилжүүлэх тухай хүлээлгэн өгөх-хүлээн авах акт үйлдэнэ.

4.4. Хүлээлгэн өгөх-хүлээн авах актанд гарын үсэг зурснаар дамжуулан түрээслэх байрыг шилжүүлэн өгсөнд тооцно.

5. Тооцоо хийх

5.1. Дамжуулан түрээслэгч түрээсийн төлбөрийг тохиролцсон тооцооны дагуу _____-д _____ төгрөгийг цаг хугацаанд нь хийнэ.
(сар, улирал) (бичгээр)

5.2. Бодит үнийн өөрчлөлт болон бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр түрээсийн байр (талбай)-ны төлбөрт өөрчлөлт орох бол талуудын аль нэгний шаардлагаар түрээсийн төлбөрийг дахин авч хэлэлцэж тохиролцоно. Түрээсийн үнийг дахин авч хэлэлцэхийг санаачилсан тал нь нөгөө талдаа тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш _____ хоногийн дотор мэдэгдэнэ.

5.3. Түрээсийн төлбөрийг хожигдуулсан хоног тутам нийт төлбөрийн ___ хувьтай тэнцэх анз тооцон төлнө. Энэ нь нийт түрээсийн төлбөрийн __ хувиас хэтрэхгүй байна.

5.4. Дамжуулан түрээслэх гэрээний хугацаа дуусмагц дамжуулан түрээслэгч нь хийх ёстой байсан урсгал болон бусад засварыг гүйцэтгээгүй бол түрээслэгчид засварт гарах зардлын үнийг төлнө.

5.5. Түрээслэгчийн зөвшөөрөлгүйгээр хийсэн салж үл болох өөрчлөлтийн зардлыг дамжуулан түрээслэгчид нөхөн төлөхгүй.

6. Гэрээний үйлчлэх хугацаа, гэрээг өөрчлөх ба цуцлах

6.1. Уг гэрээгээр дамжуулан түрээслэх хугацааг 200__оны __ дугаар сарын __-ны өдрөөс эхлэн 200__оны __дугаар сарын __-ны өдөр хүртэл тогтоов.

6.1.1. Гэрээний хугацаа дууссан болон гэрээ биелэгдсэн тохиолдолд дамжуулан түрээслэгч гэрээг сунгах давуу эрхтэй.

6.1.2. Дамжуулан түрээслэх хугацаа дуусахаас нэг сарын өмнө дамжуулан түрээслэгч гэрээг сунгах хүсэлтэй байгаагаа түрээслэгчид мэдэгдэнэ.

6.1.3. Түрээсийн хугацаа дуусах болон хугацаанаас өмнө дамжуулан түрээсэлж байгаа байрыг чөлөөлөх тохиолдолд хүлээлгэж өгөх-хүлээн авах актын дагуу тус байрыг ердийн элэгдлийг тооцон зохих байдалтайгаар _____хоногоос хэтрүүлэхгүйгээр хүлээлгэн өгнө.

6.2. Дараахь нөхцөлд түрээслэгчийн шаардлагаар хугацаанаасаа өмнө энэхүү дамжуулан түрээслэх гэрээ нь цуцлагдах бөгөөд дамжуулан түрээслэгч нь түрээсийн байрнаас гарна:

6.2.1. Дамжуулан түрээсэлж байгаа байрыг бүхэлд нь болон түүний хэсгийг дамжуулан түрээслэх гэрээнд заагаагүй зориулалтаар ашигласан бол;

- 6.2.2. Дамжуулан түрээслэгч санаатайгаар болон болгоомжгүйгээс дамжуулан түрээсэлж байгаа байрны нөхцөлийг доройтуулсан бол;
- 6.2.3. _____ хугацаагаар дахин түрээсийн төлбөрийг хийгээгүй тохиолдолд;
- 6.2.4. Дамжуулан түрээслэгч нь өөрийн хүлээсэн үүргийн дагуу хийх ёстой засвар үйлчилгээг хийхгүй байх тохиолдолд.
- 6.3. Дамжуулан түрээслэгчийн үл хариуцах нөхцөл байдлын улмаас түрээсийн байрыг ашиглах боломжгүй болсон тохиолдолд дамжуулан түрээслэгчийн шаардлагаар хугацаанаас өмнө энэхүү дамжуулан түрээслэх гэрээ цуцлагдаж болно.
- 6.4. Давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр энэхүү дамжуулан түрээслэх гэрээ цуцлагдаж болно.
- 6.5. Нэг талын журмаар уг гэрээг цуцалж болохгүй.

7. Дамжуулан түрээсэлж байгаа байрыг буцаан хүлээлгэж өгөх

- 7.1. Уг гэрээний дагуу дамжуулан түрээслэх хугацаа дуусмагц дамжуулан түрээсэлж байгаа байрыг буцаан хүлээлгэж өгнө.
- 7.2. Уг гэрээний дагуу дамжуулан түрээслэх хугацаа дууссан мөчөөс эхлэн _____ хугацаанд хүлээлгэн өгөх-хүлээн авах актын дагуу дамжуулан түрээсэлж байгаа байрыг буцаан хүлээлгэж өгнө.

8. Бусад нөхцөл

- 8.1. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурсан үеэс хүчин төгөлдөр болж 200__ оны __ дугаар сарын __-ний өдөр хүртэл үйлчилнэ.
- 8.2. Энэ гэрээний үндсэн эхийг хоёр хувь хийсэн бөгөөд тал тус бүр нэг хувийг хадгална.
- 8.3. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

9. Маргааныг шийдвэрлэх

- 9.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.
- 9.2. Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

10. Нэмэлт нөхцөл

11. Нэмэлт, өөрчлөлт

- 11.1. Талууд энэ гэрээний бүх нэмэлт, өөрчлөлтийг зөвшилцөх бөгөөд энэ гэрээний хавсралтад тусгана.

12. Энэ гэрээний хавсралт

- 12.1. Хавсралт № _____ Хуудас _____
- 12.2. Хавсралт № _____ Хуудас _____

13. Талуудын хаяг

Түрээслэн авагч:

Давхар түрээслэн авагч:

Хаяг: _____

Хаяг: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ
ЗОХИОН БҮТЭЭХ, ДАМЖУУЛАН ӨГӨХ ТУХАЙ ГЭРЭЭ**

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____ (цаашид “Захиалагч”
(хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж байгууллагын нэр)

гэх)-ыг төлөөлж _____,
(төлөөлсөн хүний эцэг/эх/-ийн нэр, нэр, албан тушаал) (дүрэм, журам, итгэмжлэл)

үндэслэн, нөгөө талаас _____
(хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(цаашид “Гүйцэтгэгч” гэх)-ыг _____ үндсэн дээр _____
(дүрэм, журам, итгэмжлэл)

_____ төлөөлж үндэслэн дор дурдсан
(төлөөлсөн хүний эцэг/эх/-ийн нэр, нэр, албан тушаал)
гэрээг байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Захиалагч даалгаж, харин Гүйцэтгэгч дараахь ажлыг биелүүлэхээр үүрэг хүлээнэ. _____

1.2. Энэхүү гэрээний зүйл болох шинжлэх ухаан, технологийн, эдийн засаг болон бусад шаардлагууд нь гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №....-д тусгагдсан.

1.3. Ажлын үндсэн агуулга, түүнийг биелүүлэх үндсэн үе шат нь талуудын хооронд харилцан тохиролцсон хөтөлбөрөөр тодорхойлогдох (Хавсралт №....) нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

1.4. Гэрээгээр ажлыг гүйцэтгэх хугацаа _____. Үндсэн үе шатлалын гүйцэтгэх хугацаа нь календарьчилсан төлөвлөгөөнд тусгагдсан болно. (Хавсралт №....)

1.5. Захиалагч нь шинжлэх ухаан, технологийн бүтээгдэхүүнийг дараахь байдлаар ашиглана. _____

2. Бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгөх, хүлээж авах

2.1. Ажлын төгсгөлд энэхүү гэрээний дагуу үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүний хүлээлгэн өгөх туршилтын ажил хийгдэнэ.

2.2. Хүлээлгэн өгөх туршилт явуулах комиссийг Гүйцэтгэгчтэй тохирсны дагуу Захиалагч томилно. Захиалагч нь Гүйцэтгэгчид комиссийн бүрэлдэхүүнийг хүртэлх _____ хугацаанд мэдэгдэнэ.

2.3. Гүйцэтгэгч хүртэлх _____ хугацаанд хүлээн авах, туршилтыг явуулах бэлэн байгаа тухайгаа Захиалагчид мэдэгдэнэ.

2.4. Хүлээн авах туршилтын ажлын үр дүнгээр шинжлэх ухаан, технологийн бүтээгдэхүүнийг хүлээлгэж өгөх, хүлээн авах тухай акт үйлдэх бөгөөд үүнд дараахь зүйлийг хавсаргана.

- бүтээгдэхүүнийг хүлээн авах тухай комиссийн протокол
- энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралт-д тусгагдсан шинжлэх ухаан, технологийн бусад баримт бичгийн иж бүрдэл
- _____

2.5. _____ хугацааны дотор Захиалагч нь бичиг баримтын иж бүрдэл болон бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгөх, хүлээн авах актыг хүлээж авсан өдрөөс хойш _____ хоногийн дотор бүтээгдэхүүнийг өгөх, хүлээн авах гарын үсэг зурсан актыг юмуу эсвэл ажлыг хүлээн авахаас татгалзсан тухай шалтгааныг Гүйцэтгэгчид хүргүүлж, мэдэгдэх ёстой.

2.6. Захиалагч ажлыг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд шаардлагатай нэмэлт ажлуудыг хийх жагсаалт бүхий актыг хоёр тал хийх ба хүлээн авах туршилтыг давтан хийх хугацааг тогтооно.

2.7. Гүйцэтгэгч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хугацаанаас өмнө өгөх эрхтэй ба харин Захиалагч түүнийг хүлээн авч төлбөр хийх үүрэгтэй.

2.8. Гүйцэтгэгч нь борлуулалтын техник, эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулах эрхтэй. Энэ тохиолдолд, түүнчлэн Захиалагчийн шаардлагыг хангах зорилгоор Гүйцэтгэгч нэмэлт судалгаа шинжилгээ явуулах, туршилт хийх, ажлын чанарыг сайжруулах бол гэрээний үнэн дээр нэмэлт төлбөрийг _____ төгрөгөөр тогтооно.

2.9. Хэрэв ажлыг гүйцэтгэх явцад сөрөг үр дүн гарах нь зайлшгүй болох буюу эсвэл ажлыг цаашид явуулах нь үр ашиггүй болох нь тогтоогдвол Гүйцэтгэгч ажлаа зогсоох үүрэгтэй ба энэ тухай Захиалагчид ажлыг зогсоосон үеэс хойш _____ хугацааны дотор мэдэгдэх ёстой. Энэ тохиолдолд талууд _____ хугацаанд ажлыг цаашид үргэлжлүүлэх болон үр дүнтэй эсэх талаар асуудлыг авч үзнэ.

3. Ажлын үнэ, тооцоо хийх журам

3.1. Захиалагч Гүйцэтгэгчид шинжлэх ухаан, технологийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн ажлын үнийг _____ төгрөг, нэгжийн үнийг төлнө.
(бичгээр)

Ажлын нийт үнэ нь _____ төгрөг байна.

3.2. Захиалагч нь гэрээ байгуулснаас хойш _____ хугацаанд Гүйцэтгэгчид анх ажлын 1 дүгээр үеийн ажлын үнээс _____ хувийн урьдчилгаа төлбөрийг хийнэ.

3.3. Ажлын хөлсийг төлөхдөө хүлээн авах, хүлээлгэн өгсөн актанд гарын үсэг зурсан үеэс _____ хугацааны дотор Гүйцэтгэгчийн дансанд мөнгийг үе шаттайгаар хийнэ.

4. Талуудын хариуцлага

4.1. Хүлээсэн үүргээ зохих ёсоор буюу үл гүйцэтгэсэн тохиолдолд талууд нь үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

4.2. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх, хугацааг зөрчсөн тохиолдолд гүйцэтгээгүй ажлын үнийг _____ хувьтай тэнцэх торгуулийг хугацаа хожимдсон өдөр тутам _____ хувиар бодож Захиалагчид төлөх ба гэхдээ _____ хувиас илүүгүй байна.

4.3. Захиалагчийн төлбөрийн хугацааг зөрчсөн тохиолдолд төлбөр хийгээгүй хугацааны үнийн дүнгийн _____ хувьтай тэнцэх торгуулийг Гүйцэтгэгч төлөх ба энэ нь _____-с ихгүй байна.

4.4. Захиалагч нь жинхэнэ гүйцэтгэсэн ажлын хөлстэй холбоотой гэрээний нөхцөлийг зөрчвөл Гүйцэтгэгч гэрээг цуцлах эрх эдлэнэ.

5. Нэмэлт нөхцөл

6. Гэрээний хугацаа

6.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан үеэс эхлэн хүчин төгөлдөр болж 200__ оны __ сарын __-нд үйлчилж эхлээд 200__ оны __ сарын __-нд дуусгавар болно.

7. Маргаан шийдвэрлэх

7.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

7.2. Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

8. Талуудын хаяг

Захиалагч:

Гүйцэтгэгч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

ФРАНЧАЙЗИНГИЙН (БҮТЭЭЛ АШИГЛАХ, ЗӨВШӨӨРӨЛ) ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)
(цаашид "Зөвшөөрөл олгогч" гэнэ), түүнийг _____ үндсэн
дээр төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

негөө талаас _____
(байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)
(цаашид "Зөвшөөрөл авагч" гэнэ), түүнийг _____ үндсэн дээр
төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

бид дор дурьдсан гэрээг байгуулав. Үүнд:

1. Гэрээний зүйл

1.1. Энэ гэрээг _____ -ийн зах зээл
дээр _____
(газар нутгийн нэрийг заах)

Барааг борлуулах, үйлчилгээ явуулах ажлыг амжилттай явуулах, эдийн засгийн аль болох өндөр үр дүнгд хүрэх, талуудын ажил хэрэгч хамтын ажлгааг хөгжүүлэх зорилтын дор байгуулж байна.

1.2. "Зөвшөөрөл авагч" Зөвшөөрөл өгөгчийн худалдааны тэмдэг бүхий бүтээгдэхүүнийг үйлвэрлэх, борлуулах систем нь өөрийн өндөр чанартайг баталсныг харгалзан Зөвшөөрөл олгогчтой үйлдвэрлэлийн болон ажил хэргийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, түүний тулд

_____ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх ажилд оролцох, энэ үйл
(бүтээгдэхүүний нэр)
ажиллагаанд Зөвшөөрөл олгогчтой үйлдвэрлэлийн арга, туршлагыг хэрэглэх, түүний техникийн тусламжыг ашиглахыг хүсч байна.

1.3. Талууд ажил хэргийн дараахь зорилтуудтай болохоо санал нэгтэй тэмдэглэж байна. Үүнд:

а) үйлдвэрлэлийг тусгайлан мэргэжүүлэх болон хөдөлмөрийг зохистой хуваарлах:

б) үйлдвэрлэлийн хөтөлбөрийг өргөжүүлэн бүтээгдэхүүний хэмээг нэмэгдүүлэх:

в) нэгж бүтээгдэхүүний өөрийн өртөг, түүхий эд, бусад материалын худалдан авах үнийг хямдруулсан үндсэн дээр үйлдвэрлэлд хэмнэлттэй байдлыг хангах:

г) зах зээлийн шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажилгааны уян хатан байдлыг хангах:

д) зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй байгаа шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түргэн эзэмших:

е) _____

2. Үйлдвэрлэлийг төлөөлөх ба хөгжүүлэх

2.1. Энэ гэрээний 1-д дурьдсан хамтын зорилтыг биелүүлэхийн тулд дараахь тохиролцоонд хүрэв. Үүнд:

а) Гэрээ ёсоор бидний ажил хэргийн харилцаа нь өдөр тутмын хамтын ажиллагаа, харилцан туслалцаа үзүүлэх явдалд үндэслэсэн:

б) Харилцан бараа солилцох, үйлчилгээ үзүүлэх үнэ тогтооход зах зээлийн шалгуур, зарчмийг баримтлана.

в) Зөвшөөрөл авагч нь үйлдвэрлэлийг төлөвлөх, хөгжүүлэх ажлыг Зөвшөөрөл олгогчийн саналыг харгалзан түүнтэй ижил арга зүйгээр явуулах.

г) Талууд энэ гэрээгээр хамтран ажиллах гол зүйл болсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, борлуулах ажлыг нэгтгэн зохицуулах, аж ахуйн үйл ажиллагааг

нэгэн арга зүйгээр төлөвлөх талаар бүхий л хүчин чармайлтаа дайчлан ажиллах болно.

3. Франчайзингийн (бүтээл ашиглах, зөвшөөрөх) зорилго

3.1. Энэ гэрээний зорилго нь үйлдвэрлэл явуулах, бүтээгдэхүүн бордуулах үйл ажиллагаанд Зөвшөөрөл олгогч, Зөвшөөрөл авагчийн хамтын ажиллагаа, хүч хэрэгслийг нэгтгэн зоихон байгуулж хэрэгжүүлэх явдал мөн.

3.2. Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд тусламж үзүүлэх хүрээнд үйлдвэрлэлийн Франчайзинг дор дурьдсан асуудлыг өөртөө багтаана.

а) эрх бүхий байгуулагаас үйлдвэрлэлийн байршилтын талаар зөвшөөрөл авахад зориулан техникийн нөхцлийг тодорхойлон хангах талаар хамтран ажиллах;

б) ажилтан нарыг сургах хөтөлбөр боловсруулах, уг сургалтыг зохион байгуулах;

в) объектыг ашигалтанд оруулах, ажиллуулахад зориулсан баримт бичгээр хангах;

г) үйлдвэрлэлийн хөтөлбөр, ажлыг төлөвлөгөөг боловсруулах;

д) үйлдвэрийн өөрийн нэр, хамгаалалтын тэмдгийг ашиглах эрхийн тухай асуудлыг зохицуулах;

3.2. Энэ гэрээний 3.2.-д дурьдсан арга хэмжээ нь Зөвшөөрөл олгогчоос үзүүлэх “ багц үйлчилгээ”-г бүрдүүлэх бөгөөд тэдгээрийн гэрээний бүрдүүлэх бөгөөд тэдгээрийн гэрээний үнийг талууд тохиролцон _____-д тодорхойлно.

4. Зөвшөөрөл авагчийг үүрэг

4.1. Зөвшөөрөл авагч нь Франчайзингийн хүрээнд хамтын үйл ажиллагааг явуулахад зориулан дараахь хэрэгсэлийг, бэлтгэн өгөх үүрэгтэй:

а) Санхүүгийн хэрэгсэл болгон _____ төгрөг;

б) Үйлдвэрийн байр, тоног төхөөрөмж;

в) Үйлдвэрлэлийн хэрэгцээ , шаардлагын хэмжээгээр ажиллах хүчин.

4.2. а) Зөвшөөрөл олгогчийн үйлдвэрлэлийн хөтөлбөрөөр ажиллах ;

б) Франчайзингийн зүйл дээр ажилладаг үйлдвэрүүд дээр үйлдвэрийн өөрийн _____ нэр, _____ хамгаалалтын тэмдэгтэйгээр ажиллах;

в) Үйлдвэрлэх, борлуулах явцад Зөвшөөрөл олгогчийн баримт бичигт дурьдсан нөхцөл, шардлагад онцгой анхаарал тавьж ажиллах;

г) Зөвшөөрөл олгогчийн нууцад тооцсон бүх баримт сэлтийг үйлдвэрлэлийн нууцын нэгэн адилаар хадгалан хамгаалах.

4.3. Зөвшөөрөл авагч багц үйлчилгээ үзүүлсний төлөө Зөвшөөрөл олгогчид энэ гэрээний агуулга болсон хамтран зохион байгуулсан үйлдвэрлэлийг үйл ажиллагааны төлөвлөгөөт хэмжээ- (борлуулах бүтээглэхүүнийг оролцуулан) -ний зохих хувиар шагнал төлнө. Эхний удаагийн шагнал нь Зөвшөөрөл олгогчийн энэ гэрээний “.2.-д заасан үйл ажиллагааны зардлыг нөхөх ёстой бөгөөд дээр өгүүлсэн хэмжээний _____ хувьтай тэнцэхээр байна.

4.4. Зөвшөөрөл авагч нь Зөвшөөрөл өгөгчид гэрээ, түүний хэрэгжүүлэх хөтөлбөрт дурьдсан техникийн тусламж үзүүлэлсэн, бэлэн бүтээгдэхүүнийг борлуулах болон хөдөлмөр , үйлдвэрлэлийг зоаион байгуулахтай холбогдсон үйлчилгээ үзүүлсэн зардлыг нөхөхөөр урсгал шагнал (комисс) –ыг төлөх үүрэгтэй.

4.5. Зөвшөөрөл авагч ажилтныг сургахын тулд эдийн засгийн үндэслэл бүхий бөгөөд жинхэнэ гаргасан зардлыг төлнө.

5. Зөвшөөрөл олгогчийн үүрэг

- 5.1. Зөвшөөрөл олгогч нь энэ гэрээнд заасан ёсоор үйлдвэрлэлийн хамтын үйл ажиллагаа явуулах зорилгоор Зөвшөөрөл авагчид багц үйлчилгээ үзүүлнэ.
- 5.2. Зөвшөөрөл олгогч нь үйлдвэрлэлийн хөтөлбөр боловсруулахын зэрэгцээгээр энэ гэрээнд дурьдсан үйл ажиллагааг явуулахын тулд Зөвшөөрөл авагчид шаардагдах бүх техникийн болон зохион байгууллалтын туслалцаа үзүүлнэ.
- 5.3. Зөвшөөрөл олгогч нь Зөвшөөрөл авагчид тоног төхөөрөмж олж авахад нь зориулан комиссын үйлчилгээ үзүүлэхээс гадна төлөвлөсөн тоо хэмжээ, зохих чанар бүхий үйлдвэрлэлийн материалыг цаг тухайд нь _____ үнээр бэлтгэн нийлүүлнэ.
- 5.4. Зөвшөөрөл олгогч үйлдвэрлэлийг нэгжийн ажилд зориулан технологийн баримт бичиг боловсруулахад нь шаардагдах тусламж үзүүлнэ.
- 5.5. Зөвшөөрөл олгогч нь үйлдвэрлэлийн зохион байгуулахад тусгай тусламжийг байнга үзүүлж, гэрээний үндсэн зүйл болох бүтээгдэхүүний чанарт хяналт тавина.
- 5.6. Зөвшөөрөл олгогч нь үйлдвэрлэлийн төлөвлөсөн хэмжээг хангахын тулд үйлдвэрлэлийн нэгжийн боломжинд нийцүүлэн тэдэнд ажлын тодорхой даалгавар өгнө.
- 5.7. Зөвшөөрөл олгогч нь Зөвшөөрөл авагчид гэрээний үндсэн дээр түүний тогтмол үйлдвэрлэн нийлүүлж, бүртгүүлэн буй бүтээглэхүүнийг үнийг тогтмол төлнө.

6. Аж ахуйн үйл ажиллагааны хамтын байгуулага.

- 6.1. Аж ахуйн үйл ажиллагааг амжилттай явуулахын тулд Талууд _____ нэр бүхий хамтын байгуулага байгуулахаар тохиролцов. Энэ нь Талуудаас тэгш тооны хүмүүсээс бүрдэх бөгөөд харин дарга нь Зөвшөөрөл авагчийн талаас томилно.
- 6.2. Хамтын байгууллагын эрх мэдэл, ажлын болон шийдвэр гаргах журам нь гэрээний тусгай хавсралт, мөн гэрээний талуудын зөвшөөрснөөр хамтын байгуулага батлан гаргах ажлын заавраар тус тус зохицуулагдана.
- 6.3. Талууд маргаан гарсан бүх асуудлыг хамтын байгууллагын саналын үндсэн дээр урьдчилан нөхөрсөг хэлцлийн журмаар шийдвэрлэхийг хичээж ажиллахаар тохиролцов.

7. Гэрээний үйлчлэх хугацаа, түүнийг сунгах, гэрээг цуцлах, түүнээс татгалзах.

- 7.1. Энэ гэрээг _____ оны __-р сарын __-ээс _____ оны __-р сарын _____ хүртэл _____ жил үйлчилнэ.
- 7.2. Талуудын аль нэг нь энэ гэрээний хугацаа дуусахаас 3 сарын өмнө уул гэрээнээс цаашид татгалцахаа бичгээр илэрхийлээгүй бол гэрээний үйлчлэх хугацааг автоматаар _____ хугацаагаар сунгасанд тооцно.
- 7.3. Гэрээний нэмэлт сунгалтыг мөн гэрээний 7.2.-д заасан нөхцлөөр гүйцэтгэнэ.
- 7.4. Зөвхөн захиалгын захидлаар гэрээнээс татгалзаж болно.
- 7.5. Энэ гэрээний 7.1 - 7.4. –д заасан үндэслэлээр гэрээг цуцлахын зэрэгцээгээр талууд дараахь үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 7.5.1. Хэрэв талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлээгүй байх буюу энэ гэрээний 8-д дурьдсан нөхцөл байвал, бэрхшээл бий болсны улмаас гэрээг цуцлахыг хүссэн тал энэ тухайгаа нөгөө талдаа бичгээр мэлэгдэнэ.
- 7.5.2. Энэ гэрээний 7.6–д дурьдсан мэдэгдлийг хүлээн авсан тал уул мэдэгдлийг

хүлээн авснаас хойш 30 дотор өөрийн санаа бодлыг бичгээр мэдэгдэж, бий болсон бэрхшээлийг арилгах талаар санал тавина. Хэрэв ирүүлсэн санал, мэдэгдлээс үзэхэд учирсан бэрхшээлийг боломжийн хугацаанд арилгах аргагүй нь тодорхой байвал, аль нэгэн тал тал тийнхүү учирсан бэрхшээлийг гэтлэн давах байдлыг баталсан мэлэгдлийг хүлээн авснаар хойш 30 хоногийг дотор уул гэрээг цуцлах эрхтэй.

7.6. Дээр дурьдсан шалтгаанаар гэрээг цуцласан тохиолдолд гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг цуцлах өдөр хүртэл Талууд өөрсдийн гэрээний үүргээ биелүүлэх болно.

7.6.1. Хэрэв талуудын аль нэгний буруугийн улмаас гэрээг цуцалсан бол нөгөө тал түүнээс шалтгаалж учирсан хохирол, түүний дотор олох ёстой байсан орлогыг буруутай талаас нэхэмжлэн авах эрхтэй.

8. Хариуцлагаас чөлөөлөх

(давагдашгүй хүчин ба түүнтэй алилтгах бусад тохиолдол)

8.1. Зөвшөөрөл олгогч, Зөвшөөрөл авагч нар тэдгээрийн дурьдсанаас хамаарахгүй шалтгаанаар үүргээ биелүүлж чадаагүй тохиолдолд хариуцлагаас чөлөөлнө.

8.2. Хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл нь сайн санаат талын зориг санаанаас хамаарах бөгөөд урьдчилан зайлуулах аргагүй үйл явдлаас улбаалан бий болсон нөхцөл байдал болно.

Нөхцөл байдал нь гэрээ байгуулагдаснаас хойш бий болж, түүнийг бүрэн буюу зарим хэсгийг биелүүлэхэд саад болсон байна.

8.3. Давагдашгүй хүчин тохиолдох гэдэгт: дайн, дайны байдал, бослого, дайчилгаа, ажил хаялт, өвчин тахал, гал түймэр, дэлбэрэлт, замын осол авар, байгалийн аюул, үүрэг биелүүлэхэд нөлөөлсөн Төрийн байгууллагын акт, шүүх, арбитрын байгууллага, давагдашгүй хүчинд тооцсон бусал бүх хэрэг явдлыг хэлнэ.

9. Маргааныг шийдвэрлэх.

9.1. Энэ гэрээнээс болон түүнтэй холбогдон гарах аливаа маргааныг талууд хэлэлцээний журмаар шийдвэрлэхийг хичээнэ.

9.2. Хэрэв Талууд зохих тохиролцоонд хүрч чадаагүй бол маргааныг шийдвэрлүүлэхээр _____ -нд хандаж асуудал оруулна.

9.3. Талууд гаргасан шийдвэрийг уул шийдвэр гарснаас хойш _____ хугацааны дотор биелүүлнэ.

10. Төгсгөлийн заалт

10.1. Энэ гэрээ нь Зөвшөөрөл олгогч, Зөвшөөрөл авагч нарын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

10.2. Энэ гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгийн хэлбэрээр хийнэ.

10.3. Энэ гэрээний хавсралт болон протокол нь зөвхөн Талуудын төлөөлөгчид гарын үсэг зурсан нөхцөлд энэхүү гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт болж чадна.

10.4. Энэ гэрээний үндсэн эхийг хоёр хувь хийсэн бөгөөд тал тус бүр нэг хувийг хадгалана.

10.5. Талуудын хууль ёсны хаяг, банкны харилцах данс, гарын үсэг

Зөвшөөрөл олгогч:

Хаяг: _____
Утас: _____ факс: _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Зөвшөөрөл авагч:

Хаяг: _____

Утас: _____ факс _____

Банкны харилцах дансны дугаар: _____

Зөвшөөрөл олгогч :

Зөвшөөрөл авагч:

(гарын үсэг)
тэмдэг

(гарын үсэг)
тэмдэг

БҮТЭЭЛ АШИГЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЭЭ

№ _____

_____ хот
дугаар (аймаг, сум, дүүрэг)
ны өдөр

200_ оны __
сарын __ -

Бүтээл ашиглах /онцгой эрх, зарим эрх аль болохыг догуур нь зурна/ -ийг зөвшөөрөх энэхүү гэрээг нэг талаас _____

_____ хаягт амьдрах
_____ /эцгийн нэр, нэр/
_____ /тоот регистртэй, /Цаашид “Зохиогч” гэнэ/ нөгөө талаас

_____ хаягт амьдрах _____ /эцгийн
нэр, нэр/ _____ тоот регистртэй, /цаашид “Эрх авагч” гэнэ/ нар
/цаашид хамтдаа талууд гэнэ/ Монгол улсын Зохиогчийн эрх болон түүнд
хамаарах эрхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийг үндэслэн харилцан
тохиролцож дор дурьдсан нөхцөлөөр энэхүү гэрээ байгуулж байна.

Нэг. Бүрэн зөвшөөрөл олгох бүтээл

1.1. Зохиогчийн дараахь нэр бүхий _____

_____ /бүтээлийн нэр бичих/ бүтээлүүд байна.

1.2. Эдгээр бүтээлүүд нь ____ онд туурвисан _____ цомогт
бэхжигдсэн болно.

Хоёр: Бүрэн зөвшөөрөл

2.1. Энэхүү гэрээнд заасан бүтээлд зохиогч өөрийн эдлэх бүтээлийн эд хөрөнгийн буюу бүтээл ашиглах онцгой бүрэн эрхийг бүрэн гүйцэд /100 хувь/ эдлэхийг эрх авагчид зөвшөөрч байна.

2.2. Бүтээлийн эд хөрөнгийн буюу бүтээл ашиглах онцгой эрх гэдэгт бүтээлийг хуулбарлах, нийтлэх, нийтэд түгээх, үүсмэл бүтээл болгон өөрчлөх, түрээсээр ашиглуулах болон бусад бүхий л арга хэлбэрээр ашиглах онцгой эрхийг ойлгоно /цаашид бүтээлийн онцгой эрх гэнэ/.

Гурав: Эрх шилжүүлсний төлбөр

3.1. Бүтээл ашиглах онцгой эрхийг бүрэн шилжүүлсний нийт төлбөрт:

/тоогоор/: _____

/үсгээр/: _____

3.2. Эрх бүрэн шилжүүлсний төлбөрийг эрх авагч нь зохиогчид нэг удаа төлбөр төлнө.

Дөрөв: Зохиогчийн эрх, үүрэг

4.1. Энэхүү гэрээгээр шилжүүлж буй бүтээл нь зохиогч миний хууль ёсны бүтээл мөн бөгөөд энэхүү гэрээгээр шилжүүлж байгаа бүтээлийн онцгой эрхийг гуравдагч этгээдэд бүрэн болон хэсэгчлэн шилжүүлээгүй болохоо баталж байна. Хэрэв үүнтэй холбогдсон маргаан, зөрчил гарвал түүний хариуцлага, төлбөр, зардал, ирээдүйд гарах алдагдлыг зохиогч бүрэн хариуцна.

4.2. Зохиогч нь өнгөрсөн, одоо, ирээдүйд бүтээлдээ эд хөрөнгийн буюу бүтээл ашиглах ямар ч онцгой эрх эдлэхгүй, зөвхөн амины эрх буюу зохиогч байх, нэрээ дурдуулах, зохиомол нэр ашиглах эрхээ саадгүй эдэлнэ.

4.3. Гэрээнд заасан бүтээлийн ашиглах онцгой эрхийг зохиогч нь зөвхөн эрх авагчийн бичгээр хийсэн зөвшөөрлийн үндсэн дээр эдэлнэ.

4.4. Зохиогч би энэхүү гэрээнд хамаарах сэдэв, салбарт бүтээлээ чөлөөтэй туурвих эрхтэй, гагцхүү энэ гэрээнд заасан бүтээлийн эрх, ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэх болон олон нийтийг төөрөгдүүлэх адил утга, агуулгатай бүтээлийг цаашид хийхгүй болохоо батлаж байна.

Тав. Эрх авагчийн эрх үүрэг

5.1. Энэхүү гэрээний дагуу бүтээлийн эд хөрөнгийн буюу бүтээл ашиглах онцгой эрхийг эрх авагч нь Монгол улсын Зохиогчийн эрх түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасан хугацаанд бүрэн эдэлнэ.

5.2. Эрх авагч би бүтээл ашиглах онцгой эрхээ эдлэхдээ бүтээлийг гажуудуулах, дордуулахгүй байх болон зохиогчийн амины буюу эдийн бус баялагийн эрхийг хөндөхгүй байх үүрэгтэй.

5.3. Эрх авагч би бүтээл ашиглах онцгой эрхээ өнгөрсөн, одоо, ирээдүйд ганцаар бүрэн эдэлнэ.

Зургаа: Бусад заалт:

6.1. Энэхүү гэрээ нь гуравдагч этгээдэд хамаарахгүй.

6.2. Энэхүү гэрээний нөхцөл, заалттай холбоотой маргаан гарвал талууд аль болох хэлэлцээ хийх аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.3. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

6.4. Энэхүү гэрээг _____ оны _____ сарын _____-ны өдөр адил хүчинтэй гурван хувь үйлдэж талууд тус бүрт нэг хувь, нотариатад нэг эх хувь хадгалагдана.

6.5. Талууд энэхүү гэрээнд заасан нөхцлийг урьдчилан гүйцэд уншиж танилцсан, гэрээний бүх нөхцлийн талаар харилцан саналаа илэрхийлж тохиролцсон бөгөөд талууд бүрэн дүүрэн ойлголтыг авсан болно.

Гэрээ байгуулсан:

Зохиогч:

/ нэр /

/ гарын үсэг /

Иргэний үнэмлэхний № _____
Регистрийн № _____

Эрх авагч:

/ нэр /

/ гарын үсэг /

Иргэний үнэмлэхний № _____
Регистрийн № _____

БҮТЭЭЛ (НОМ, ТОВХИМОЛ) ХЭВЛЭХ, ХЭВЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

№

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(бүтээл (ном, товхимол) хэвлэх ажлыг эрхлэх байгууллагын нэр, хаяг)
(цаашид "Хэвлэлийн газар" гэнэ), түүнийг _____ үндсэн
дээр төлөөлөн _____
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нөгөө талаас _____
(ном зохиогчийн овог, нэр, хаяг)
(цаашид "Зохиогч" гэнэ) бид дор дурьдсаи гэрээ байгуулав. Үүнд:

1. Зохиогч _____ нэртэй номыг Хэвлэлийн газар сайшаан зөвшөөрснөөс хойш _____ хугацааны дотор _____ хэл дээр бичиж хэвлүүлэх (дахин хэвлүүлэх)-ээр хэвлэлийн газарт шилжүүлэн өгнө.

2. Дурьдсан бүтээл нь доорхи нөхцлийг хангасан байна:

а) _____
(бүтээлийн төрөл, жанр, зориулалт)

б) Гэрээнд хавсаргасан хөтөлбөртэй нийцсэн байх;

в) _____
(захиалга, төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр)

г) Номын хэмжээ нь хавсралт болон зургийг оруулаад зохиогчийн _____ хэвлэлийн хуудас (шүлгийн мөр) байна (Зохиогчийн нэг хэвлэлийн хуудас нь 40 мянган хэвлэлийн тэмдэгттэй тэнцэнэ).

3. Зохиогч бүтээлийн эх бичмэлийг _____ оны __ -р сарын _____ -ээс хожимдуулахгүйгээр хэвлэлийн газарт (шууданд өгөх) ирүүлнэ.

Зохиогч гэрээний дагуу 10 хүртэлх зохиогчийн хэвлэлийн хуудас бүхий бүтээлийн эх бичмэлийг тогтоосон өдрөөс нэг сар, 10-аас дээш зохиогчийн хэвлэлийн хуудас бүхий бүтээлийн эх бичмэлийг хоёр сарын хугацаагаар тус тус хэвлэлээс зөвшөөрөл авахгүйгээр хожимдуулан ирүүлж болно.

Зохиогчийн гарын үсэг зурсан эх бичмэл нь хоёр хувь байх бөгөөд тод харагдахуйц үсгээр, хоёр мөрний зайтай (интервал)-гаар стандартын хуудасны нэг талд 28-30 мөрөөр, нэг мөрөндөө 60-аас дээшгүй үсгийн тэмдэгт оруулан машиндсан байна.

Хоёр буюу түүнээс олон зохиогчтой (хамтын) бүтээлд бүх зохиогчид гарын үсэг зурж, бүтээлээ бүхэлд нь ирүүлнэ.

Эх бичмэлийг бүрэн, тогтоосон журмаар хэлбэржүүлэн ирүүлнэ.

Эх бичмэлийг хагас дутуу буюу зохих ёсоор хэлбэржүүлээгүй байна гэсэн шүүмжлэл хэвлэлийн газарт ирснээс хойш 10 хоногийн дотор гараагүй бол уг бүтээлийг Хэвлэлийн газар хүлээн авсан гэж үзнэ.

4. Зохиогч гэрээ байгуулсан өдрөөс буюу эсвэл эх гар бичмэлийг Хэвлэлийн газар сайшаан зөвшөөрснөөс хойш _____ жилийн дотор уг бүтээл болон түүний хэсгийг хэвлэлийн газраас урьдчилан бичгийн зөвшөөрөл авахгүйгээр өөр байгууллагад хэвлүүлэхээр шилжүүлэн өгч болохгүй.

Тайлбар:

а) Хэрэв бүтээл хоёр буюу түүнээс дээш ботиор байвал боть тус бүр тусдаа хэвлэгдэхгүй нөхцөлд тэдгээрийн сүүлчийн ботийг хэвлэлийн газар сайшаан зөвшөөрснөөр уг бүтээлийг бүхэлд нь сайшаан зөвшөөрсөн гэж үзнэ.

б) Зохиогч хэвлэлийн газраас зөвшөөрөл авахгүйгээр харин түүнд зөвхөн мэдэгдсэний үндсэн дээр өөрийн бүтээлийг сонин сэтгүүл, роман-сонин, цоморлигт нийтлүүлж болно.

5. Хэвлэлийн газар зохих ёсоор хэлбэржүүлсэн бүтээлийг хүлээн авснаас хойш 30 хоног дээр зохиогчийн хэвлэлийн хуудас бүр (шүлгийн 700 мөр) бүрд 4 өдөр нэмсэн хугацаанд түүнийг хянан үзээд нэг бол бүтээлийг сайшаан хэвлэхийг зөвшөөрөх, эсвэл гэрээнд заасан үндэслэлээр хэвлэхээс татгалзах, мөн гэрээний нөхцлийн хүрээнд зохих хэмжээний засвар хийх шаардлагатай байгаа тухай зохиогчид бичгээр мэдэгдэнэ.

Хэвлэлийн газар эх бичмэлдээ засвар хийхэд нь зориулан зохиогчид хангалттай хугацааг өгөх бөгөөд тэгэхдээ уг хугацааг талууд тохиролцож тогтооно.

9.3. Гүйцэтгэгч дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/ төслийг хугацаанд нь багтааж бүрэн гүйцэтгэх, үр дүнг тоо, чанарын хувьд захиалсан түвшингээс нь бууруулахгүйгээр бүтээж бий болгох;
б/ төслийн хөрөнгө зардлыг оновчтой хэлбэрээр хуваарилж, үр ашигтай зарцуулах;
в/ гүйцэтгэж буй төсөл, түүний үр дүнгийн талаар сурталчилж байх, үр дүнг нэвтрүүлэх буюу ашиглах аж ахуйн нэгж, байгууллагыг олох;
г/ төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлыг тооцож төслийн жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх;
д/ төслийн явцыг хагас жил тутам захиалагч, санхүүжүүлэгчид танилцуулж байх.

10. Эрх

10.1. Захиалагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/ төслийн гүйцэтгэл, үр дүн, түүний баталгаажуулалт, санхүүжилт, санхүүгийн үйл ажиллагаа зэрэг асуудлын талаар гүйцэтгэгчээс тухай бүр мэдээ, тайлан гаргуулж авах, гэрээний үүргийг биелүүлэх, зөрчил дутагдлыг арилгах талаар түүнд анхааруулах, шаардлага тавих;
б/ захиалсан үр дүнд холбогдолгүй ажлыг төслийн хүрээнд гүйцэтгэж буй тохиолдолд уг ажлыг зогсоох тухай асуудлыг зохих журмын дагуу тавьж шийдвэрлүүлэх;

в/ төслийн үр дүн нь захиалагчийн хэрэгцээ шаардлагыг хангахааргүй төлөвтэй байгаа тохиолдолд төслийг зогсоох буюу шинэчлэх, гэрээг цуцлах асуудлыг зохих журмын дагуу тавьж шийдвэрлүүлэх;

г/ гэрээний шаардлагыг хангаагүй үр дүнг хүлээж авахгүй байх, уг ажлыг дахин гүйцэтгүүлэх, эсвэл төлбөр тавих;

д/ захиалсан үр дүнгийнхээ патентыг эзэмших, үр дүнг захиран зарцуулах;

е/ төслийн эрдэм шинжилгээний ажлын тайланг өмчлөх, бусдад ашиглуулах асуудлыг шийдвэрлэх;

ж/ өгөөж, ашиг сайтай үр дүн бий болгосон тохиолдолд гүйцэтгэгчийг зохих журмын дагуу урамшуулах;

з/ төсөл хэрэгжүүлэх явцад түүний санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх /хорогдуулах/ зайлшгүй шаардлага гарвал уг асуудлыг санхүүжүүлэгчтэй хамтран боловсруулж, шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

и/ төслийн хэрэгжилтийн явц захиалагчаас үл хамаарах шалтгаанаар удаашрах, төлөвлөсөн ажил биелэхгүй байх, үр дүн нь хэрэгцээ шаардлагыг хангахааргүй төлөвтэй байгаа тохиолдолд төслийн санхүүжилтийг зогсоох, гэрээг цуцлах асуудлыг санхүүжүүлэгчтэй хамтран шийдвэрлэх;

к/ гэрээнд заасан хэмжээ, хуваарийн дагуу төслийн санхүүжилт хийгдэхгүй тохиолдолд гэрээний үүргээ биелүүлэх талаар санхүүжүүлэгчид шаардлага тавьж хариу авах.

10.2. Санхүүжүүлэгч дор дурдсан эрх эдэлнэ:

а/ төслийн гүйцэтгэл, үр дүн, түүний баталгаажуулалт, хөрөнгө зардлын зарцуулалт, ашиглалт зэрэг асуудлаар захиалагчаас мэдээ, тайлан гаргуулж авах, гэрээний үүргийг биелүүлэх, зөрчил дутагдлыг арилгах талаар түүнд анхааруулах, шаардлага тавих, зохих дээд шатны байгууллагад мэдээлэх, асуудал боловсруулж шийдвэрлүүлэх;

б/ санхүүгийн мэдээ, тайланг хожимдуулах, санхүүгийн үйл ажиллагааг буруу явуулах, хөрөнгө мөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулах, санхүүжилтийн бус шалтгаанаар төслийн ажил удаашрах, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй тохиолдолд төслийн санхүүжилтийг түр зогсоох, улмаар шаардлагатай гэж үзвэл төслийг хаах санал тавих зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

в/ төслөөр гүйцэтгэх ажлын чиглэл, төслийн үр дүнг ашигласнаас ашиг олох боломж зэргийг харгалзаж төсөл болон түүний тодорхой үе шатны ажлуудыг буцалтгүй санхүүжүүлэх, эргэж төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлэх, зээл олгох зэргийн аль тохиромжтой хэлбэрийг нь сонгож ялгавартайгаар санхүүжүүлэх асуудлыг захиалагчтай тохиролцон хэрэгжүүлэх;

г/ төслийн үр дүнгийн борлуулалт, нэвтрүүлэлтээс олсон орлого, ашгаас санд зохих хэмжээний шимтгэл авах замаар сангийн хөрөнгийг арвижуулах, өгөөж сайтай үр дүнг урамшуулах;

д/ холбогдох талуудтай нэмэлт гэрээ, хэлцэл байгуулж, харилцан тохиролцох замаар төслийн үр дүнг борлуулах буюу борлуулахад зуучлах, үүний төлөө зохих хэмжээний хувь ногдол хүртэх;

е/ патент эзэмшигчтэй лицензийн гэрээ байгуулж патентлагдсан үр дүнг ашиглах, эсхүл патент эзэмших эрхийг захиалагчаас шилжүүлж авах;

ж/ төслийн сүүлийн жилийн санхүүжилтийн 10 хувийг санд үлдээж төслийг бүрэн дуусгаж, үр дүнг захиалагчид, эрдэм шинжилгээний ажлын тайланг Итгэмжлэн хадгалагчид хүлээлгэж өгсний дараа захиалагчийн санал дүгнэлтийг үндэслэн гүйцэтгэгчид олгох.

10.3. Гүйцэтгэгч дор дурдсан эрх эдэлнэ:

а/ төслийн үйл ажиллагааны хүрээнд захиалагч, санхүүжүүлэгчээс аас санхүү, эдийн засаг, удирдлага, зохион байгуулалтын хувьд зохих хэмжээний дэмжлэг туслалцаа авах;

б/ төсөл гүйцэтгэх нөхцөл бололцоогоор бүрэн хангахыг шаардах;

в/ захиалгаар бий болгосон үр дүн нь шинэ бүтээлийн патент авсан нөхцөлд захиалагчтай лицензийн гэрээ байгуулах үндсэн дээр тухайн үр дүнг ашиглах, эсхүл патент эзэмших эрхийг захиалагчаас зохих журмын дагуу шилжүүлж авах;

г/ төслийн үр дүн шинэ бүтээлийн патент, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын гэрчилгээ авсан нөхцөлд түүнийг хүлээн авч ашиглагч этгээдтэй зохиогч нь гэрээ хэлцэл байгуулах замаар лицензийн төлбөр авах;

д/ захиалгаар бий болгосон үр дүн нь зохиогчийн эрхэд хамаарах тохиолдолд захиалагчтай нэмэлт гэрээ хэлцэл байгуулж, түүнд тусгагдсан болзол, нөхцөлийн дагуу зохиогчийн эрх эдлэх;

е/ төслийн үр дүнгийн даалгаварт нэр заагдаагүй боловч төслөөр зайлшгүй хийгдэх ажлын хүрээнд бий болгосон бүтээл нь зохиогчийн эрхэд хамаарах тохиолдолд зохиогч этгээд тухайн бүтээлийнхээ хувьд эд хөрөнгийн бус амины болон түүнийг ашиглах онцгой /эд хөрөнгийн/ эрх эдлэх;

ж/ төслийн үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглах явцад зохиогчийн хяналт тавих;

з/ төслийн үр дүнг бүтээж, бий болгосны төлөө, түүнийг үйлдвэрлэлд ашигласнаас олсон орлого, ашгаас гэрээ хэлцлийн үндсэн дээр зохих хэмжээний шан, урамшуулал авах.

11. Хариуцлага

Үүргээ биелүүлээгүй талын хүлээх хариуцлагыг талууд харилцан тохиролцоо замаар энэхүү гэрээнд тодорхой тусгана.

Гурав. Бусад зүйл

12. Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, түүний үр дүнг баталгаажуулах, үнэлэх, хүлээлгэн өгөх, үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд шилжүүлэх, ашиглах, урамшуулах ажлыг холбогдох хууль тогтоомж болон Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх журам, түүнд нийцүүлж гаргасан бусад дүрэм, журам, заавар, аргачиллын хүрээнд хийж гүйцэтгэнэ.

13. Энэхүү гэрээний эхийг _____ хувь үйлдэж гэрээлэгч талууд ба шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус бүр нэг хувийг хадгалав.

Захиалагчийг төлөөлж:

Санхүүжүүлэгчийг
төлөөлж:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

/гарын үсэг/

/гарын үсэг/

/гарын үсэг/

/албан тушаал/

/албан тушаал/

/албан тушаал/

/Гарын үсгийг тамга, тэмдгээр баталгаажуулна/

Тайлбар: Гэрээний энэхүү үлгэрчилсэн загвар нь нийтлэг шинж чанартай учир тодорхой төслөөр гэрээ байгуулахдаа гэрээний бүтэц, агуулга, үг найруулга, ялангуяа, гүйцэтгэх ажил, гарах үр дүнгийн онцлогтой уялдуулан талуудын үүрэг, эрх, хариуцлагын хувьд зохих хэмжээний өөрчлөлт тодруулалт хийх нь зүйтэй.

_____ нэртэй шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх 200 оны _____ дугаар сарын ны өдрийн тоот гэрээний 1 дүгээр хавсралт

ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР /Техникийн даалгавар/

Төслөөр бий болгох үр дүнгийн нэр	Тоо хэмжээ	Үндсэн параметр	Захиалагчид хүлээлгэж өгөх хугацаа

Захиалагчийг төлөөлж:

.....

/гарын үсэг/

.....

/овог нэр/

.....
/албан тушаал/

Гүйцэтгэгчийг төлөөлж:

.....

/гарын үсэг/

.....

/овог нэр/

.....
/албан тушаал/

Төслийн удирдагч

.....

/гарын үсэг/

.....

/овог нэр/

.....
/албан тушаал/

/Гарын үсгийг тамга, тэмдгээр баталгаажуулна/

_____ нэртэй Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх 200... оны .. дугаар сарын .. ны өдрийн .. тоот гэрээний 2 дугаар хавсралт

ТӨСЛӨӨР ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ
/Ажлын программ/

Төслийн хүрээнд гүйцэтгэх тодорхой үе шатны ажлуудын нэр	Эхлэх, дуусах хугацаа /он,сар,өдөр/	Гүйцэтгэгчийн овог, нэр, мэргэжил

Захиалагчийг төлөөлж:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Төслийн удирдагч

.....
/гарын үсэг/

.....
/гарын үсэг/

.....
/гарын үсэг/

.....
/овог нэр/

.....
/овог нэр/

.....
/овог нэр/

.....
/албан тушаал/

.....
/албан тушаал/

.....
/албан тушаал/

/Гарын үсгийг тамга, тэмдгээр баталгаажуулна/

_____ нэртэй шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, 200.... оны .. дугаар сарын .. ны өдрийн тоот гэрээний 3 дугаар хавсралт

ТӨСЛИЙН ӨРТӨГ, ЗАРДАЛ ТОХИРОЛЦСОН ТУХАЙ ПРОТОКОЛ

Төслийн өртөг, зардал, санхүүжилтийг дараахь хэмжээ, хуваарь, нөхцөлтэйгээр харилцан тохиролцож энэхүү протоколыг 200...оны ... дугаар сарын ны өдөр үйлдэв. Үүнд:

1.Төслийн нийт төсөвт өртөг мян.төг

Үүнээс: - урсгал зардал мян.төг

- хөрөнгийн зардал мян.төг

2.Төслийн нийт зардлын оны хуваарь /урьдчилсан байдлаар/

Он	Бүгд	Урсгал	Хөрөнгийн
200			
200			
200			
Дүн			

3. Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгийн батлагдсан хэмжээ, жилийн төсөв, төлөвлөгөөтэй уялдуулан дээр дурдсан оны хуваарьт жил бүр өөрчлөлт, тодотгол хийнэ.

4. Тухайн жилийн төсвийг зохиохдоо оны хуваарьт дурдсан зардлыг санхүүгийн холбогдох байгууллагаас гаргасан хүчнэгт загварын дагуу зардлын нэрээр ангилж, нарийвчлан тооцох ба төсвийн батлагдсан тооцоог тухай бүр энэхүү протоколд хавсаргана.

5. Төслийг санхүүжүүлэхдээ түүний хүрээнд гүйцэтгэх ажлын чиглэл, явц байдал, гарах үр дүнгийн онцлог зэргийг харгалзан ажлын тодорхой үе шатуудад санхүүжилтийн хэлбэрийг ялгавартайгаар сонгон тогтоож болох ба энэ тохиолдолд талууд тухай бүр харилцан тохиролцож нэмэлт тэмдэглэл үйлдэж энэхүү протоколд хавсаргана.

6. Энэ протокол ба түүнд хийсэн албан ёсны тодотгол, тооцоо нь төслийн эцэст санхүүгийн өр, авлагыг тооцоход баримтлах эрхийн үндэслэл болно.

Санхүүжүүлэгчийг төлөөлж Гүйцэтгэгчийг төлөөлж:

Захиалагчийг төлөөлж:

.....

/гарын үсэг/

.....

/гарын үсэг/

.....

/гарын үсэг/

.....

/овог нэр/

.....

/овог нэр/

.....

/овог нэр/

.....

/албан тушаал/

/Гарын үсгийг тамга, тэмдгээр баталгаажуулна/

.....

/албан тушаал/

.....

/албан тушаал/

Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх,
санхүүжүүлэх журмын 2 дугаар хавсралт

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН,
ТӨСЛИЙН ҮР ДҮНГҮНЭЛЖ, ХҮЛЭЭН АВСАН АКТ
/Үлгэрчилсэн загвар/

200.. оны .. дугаар
хот
сарын .. ны өдөр

Дугаар...

Улаанбаатар

Захиалагч -ыг төлөөлж

/байгууллагын нэр/

/албан тушаал, овог, нэр/

Гүйцэтгэгч -ийг төлөөлж

байгууллагын нэр/

/албан тушаал, овог нэр/

/цаашид “талууд” гэх/ Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх,
санхүүжүүлэх журмыг үндэс болгон 200... оны ... дугаар сарын .. ны өдрийн ...
тоот гэрээний дагуу 200.... – 20..... онд гүйцэтгэсэн.
.....

нэртэй шинжлэх ухаан, технологийн төсөл /цаашид “төсөл” гэх/-ийн үр дүнг
үнэлэн хүлээлцэж энэхүү актыг үйлдэв.

Нэг. Үнэлж хүлээн авсан үр дүнгийн жагсаалт

Төслөөр гаргасан эцсийн үр дүнгийн нэр	Тоо хэмжээ	Үндсэн параметр	Өөрийн өртөг /мян.төг/

Хоёр. Үр дүнг шилжүүлэх, ашиглах

1. Үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд дараах хэлбэрээр шилжүүлэхээр тохиролцов:

- а.
- б.

2. Үр дүнг үйлдвэрлэгч, хэрэглэгч нар дараах хэлбэрээр ашиглана:

- а.
- б.

3. Үр дүнг шилжүүлэх, ашиглах үйл ажиллагааг цаашид өргөжүүлэн явуулах ба энэ зорилгоор төслийг гэрээлэгч талууд хамтран ажиллаж дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэх болно:

- а.
- б.

4. Үр дүнг борлуулах тохиолдолд үнийг нь тохиролцон тогтоох зарчим баримтлах ба ингэхдээ энэхүү актад дурдсан өөрийн өртгийг албан ёсны жишиг болгоно.

Гурав. Бусад зүйл

5. Төслийн санхүүгийн тооцоо хийж, өр, авлагыг барагдуулах ба Санд шимтгэл оруулах, үр дүнг урамшуулах зэрэг асуудлыг санхүүжүүлэгч байгууллага зохих журмын дагуу хариуцан зохион байгуулж, төслийг гэрээлэгч талууд тухай бүр хамтран ажиллах болно.

6. Энэхүү актын эхийг 4 хувь үйлдэж төслийн захиалагч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгч талууд ба шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус бүр нэг хувийг хадгалуулав.

Захиалагчийг төлөөлж:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

.....
(гарын үсэг)

.....
(гарын үсэг)

.....
(овог нэр)

.....
(овог нэр)

.....
(албан тушаал)

.....
(албан тушаал)

(Гарын үсгийг тамга, тэмдгээр баталгаажуулна)

ОНОЛЫН СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

200 ... оны ... дугаар
сарын -ны өдөр

№....

Улаанбаатар хот

Захиалагчийг _____ төлөөлж _____
(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

Гүйцэтгэгчийг _____ төлөөлж _____
(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

(цаашид "Талууд" гэх) онолын суурь судалгааны ажлыг гүйцэтгэх,
санхүүжүүлэх журмыг үндэс болгон

_____ нэртэй онолын суурь судалгааны
сэдэвт ажлыг (цаашид "суурь судалгаа" гэх) хэрэгжүүлэх талаар харилцан
тохиролцож энэхүү гэрээг байгуулав

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Суурь судалгааны сэдэвт ажлыг 200 – 200 онд багтааж жилийн хугацаанд гүйцэтгэнэ.

1.2. Суурь судалгааны дүнд дэвшүүлэх таамаглал, бүтээл туурвилын чиглэл, шинжлэх ухааны шинэлэг тал, ач холбогдлыг "Суурь судалгааны сэдэвт ажлын тодорхойлолт", "Онолын суурь судалгааны сэдэвт ажлын жагсаалт"-д тодорхойлж гэрээнд хавсаргана.

1.3. Шинэ бүтээлийн патент, оновчтой саналын гэрчилгээ авсан, зохиогчийн эрхэд хамаарах бусад бүтээл бий болгосон тохиолдолд тухайн бүтээлийг ашиглах онцгой эрх болон зохиогчийн эрхтэй холбогдон үүсэх харилцааг Патентийн тухай, Зохиогчийн эрхийн тухай, Иргэний хуулиуд ба энэ гэрээнд дурьдсаны дагуу зохицуулах зарчим баримтална. Өөрөөр зохицуулах шаардлага гарвал талуудын хооронд нэмэлт гэрээ хэлцэл байгуулж болно.

Хоёр. Талуудын үүрэг, эрх хариуцлага

2.1. Үүрэг

2.1.1. Захиалагч дараах үүрэг хүлээнэ:

а/ Суурь судалгааны гүйцэтгэлд байнгын хяналт тавих

б/ Суурь судалгаа гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд зохих дэмжлэг тусалцаа үзүүлэх

в/ Суурь судалгааны явцтай хагас жил тутам танилцаж, дараагийн санхүүжилтийн талаар санал гаргах

г/ Суурь судалгааны үр дүнгийн үнэлгээ, тайланг хянаж баталгаажуулах

д/ Суурь судалгааны үр дүнг хүлээн авч, түүнийг үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглах арга хэмжээг зохион байгуулах

е/ Үр дүнгийн ашиглалтын байдлыг харгалзан гүйцэтгэгч нарыг зохих журмын дагуу хөхүүлэн дэмжих, урамшуулах

2.1.2. Гүйцэтгэгч дараах үүрэг хүлээнэ:

а/ Суурь судалгааны ажлыг хугацаанд нь багтааж бүрэн гүйцэтгэх, үр дүнг тоо чанарын хувьд захиалсан түвшингээс нь бууруулахгүйгээр бүтээж бий болгох

б/ Суурь судалгааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлыг тооцож төсвийн жил, жилийн төсөв, төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх

в/ Суурь судалгааны хөрөнгө зардлыг оновчтой хэлбэрээр хуваарилж, үр өгөөж сайтайгаар зарцуулах

г/ Суурь судалгааны гүйцэтгэлийн явц, үр дүнгийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд тухай бүр мэдээлж байх

д/ Гүйцэтгэж буй суурь судалгааны сэдэвт ажил, түүний үр дүнгийн талаар сурталчилж байх, үр дүнг нэвтрүүлэх буюу ашиглах аж ахуйн нэгж, байгууллагуудтай холбоо тогтоох

е/ Суурь судалгааны явцыг хагас жил тутам захиалагчид танилцуулж байх

ё/ Суурь судалгааны ажлын үр дүнг олон улсын түвшинд хүргэх талаар тодорхой ажил зохиох

2.2. Эрх

2.2.1. Захиалагч дараах эрх эдэлнэ:

а/ Суурь судалгааны гүйцэтгэл, үр дүн, түүний баталгаажуулалт, санхүүжилт, санхүүгийн үйл ажиллагаа зэрэг асуудлын талаар гүйцэтгэгчээс тухай бүр мэдээ, тайлан гаргуулж авах, гэрээний үүргийг биелүүлэх, зөрчил дутагдлыг арилгах талаар түүнд анхааруулах, шаардлага тавих

б/ Суурь судалгааны захиалсан үр дүнд холбогдолгүй ажлыг сэдэвт ажлын хүрээнд гүйцэтгэж буй тохиолдолд уг ажлыг зогсоох тухай асуудлыг зохих журмын дагуу тавьж шийдвэрлүүлэх

в/ Суурь судалгааны үр дүн нь захиалагчийн хэрэгцээ шаардлагыг хангахааргүй төлөвтэй байгаа тохиолдолд ажлыг зогсоох буюу шинэчлэх, гэрээг цуцлах асуудлыг зохих журмын дагуу тавьж шийдвэрлүүлэх

г/ Гэрээний шаардлагыг хангаагүй үр дүнг хүлээж авахгүй байх, уг ажлыг дахин гүйцэтгүүлэх, эсвэл төлбөр тавих

д/ Захиалсан үр дүнгийнхээ патентыг эзэмших, үр дүнг захиран зарцуулах,

е/ Суурь судалгааны ажлын тайланг өмчлөх, бусдад ашиглуулах асуудлыг шийдвэрлүүлэх

ж/ Өгөөж, ашиг сайтай үр дүн бий болгосон тохиолдолд гүйцэтгэгчийг зохих журмын дагуу урамшуулах.

2.2.2. Гүйцэтгэгч дараах эрх эдэлнэ:

а/ Суурь судалгааны үйл ажиллагааны хүрээнд захиалагчаас санхүү, эдийн засаг, удирдлага, зохион байгуулалтын хувьд дэмжлэг туслалцаа авах

б/ Суурь судалгааны ажлыг гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангахыг шаардах

в/ Захиалгаар бий болгосон үр дүнгээр патентын эрх хамгаалах нөхцөлд захиалагчтай лицензийн гэрээ байгуулах үндсэн дээр тухайн үр дүнг ашиглах, эсвэл патент эзэмших эрхийг захиалагчаас зохих журмын дагуу шилжүүлж авах

г/ Суурь судалгааны үр дүн оновчтой саналаар батлагдсан нөхцөлд түүнийг хүлээн авч ашиглагч этгээдтэй зохиогч нь гэрээ хэлцэл байгуулах замаар лицензийн төлбөр авах

д/ Захиалгаар бий болгосон үр дүн нь зохиогчийн эрхэд хамаарах тохиолдолд захиалагчтай нэмэлт гэрээ хэлцэл байгуулж, түүнд тусгагдсан болзол нөхцөлийн дагуу зохиогчийн эрх эдлэх

е/ Суурь судалгааны үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглах явцад зохиогчийн хяналт тавих

ж/ Суурь судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлснээс олсон ашиг орлогоос холбогдох хууль, журмын дагуу хувь хүртэх

Гурав. Бусад зүйл

3.1. Суурь судалгааны үр дүнг баталгаажуулах, үнэлэх, хүлээлгэн өгөх, үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд шилжүүлэх, ашиглах, урамшуулах ажлыг холбогдох хууль тогтоомж болон Онолын суурь судалгааны ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх журам, түүнд нийцүүлж гаргасан бусад дүрэм, журам, заавар аргачлалын хүрээнд хийж гүйцэтгэнэ.

3.2. Энэхүү гэрээний эхийг 3 хувь үйлдэж гэрээлэгч талууд ба шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус бүр нэг хувийг хадгална.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ

(гарын үсэг)

(гарын үсэг)

(овог нэр)

(овог нэр)

(албан тушаал)

(албан тушаал)

Тайлбар: Гэрээний энэхүү үлгэрчилсэн загвар нь нийтлэг шинж чанартай учир тодорхой гэрээ байгуулахдаа гэрээний бүтэц, агуулга, үг найруулга, ялангуяа гүйцэтгэх ажил, гарах үр дүнгийн онцлогтой уялдуулан талуудын үүрэг, эрх хариуцлагын хувьд зохих хэмжээний өөрчлөлт тодруулалт хийх нь зүйтэй.

.....

.....

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЗЭХЭЦ АЖЛЫГ
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙГЭЭР САНХҮҮЖҮҮЛЭХ
ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

Нэг. Гэрээний зорилго, үндэслэл

Шинжлэх ухаан, технологийн сан (цаашид “Сан” гэх)-гаас шинжлэх ухаан, технологийн хөгжлийг хөхүүлэн дэмжих, төслийн үр дүнд бий болсон зэхэц ажил (бэлэн бүтээгдэхүүн, боловсрогдсон технологи)-ыг үйлдвэрлэлд шуурхай нэвтрүүлэх, борлуулах, эрдэм шинжилгээний ажлын үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгийн эргэцийг түргэтгэх зорилготой төслүүдийг аж ахуйн нэгж, шинжлэх ухаан, технологийн байгууллага, хамтлагт тодорхой зориулалттай, эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэхэд энэ гэрээний зорилго оршино.

Хоёр. Гэрээний талууд

Санхүүжүүлэгч талаас Сан, гүйцэтгэгч талаас хот (аймаг)
..... дүүргийн хороо, нутаг дэвсгэрт орших
..... яам, байгууллага, үйлдвэр,
компани захирал нь овогтой (цаашид
“гүйцэтгэгч” гэх) нь гэрээний нөхцлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр
200... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс 200... оны ...дугаар сарын ...-ны
өдөр хүртэл жил, сар, хоногийн хугацаатайгаар, эргэж
төлөгдөх баталгааг үндэслэн харилцан хариуцлага хүлээж, энэхүү гэрээг
байгуулав.

Гурав. Гэрээний ерөнхий нөхцөл

1. зориулалтаар эргэн
төлөгдөх нөхцөлтэй санхүүжилтийн хэмжээ (цаашид “санхүүжилт” гэх)
..... (тоогоор)
(үсгээр).
2. Санхүүжилт олгох хугацаа.....
Гэрээнд заасан санхүүжилтийн
... хувийг 200.. оны ... дугаар сарын ...-нд,
... хувийг 200.. оны ... дугаар сарын ...-нд,
... хувийг 200.. оны ... дугаар сарын ...-нд тус тус олгоно.
3. Мөнгөний ханшийн имфляцийн түвшинд ханшийн төлбөртэй байна. Гэрээний
хугацаанд тооцож авах ханшийн төлбөрийн хэмжээ...%, ханшийн төлбөрийг
тооцож авах хугацаа
-
(сар) (улирал)
4. Санхүүжилтийг эргүүлж төлөх хугацаа (хавсралт № 1-б)
5. Санхүүжилтийг төлж дуусах эцсийн хугацаа 200.. оны ...дугаар сарын ...-ны
өдөр
хугацаандаа төлөгдөөгүй санхүүжилтэд төлөх алдангийн хэмжээ ... хувь
байна.
6. Энэхүү гэрээний 3.3-д заасан санхүүжилтэд төлөхөөр тохирсон ханшийн
төлбөрийн хэмжээг мөнгөний зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, Төв банкнаас

явуулж байгаа мөнгөний бодлогоос хамаарч нэмэгдүүлэх буюу хорогдуулах эрхийг Сан эдлэхээр талууд харилцан тохиролцов.

7. Эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр энэхүү гэрээний 3.1-д заасан зориулалтаар олгосон хөрөнгийг гэрээнд зааснаас өөр зүйлд зарцуулахыг хориглоно.

8. Санхүүжилтийг графикайн дагуу төлөхгүй байгаа гүйцэтгэгч байгууллагад дахин зэхэц ажлын санхүүжилт олгохгүй.

Дөрөв. Хөрөнгийн баталгаа

4.1. Гүйцэтгэгч нь санхүүжилтийг авахын өмнө дор дурьдсан баталгааг санд гаргаж өгнө:

4.1.1. Гүйцэтгэгчийн өмчлөлд байгаа хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийг болон тухайн байгууллагын гүйцэтгэх төслүүдийн хөрөнгийг барьцаалан баталгааг гаргах ба тухайн хөрөнгийн паспорт, эрхийн бичиг, бусад баримт болон шаардлагатай үед зарим биет зүйлийг хэлцлийн журмаар түр хугацаагаар сан өөрийн мэдэлд авна.(хавсралт № 1-а)

4.1.2. Гэрээнд заасан хугацаанд эргэн төлөгдөх санхүүжилтийг бүрэн төлөхийг баталсан баталгааг гүйцэтгэгч нь санд бичгээр гаргаж өгнө.(хавсралт №1-б)

4.2. Хөрөнгийн баталгаа болон барьцаалах хөрөнгийн баримт өгөөгүй үед сан нь гүйцэтгэгчид санхүүжилтийг олгохгүй.

4.3. Хэрэв гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд санхүүжилтийг төлөөгүй буюу хугацаа хэтрүүлбэл энэ тухай гүйцэтгэгчид мэдэгдсэний үндсэн дээр барьцаанд авсан хөрөнгийг сан өөрийн мэдэлд шилжүүлэх эрхтэй.

Тав. Талуудын харилцан хүлээх үүрэг, эрх

5.1. Гүйцэтгэгч нь сангийн өмнө дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

5.1.1. Санхүүжилтийг гэрээнд заасны дагуу тогтоосон хугацаанд нь бүрэн төлөх,

5.1.2. Гэрээний нөхцлийг сахин биелүүлэх,

5.1.3. Эхний 3 жилийн дундаж цэвэр ашгийн 15 хувийг 1 удаа төлөх,

5.1.4. Зэхэц ажлын хэрэгжилтийн явцад бий болсон хөрөнгийг даатгуулах,

5.1.5. Өөрийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа болон санхүүжилттэй холбогдсон тайлан мэдээг шаардлагатай үед саадгүй гаргаж өгөх,

5.1.6. Хэрэв гэрээний үүргээ зөрчвөл Санд гаргасан баталгаанд үндэслэн барьцаалагдсан хөрөнгийг санд шилжүүлэх,

5.1.7. Гэрээнд заасан хэмжээнд санхүүжилтийг авах,

5.2. Сан нь гүйцэтгэгчийн өмнө дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

5.2.1. Санхүүжилтийг гэрээнд заасны дагуу тогтоосон хугацаанд нь гүйцэтгэгчид бүрэн шилжүүлэх,

5.2.2. Зэхэц ажлын хэрэгжилтийн явцад хяналт тавих, санал, зөвлөмж өгөх,

5.2.3. Авсан санхүүжилтийг төлөх хугацаа хэтэрсэн тохиолдолд гүйцэтгэгч байгууллагын төслийн санхүүжилтийг тодорхой хугацаагаар зогсоох, эсвэл тусгай дансанд бүртгэж барьцаа хөрөнгөөр төлүүлэх арга хэмжээ авах.

Зургаа. Гомдол гаргах, хариуцлага тооцох зарчим

6.1. Гэрээний нөхцлийг биелүүлээгүйгээс үүссэн хохирол, төлбөрийг төлүүлэх, хэрэг маргааныг шийдвэрлүүлэхдээ дор дурьдсан зарчмыг баримтална:

6.1.1. Хугацаа хэтэрсэн санхүүжилт болон тодорхой шалтгаанаар санхүүжилт эргэж төлөгдөхгүй байгаагаас үүссэн төлбөрийг сангийн эргэн төлөгдөх хөрөнгийн асуудал хариуцсан түшмэл шаардлага тавьж төлүүлнэ.

6.1.2. Гурван сараас дээш хугацаа хэтэрсэн буюу эрх зүйн үр дагавар бүхий санхүүжилтийн төлбөрийн зөрчлийг Сан шаардлага тавьж арилгуулах, төлбөрийг төлүүлэх, шаардлагатай үед шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.1.3. Гүйцэтгэгч илэрхий зөрчил гаргасан, санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан бол энэхүү гэрээг тэр даруйд зогсоож, хуульд заасан журмын дагуу шийдвэрлүүлнэ.

6.2. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний талаарх хэрэг, маргаан болон сангийн шийдвэрийн талаар гомдолтой тохиолдолд сангийн захирал болон хуулийн байгууллагад гомдол, өргөдлөө гарган шийдвэрлүүлж болно.

Долоо. Гэрээ хүчин төгөлдөр болох

7.1. Хоёр тал харилцан зөвшөөрч, гарын үсэг зурж, сангийн захирал, гүйцэтгэгч байгууллагын дарга (захирал) нар баталсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр болно.

7.2. Гэрээг 3 хувь үйлдэж, нотариатаар батлуулан гүйцэтгэгч, санхүүжүүлэгч болон ШУТ-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ШУТ-ийн асуудал хариуцсан нэгжид тус бүр нэг хувийг хадгалж, үйл ажиллагааны үндсэн баримт бичиг болгоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Санг төлөөлж:

.....

(гарын үсэг)
(тэмдэг)

Гүйцэтгэгчийг төлөөлж:

.....

(гарын үсэг)
(тэмдэг)

иргэний үнэмлэхийн дугаар

регистрийн дугаар

Хаяг: ажлын:

гэрийн

Утас: ажлын -, гэрийн-

Зэхэц ажлын гүйцэтгэгчийг төлөөлж
..... хүрээлэн (төв)-ийн захирал овогтой
..... би эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилтийг гэрээнд заасны дагуу
хугацаанд нь бүрэн төлөхийг баталж байна.

Өөрийн байгууллагын төсөл болон сэдэвт ажлын тухайн жилийн урсгал төсвийн
хөрөнгө, үйл ажиллагааны дотоод орлогыг хөрөнгийн барьцаа болгож байна.
Манай хүрээлэн /төв/-ийн урсгал төсвийн хөрөнгө жилд сая төгрөг ба
дотоод орлого жилд сая төгрөг болно. Гүйцэтгэгчийг төлөөлж доорхи биет
хөрөнгөөр барьцаалж байна. Үүнд :

А. сая төгрөг.

Б. сая төгрөг.

(тамга)

Баримт үйлдсэн:

(гүйцэтгэгч талаас)

Захирал

Ня-бо

(гарын үсэг)

Танилцсан, зөвшөөрсөн:

(сангийн талаас)

200.. оны ...дугаар сарын .. -ны өдөр

Авсан санхүүжилтийг буцааж төлөх баталгаат хугацаа

Санхүүжилтийг төлөх хугацаа он,сар, өдөр	Мөнгөний дүн	Тайлбар
200 ..		
200 ..		

(тэмдэг) Баталгаат хугацааг харилцан тохирч тогтоосон.

..... захирал ня-бо

..... захирал ня-бо

200 .. оны ... дугаар сарын ...-ны өдөр

БАРИЛГАД ЗАСВАР ХИЙХ ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(аж ахуйн нэгж, иргэний нэр, хаяг)

_____ -ЫГ ТӨЛӨӨЛЖ _____

_____ ,
(төлөөлсөн хүний нэр, албан тушаал)

нөгөө талаас _____
(аж ахуйн нэгж, иргэний нэр, хаяг)

-ЫГ ТӨЛӨӨЛЖ _____
(төлөөлсөн хүний нэр, албан тушаал, хаяг)

бид Монгол Улсын Иргэний хуулийн 343 -358 дугаар зүйлийг удирдлага болгон дараахь гэрээг байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Захиалагч нь батлагдсан төсөл, төсөв, ажлын зураг бүхий _____
_____ объектод засвар хийх
(засвар хийх барилгын нэрийг бичих)

даалгаврыг гүйцэтгэгчид өгнө.

1.2. Гүйцэтгэгч нь гэрээгээр тохиролцсон үндэслэл бүхий ажлыг хугацаанд нь гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгнө.

2. Ажлын хөлс, хугацаа

2.1. Ажлын хөлсийг хоёр тал харилцан тохиролцож тогтооно. Нийт хөлс _____ төгрөг байна.

2.2. Засварын ажлыг 200__ оны __ сарын __-ны өдрөөс эхлэн 200__ оны __ сарын __-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж дуусгана.

3. Захиалагчийн эрх, үүрэг

3.1. Гүйцэтгэсэн ажлыг захиалагчид мэдэгдсэнээс хойш _____ хоногийн дотор хүлээн авч тохиролцсон ёсоор хөлсийг төлөх үүрэгтэй.

3.2. Засвар хийхэд шаардагдах төсөл, төсвийн баримт бичиг, материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг гүйцэтгэгчид шилжүүлэн өгнө.

3.3. Засварын ажлын явцад хяналт тавих, хэрэв хүлээн авсан ажилд ямар нэг согог, доголдол илэрвэл ажил хүлээн авснаас хойш _____ сарын дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

3.4.

4. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1. Ажлыг захиалагчийн даалгавар, зураг, төсөл, төсвийн дагуу гүйцэтгэнэ.

4.2. Захиалагчийн өгсөн баримт бичиг, материал, тоног төхөөрөмж засварын ажилд согог, дутагдал илэрвэл түүнийг өөрчлөх, сольж өгөхийг шаардах эрхтэй.

4.3. Ажлын үр дүнгийн доголдлыг арилгахад шаардагдах зардлыг хариуцана.(ажлын хөлс, материалын зардал, замын хураамж болон тээврийн зардал гэх мэт)

4.4. _____

5. Талуудын хүлээх хариуцлага

5.1. Гүйцэтгэгч ажлыг зохих ёсоор биелүүлээгүй бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн _____ хувийн торгууль төлнө.

5.2. Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаа хэтрүүлэн ажлыг гүйцэтгэсэн бол хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн _____ хувийн алданги төлнө.

5.3. Хариуцагч гэрээнд заасан үүргийг өөрийн буруугаас биелүүлээгүй бол гүйцэтгэгчид учирсан зардал, хохирлыг хариуцна.

6. Талуудын хаяг

Захиалагч:

Гүйцэтгэгч:

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____ (цаашид “Түрээслүүлэгч гэх”)
(иргэн, хуулийн этгээдийн нэр)

түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн _____,
(дүрэм буюу гэрээгээр) (төлөөлсөн хүний нэр, албан тушаал)

нөгөө талаас _____ (цаашид “Түрээслэгч гэх”)
(иргэн, хуулийн этгээдийн нэр)

түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн _____
(дүрэм буюу гэрээгээр) (төлөөлсөн хүний нэр, албан тушаал)

бид дараахь нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгууллаа.

1. Нийтлэг заалт

1.1. Түрээслүүлэгч энэхүү гэрээний хавсралт болон тодорхойлолт - жагсаалтад заагдсан эд зүйлийг түр хугацаагаар эзэмшүүлэх, ашиглуулахаар, эсвэл түр хугацаагаар ашиглуулахаар Түрээслэгчид шилжүүлэх үүрэг хүлээнэ.

2. Гэрээний үнэ

Түрээслэгч эд хөрөнгийг хүлээн авч түрээсийн төлбөр _____ төгрөгийн _____ хугацаанд төлөх үүрэгтэй.

3. Төлбөрийн нөхцөл

3.1. Төлбөрийг _____ хийнэ.
(нэгэн зэрэг, үе шаттайгаар)

3.2. Төлбөрийг _____ хэлбэрээр хийнэ.
(төлбөрийн шаардлага, төлбөрийн даалгавар)

4. Үүрэг гүйцэтгэх хугацаа

4.1. Энэхүү гэрээний 1-д заасан эд хөрөнгийг гэрээнд гарын үсэг зурснаас хойш _____ хоногийн дотор эд хөрөнгө хүлээн авсан, хүлээлгэн өгсөн актын дагуу Түрээслэгчид шилжүүлнэ.

4.2. Түрээслэгч төлбөрийг _____ төлнө.
(төлбөрийн хугацаа, нөхцөлийн дагуу)

4.3. Гэрээний үйлчлэх хугацаа:

4.3.1. Эхлэл: _____

4.3.2. Төгсгөл: _____

5. Талуудын хүлээх үүрэг

5.1. Түрээслүүлэгчийн хүлээх үүрэг:

5.1.1. Гэрээний нөхцөлийг бүрэн хангасан эд хөрөнгийг Түрээслэгчид цаг тухайд нь шилжүүлэн өгнө.

5.1.2. Эд хөрөнгөд _____ хугацааны дотор их засвар хийнэ.

5.1.3. Түрээслүүлсэн эд хөрөнгийг аль болох ашигтай ашиглуулахаар зөвлөгөө өгөх буюу бусад туслалцаа үзүүлнэ.

5.2. Түрээслэгчийн хүлээх үүрэг:

5.2.1. Эд хөрөнгийг гэрээнд заасан нөхцөл болон зориулалтын дагуу ашиглана.

5.2.2. Эд хөрөнгийг эвдэж, гэмтээхгүй ашиглах, өөрийн зардлаар урсгал засвар хийнэ

5.2.3. Гэрээнд заасан хугацаанд түрээсийн төлбөрийг төлнө.

5.2.4. Гэрээ дуусгавар болмогц хэвийн элэгдэл хорогдлыг тооцон бүрэн бүтэн байдлаар эд хөрөнгийг буцаан өгнө.

6. Талуудын хүлээх хариуцлага

6.1. Талууд нь энэхүү гэрээний нөхцөлүүдийг биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүйн төлөө эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ.

6.2. Түрээслэгч гэрээнд заасан хугацаанд түрээсийн төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд үнийн дүнгийн _____ хувийн торгууль хүлээнэ.

6.3. Хугацааг _____ хоногоос дээш хоногоор хожимдуулсан бол Түрээслүүлэгч гэрээг цуцалж өөрт учирсан хохирлыг арилгахыг шаардана.

6.4. Тухайн гэрээнд заагдсан бусад үүргийг гэм буруугийн улмаас биелүүлээгүй тохиолдолд жилийн түрээсийн төлбөрийн _____ хувиар торгууль төлнө.

6.5. Торгууль төлөх нь талуудын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх болон зөрчлийг арилгахаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

7. Давагдашгүй хүчин зүйл

7.1. Гэрээнд оролцогчдын хүсэл, зоригийн гадуур, урьдчилан мэдэж арилгах боломжгүй дайн байлдаан, иргэдийн бослого хөдөлгөөн, нийтийг хамарсан өвчлөлт, бүслэлт, хориг, газар хөдлөлт, усны үер, гал түймэр, бусад байгалийн аюулт үзэгдэл зэрэг нөхцөл байдлын улмаас гэрээг биелүүлэх боломжгүй болсон бол гэрээний оролцогчид харилцан хариуцлага хүлээхгүй.

7.2. Төрийн эрх бүхий байгууллагаас гаргаж өгсөн гэрчилгээ нь давагдашгүй хүчин зүйл байсан, мөн үргэлжилсэн хугацааны хангалттай нотолгоо болно.

8. Маргаан шийдвэрлэх журам

8.1. Гэрээний явцад талуудын хооронд үүссэн бүх маргаан, зөрөлдөөнийг талуудын хэлэлцээгээр шийдвэрлэнэ.

8.2. Хэрэв санал зөрөлдөөнийг хэлэлцээгээр шийдвэрлэж чадахгүй бол (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зурах).

9. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

9.1. Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

10. Нэмэлт нөхцөл

11. Бусад заалт

11.1. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэнэ. Хууль зүйн хувьд хувь тус бүр адил хүчинтэй байна.

11.2. Гэрээний хавсралт:

12. Талуудын хаяг

Түрээслүүлэгч:

Хаяг: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

Түрээслэгч:

Хаяг: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

Улаанбаатар хот. Дугаар _____ оны __ -р сарын __

Нэг талаас Банк _____
(нэр, хаяг)
(цаашид "Түрээслүүлэгч" гэнэ), түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

негөө талаас _____
(байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)
(цаашид "Түрээслэгч" гэнэ), түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

бид дор дурьдсан гэрээг байгуулав. Үүнд:

1. Гэрээний зүйл

1.1. Түрээслүүлэгч нь дор тоног төхөөрөмжийг гэрээнд заасан хугацаанд эзэмшүүлэн ашиглуулахаар шилжүүлэн өгч, түрээслэгч түүнийг хүлээн авна:

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Үнэ	Элэгдэл хорогдол тооцох хугацаа
	Бүгд			

1.2. Түрээслүүлэгч банк нь 1.1-д заасан эд хөрөнгийг өөрөө үйлдвэрлэх буюу гуравдагч этгээдээр үйлдвэрлүүлэх эсвэл худалдан авсан байна. Түрээслүүлэхээр шилжүүлж буй тоног төхөөрөмж нь түрээслүүлэгчийн (банкны) өмч байна.

2. Тоног төхөөрөмжийг түрээслүүлэхээр шилжүүлэн өгөх журам

2.1 Түрээслүүлэгч банк нь тоног төхөөрөмжийг шилжүүлэн өгөх түүний чанар, иж бүрдлийн талаар бэлтгэн нийлүүлэгчид шаарлага тавих эрхийг түрээслэгчид шилжүүлнэ.

2.2 Түрээслүүлэгч банк бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулснаа түрээслэг цаг тухайд нь мэдэгдэж түүнд тоног төхөөрөмжийг хүлээн авахад шаардагдах бүх бичиг баримтуудыг шилжүүлнэ.

2.3 Түрээслэгч тоног төхөөрөмжийг хүлээн авснаас хойш _____ хоногийн дотор тоног төхөөрөмжийг хүлээн авсан, ашиглалтад оруулсан тухай актын хуулбарыг түрээслүүлэгчид явуулна.

2.4. Бэлтгэн нийлүүлэгчээс тухайн тоног төхөөрөмжийн чанар, иж бүрдлийн талаарх шаардлагыг зөрчсөн нь түрээслэгчийг энэхүү гэрээний дагуу хүлээх хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

3. Түрээсийн хугацаа

3.1. Түрээсийн тоног төхөөрөмжийг шилжүүлэн өгсөн хугацааг хүлээлгэн өгөх, хүлээн авах актанд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн тооцно.

3.2. Түрээсийн хугацаа нь тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн, авсан актанд гарын үсэг зурснаас өдрөөс хойш _____ жил (сар, хоног) болно.

3.3. Түрээсийн хугацааг зөвхөн талуудын тохиролцсоноор богиносгож болно.

4. Түрээсийн төлбөр, тоцоо хийх журам

4.1. Түрээсийн төлбөрийг (нэмүү өртгийн татварыг оролцуулан) дараахь графикайн дагуу төлнө.

_____ он _____ төгрөг

_____ он _____ төгрөг

_____ он _____ төгрөг

_____ он _____ төгрөг

БҮГД _____ төгрөг

4.2. Түрээсийн төлбөрийг бэлэн бусаар түрээслүүлэгч банкны тоот дансанд _

_____ (улирал бүрт дараагийн улирал эхлэхээс _____ хоногийн өмнө гэх мэт) хугацаанд шилжүүлнэ.

4.3. Түрээсийн төлбөрийг талуудын тохиролцооноор бараа, хүнсний зүйл оролцуулан өгөх буюу үйлчилгээ үзүүлэх замаар эсвэл холимог хэлбэрээр төлж болно.

4.4. Түрээсийн төлбөрийн хэмжээг талууд харилцан тохиролцох замаар өөрчилж болно.

5. Түрээслүүлэгчийн эрх үүрэг

5.1. Түрээслүүлэгч банк нь түрээсийн тоног төхөөрөмжийг энэ гэрээний нөхцөлд зааснаар ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих эрхтэй.

6. Түрээслэгчийн эрх, үүрэг

6.1. Түрээслэгч нь тоног төхөөрөмжийн тохиолдлын бүрэн ба зарим эвдрэл гэмтлийн эрсдлийг хүлээнэ.

6.2. Түрээслэгч тоног төхөөрөмжийг хүлээн авснаас хойш _____хоногийн дотор даатгуулсан байна.

6.3.Түрээслэгч түүнчлэн:

- Түрээсийн тоног төхөөрөмжийг зориулалтаар нь ашиглах.

- Түрээсийн тоног төхөөрөмжийг бүрэн бүтэн байлгах.

- Түрээсийн эд хөрөнгөнд урсгал засвар болон урьдчилан сэргийлэх үйлчилгээг өөрийн зардлаар хийх.

- Тоног төхөөрөмжийг ашиглах, техникийн үйлчилгээ-засвартай холбогдсон зардлыг хариуцна.

- Тоног төхөөрөмжийн их засвар болон урсгал засварыг өөрийн зардлаар хариуцаж хийлгэнэ.

6.4. Түрээслэгч түрээслүүлэгч банкны зөвшөөрлийн үндсэн дээр тоног төхөөрөмжийг дамжуулан түрээсэлж болно.

7. Тоног төхөөрөмжийг түрээслүүлэгч банкинд буцаан өгөх журам

7.1. Түрээслүүлэгч түрээсийн хугацаа дууссанаас хойш _____хоногийн дотор түрээсийн тоног төхөрөмжийг түрээслүүлэгч банкинд зохих баглаа боодолтойгоор техникийн баримт бичгийн хамт хүлээлгэн өгч акт үйлдэж гарын үсэг зурна.

7.2. Түрээсийн тоног төхөөрөмжийг түрээслүүлэгчид хэвийн элэгдэл хорогдлыг тооцон бүрэн бүтэн байдлаар нь хүлээлгэн өгнө.

7.3. Түрээслэгч түрээсийн тоног төхөөрөмжийг бүрэн буюу зарим хэсгийг нэмэлт гэрээгээр түрээслүүлэгчээс худалдан авч болно.

7.4. Түрээслэгч өөрийн хөрөнгөөр түрээслүүлэгч банкны зөвшөөрлөөр түрээсийн тоног төхөөрөмжид хийсэн бөгөөд тоног төхөөрөмжид гэмтэл учруулахгүйгээр авч болохгүй сайжруулсан зүйлийн үнийг нөхөн авах _____

_____.
(эрхтэй, эрхгүй)

8. Талуудын хариуцлага

8.1. Түрээслэгч түрээслүүлэгч банкны өмнө дараахь хариуцлага хүлээнэ:

-Түрээслэгч тоног төхөөрөмжийг хүлээн авснаас хойш _____ хоногийн дотор түрээслүүлэгч банкинд мэдэгдээгүй бол _____ төгрөгийн торгууль төлнө.

- Түрээсийн тоног төхөөрөмжийг хүлээн авах хугацаа хожимдуулсан бол тоног төхөөрөмжийн үнийн _____ хувьтай тэнцэх алдангийг хугацаа хожимдуулсан хоног тутамд төлнө.

- Түрээсийн төлбөр төлөх хугацааг хожимдуулсан бол өөрийн дүнгийн _____ хувьтай тэнцэх хэмжээгээр алдангийг хожимдуулсан өдөр бүр төлнө.

- Түрээсийн тоног төхөөрөмжийг зориулалтын бусаар ашигласан бол гэрээний үнийн дүнгийн _____ хувьтай тэнцэх торгууль төлнө.

9. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах үндэслэл

9.1. Талуудын аль нэг нь гэрээний үүрэг, нөхцөлийг байнга зөрчихөөс бусад тохиолдолд энэхүү гэрээг нэг талын журмаар цуцлахгүй.

9.2. Бусад үндэслэл _____

10. Бусад нөхцөл

10.1. Энэ гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдсэн бөгөөд тал тус бүр нэг хувийг хадгална.

10.2. Энэ гэрээнд тусгагдаагүй асуудлыг Монгол улсын иргэний хууль тогтоомжоор зохицуулна.

10.3. Энэ гэрээнд гарын үсэг зурмагц түүнтэй холбогдуулан хийсэн урьдчилсан хэлцэл, баримт бичиг нь хүчингүй болсонд тоцогдоно.

10.4. Энэ гэрээнд орсон аливаа засвар нь зөвхөн хоёр талын эрх бүхий төлөөлөгчдийн тухай бүр харилцан тохиролцож сайшаасаны үндсэн дээр хүчин төгөлдөр болно.

10.5. Талуудын хууль ёсны хаяг, банкны хаяг, гарын үсэг:

Түрээслүүлэгч:

Хаяг: _____

Утас: _____ факс: _____

Банкны харилцах дансны дугаар _____

Түрээслэгч:

Хаяг: _____

Утас: _____ факс: _____

Банкны харилцах дансны дугаар _____

Түрээслүүлэгч :

Түрээслэн авагч:

(гарын үсэг)
тэмдэг

(гарын үсэг)
тэмдэг

ОРОН СУУЦНЫ ЗОРИУЛАЛТЫН БУС БАЙР ТҮРЭЭСЛЭХ ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____ (цаашид “Түрээслүүлэгч гэх”)
(иргэн, хуулийн этгээдийн нэр)

түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн _____,
(дүрэм буюу гэрээгээр) (төлөөлсөн хүний нэр, албан тушаал)

нөгөө талаас _____ (цаашид “Түрээслэгч гэх”)
(иргэн, хуулийн этгээдийн нэр)

түүнийг _____ үндсэн дээр төлөөлөн _____
(дүрэм буюу гэрээгээр) (төлөөлсөн хүний нэр, албан тушаал)

бид дараахь нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Түрээслүүлэгч нь _____,
(байрны хаяг, байршил)

_____ талбай бүхий хэвийн ашиглах боломжтой орон сууцны зориулалтын
(м.кв)

бус байрыг Түрээслэгчид шилжүүлэн өгнө.

1.2. Уг байрыг _____ ашиглана.
(зориулалтын дагуу)

2. Талуудын хүлээх үүрэг

2.1. Түрээслүүлэгчийн хүлээх үүрэг:

2.1.1. Өөрийн хүч, хөрөнгөөр _____ хугацаанд их засвар
хийнэ.

2.1.2. Түрээслэгчийн буруугүйгээр осол аюул гарсан тохиолдолд түүний
хор уршгийг арилгах шаардлагатай арга хэмжээ авна.

2.1.3. _____

2.2. Түрээслэгчийн хүлээх үүрэг:

2.2.1. Байрыг зөвхөн гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглана.

2.2.2. Байрыг бүрэн бүтэн байлгаж, ариун цэвэр-техникийн шаардлагын
дагуу ашиглана.

2.2.3. Цаг тухайд нь өөрийн хүч хөрөнгөөр урсгал засвар болон засал
чимэглэлийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

2.2.4. Байрны сантехник, цахилгаан шугам сүлжээ, бусад тоног
төхөөрөмжид осол аюулын шинж байдал илэрвэл нэн даруй түрээслүүлэгчид
мэдэгдэнэ.

2.2.5. Түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр барилгыг өөрчлөх, сантехник
болон цахилгаан шугам сүлжээг өөрчлөх, их засвар хийхийг хориглоно.
Түрээсийн байрны зайлшгүй сайжруулалтыг зөвхөн түрээслүүлэгчийн бичгээр
өгсөн зөвшөөрлөөр хийж гүйцэтгэнэ.

2.2.6. Гэрээний хугацаа дуусаж байрыг чөлөөлөх, мөн хугацаанаас өмнө
чөлөөлөх болсон тухайгаа _____ хоногийн дотор түрээслүүлэгчид мэдэгдэж
барилгын элэгдэл хорогдлыг тооцон акт үйлдэн хүлээлгэж өгнө.

2.2.7. _____

2.3. Түрээсийн байр нь түрээслэгчийн үйл ажиллагааны үр дүнд, эсвэл шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь аваагүйн улмаас аюул осолтой болвол нэн даруй түрээслүүлэгчид мэдэгдэж өөрийн хүч хөрөнгөөр сэргээн босгож учруулсан хохирлыг төлнө.

2.4. Түрээсийн байрыг зөвхөн түрээслүүлэгчийн зөвшөөрснөөр дамжуулан түрээслэж болно.

3. Төлбөр, тооцоо

3.1. Түрээслэгч түрээсийн төлбөрийг _____ тооцооны дагуу

(сар, улирал, жил)

_____ төгрөгөөр хийнэ.

3.2. Түрээсийн үнэ үнийн бодит өөрчлөлт болон үнэд нөлөөлөх бусад хүчин зүйлүүдээс шалтгаалж оролцогчдын аль нэг талын хүсэлтээр өөрчлөгдөж болно. Түрээсийн үнийг өөрчлөхийг санаачлагч тал нөгөө талдаа _____ хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

3.3. Гэрээгээр тодорхойлсон түрээсийн төлбөрийг _____ тутам _____

(сар, улирал)

(сар, өдөр)

өдрөөс эхлэн _____ багтаан түрээслэгч түрээслүүлэгчийн талд

(сар, улирал)

шилжүүлнэ.

3.4. Түрээсийн төлбөрийг хугацаа хожимдуулсан өдөр бүр _____ хувиар тооцож алданги төлөх ба энэ нь нийт үнийн дүнгийн _____ хувиас их байж болохгүй.

3.5. Түрээсийн гэрээ дуусаж байрыг чөлөөлсөн түрээслэгч төлөгдөөгүй үлдсэн урсгал засварын үнийг төлнө. Түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр хийсэн зайлшгүй сайжруулалтын үнийг нөхөн олгохгүй.

4. Гэрээний үйлчлэх хугацаа, гэрээг өөрчлөх ба цуцлах журам

4.1. Түрээсийн гэрээ нь 200__ оны __ сарын __-ны өдрөөс эхлэн 200__ оны __ сарын __-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

4.1.1. Гэрээний хугацаа дууссан, гэрээний бүх нөхцөлийг зохих ёсоор биелүүлсэн тохиолдолд түрээслэгч гэрээг сунгах хүсэлт гаргах эрхтэй.

4.1.2. Гэрээний хугацаа дуусахаас өмнө _____ хоногийн дотор гэрээг сунгах хүсэлтээ түрээслэгч түрээслүүлэгчид гаргана.

4.2. Хоёр тал харилцан тохирч гэрээний нөхцөлийг өөрчлөх буюу цуцалж болно.

4.3. Түрээслүүлэгчийн шаардлагаар гэрээг хугацаанаас өмнө цуцалж, дараахь тохиолдолд түрээслэгчийг нүүлгэн гаргана.

4.3.1. Байрыг зориулалтын бусаар ашигласан;

4.3.2. Байрны чанар байдлыг санаатай болон болгоомжгүйгээр муутгасан;

4.3.3. Түрээсийн төлбөрийг _____ доошгүй хугацаагаар төлөөгүй;

4.3.4. Гэрээгээр хүлээсэн засвар, тохижилт хийх үүргээ биелүүлээгүй.

4.3.5. _____

4.4. Түрээслэгчийн шаардлагаар гэрээг цуцлах

4.4.1. Түрээслэгчийн хүсэл зоригоос гадуур байр ашиглах боломжгүй болсон.

4.4.2. _____

4.5. Гэрээ нь иргэний эрх зүйн харилцаан дахь давагдашгүй хүчин зүйлийн улмаас дуусгавар болж болно.

4.6. Гэрээ нь нэг талын хүсэл зоригор дуусгавар болохгүй.

4.7. Гэрээнээс үүсэн гарах маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ. Хэрэв ийнхүү шийдвэрлэх боломжгүй бол (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зурах).

5. Нэмэлт нөхцөл

6. Гэрээний хавсралт

6.1. Хавсралт –1: _____ хуудас

6.2. Хавсралт –2: _____ хуудас

7. Талуудын хаяг

Түрээслүүлэгч:

Хаяг: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

Түрээслэгч:

Хаяг: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

ХУДАЛДААНЫ БАЙРАНД ТАЛБАЙ ТҮРЭЭСЛЭХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

№ _____

_____ хот
(аймаг, сум, дүүрэг)

200_ оны __ дугаар
сарын __ -ны өдөр

Нэг талаас _____
(иргэн, хуулийн этгээдийн нэр)
(цаашид “Түрээслүүлэгч” гэнэ.)-ыг _____ үндсэн дээр
(байгууллагын дүрэм, итгэмжлэл)
_____ төлөөлж, нөгөө талаас
(эцэг/эх/-ийн нэр, нэр, албан тушаал)
_____ (цаашид “Түрээслэгч” гэнэ.)
(иргэн, хуулийн этгээдийн нэр)
-ыг _____ үндсэн дээр _____
(байгууллагын дүрэм, итгэмжлэл) (эцэг/эх/-ийн нэр, нэр, албан тушаал)
төлөөлөн дараахь гэрээг байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Түрээслэгч _____ хаягаар байгаа худалдааны (байр) цогцолборын _____ кв.м худалдаа хийх зориулалттай талбайг түрээслэгчид шилжүүлэн өгнө.

1.2. Түрээсийн талбайд энэ гэрээний салшгүй хэсэг болох _____ дугаар хавсралтын жагсаалтад байгаа барааг худалдах зорилгоор түрээслүүлнэ.

1.3. Түрээсийн талбайд худалдааны үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой дараахь үйлчилгээг түрээслүүлэгч түрээслэгчид үзүүлнэ.

- цахилгаан, дулаанаар хангах;
- түрээсийн талбай, орчин тойрныг нь цэвэр байлгах;
- түрээслэгчийн сурталчилгааг хийх;
- худалдааны талбайг хамгаалах;

- _____ ;
- _____ .

1.4. Түрээслэгч үүсч болох эрсдэл болон эрхлэх үйл ажиллагаатай холбоотой төрөөс олгодог зөвшөөрлийг өөрөө хариуцаж, худалдааны үйл ажиллагааг өөрийн нэрийн өмнөөс явуулна.

2. Тооцоо хийх журам

2.1. Түрээсийн талбайн хөлс нэг сард _____ төгрөг, нэг жилд _____ төгрөг байна.

2.2. Түрээслүүлэгчийн үзүүлэх үйлчилгээний жагсаалт энэ гэрээний салшгүй хэсэг болох _____ дугаар хавсралтад байна. Хэрэв гуравдагч этгээдээс үзүүлж байгаа үйлчилгээнийхээ үнийг нэмсэн тохиолдолд түүний ашиг сонирхлыг хөндөхгүйгээр талууд гэрээнд нэмэлт оруулна. Энэ гэрээнд гарын үсэг зурах үед үзүүлж байгаа үйлчилгээний нийт үнэ _____ төгрөг байна.

2.3. Түрээслэгч түрээсийн хөлсийг бэлэн бусаар түрээслүүлэгчийн банк дахь тооцооны дансанд сар бүрийн _____ -аас өмнө урьдчилан шилжүүлнэ.

3. Талуудын үүрэг

3.1. Түрээслүүлэгчийн үүрэг:

3.1.1. Энэ гэрээнд гарын үсэг зурснаас хойш _____ хоногийн дотор энэ гэрээний 1.1-д заасан талбайг хүлээлгэн өгөх–хүлээн авах актаар түрээслэгчид шилжүүлэн өгнө. Актад түрээслүүлж буй талбайн тухайн үеийн техникийн байдлыг тодорхой зааж өгнө.

3.1.2. Түрээслэгчээс шалтгаалаагүй аливаа осол гарсан нөхцөлд түүнийг арилгах шаардлагатай арга хэмжээ авна.

3.1.3. _____

3.1.4. _____

3.2. Түрээслэгчийн үүрэг:

3.2.1. Түрээсийн талбайг зөвхөн энэ гэрээний 1.2.-д заасан зориулалтаар ашиглана.

3.2.2. Түрээсийн байранд урсгал засварыг өөрийн хөрөнгөөр цаг тухайд нь хийнэ.

3.2.3 Түрээслүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түрээсийн талбайд аливаа өөрчлөлт, нэмэлт тоноглолт хийхгүй байна.

3.2.4. Энэ гэрээний үйлчлэх хугацааны туршид түрээслэн өгөх-хүлээн авах актаар түрээслүүлэгчид түрээсийн талбайг бүрэн байдлаар, зохих элэгдэл, хорогдлыг харгалзан буцааж өгнө.

3.2.5 Гэрээний хугацаа дууссанаар түрээсийн талбайд байгаа бөгөөд түүнээс салгаж үл болох засвар, өөрчилсөн, сайжруулсан зүйлийн хамт түрээслүүлэгчид шилжүүлж өгнө.

3.2.6. Захиргааны байгууллагаас байр ашиглалттай холбоотой төлбөр тавьсан тохиолдолд энэ талаар түрээслүүлэгчид нэн даруй мэдэгдэнэ.

3.2.7. Түрээсийн талбайг дамжуулан түрээслүүлэхгүй.

3.2.8. _____

4. Талуудын хариуцлага

4.1. Түрээслүүлэгч энэ гэрээний дагуу дараахь хариуцлага хүлээнэ:

4.1.1. Энэ гэрээний 3.1.1-д заасан хугацааны дотор түрээсийн байрыг олгоогүй, эсвэл түрээслэгчийг энэ гэрээнд заасан нөхцөлийн дагуу түрээсийн талбайг ашиглахад саад болох нөхцөл бий болгосон тохиолдолд түрээслүүлэгч түрээслэгчид хугацаа хэтрүүлсэн өдөр бүр аль эсвэл жилийн түрээсийн нийт төлбөрөөс _____ хувийн хэмжээтэй алдангийг төлнө.

4.1.2. _____

4.2. Түрээслэгч энэ гэрээний дагуу дараахь хариуцлага хүлээнэ:

4.2.1. Энэ гэрээнд заасан хугацаанд түрээсийн төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хэтрүүлсэн өдөр бүрийн төлбөрөөс _____ хувь алданги төлнө.

4.2.2. Энэ гэрээний 3.2-т заасан үүргээ биелүүлээгүй нөхцөлд түрээслүүлэгчид _____ хэмжээний торгууль төлнө.

4.2.3. _____

4.3. Энэ гэрээнд заасан хэмжээгээр алданги төлөх нь талуудыг үндсэн үүргээ биелүүлэх, аль эсвэл хохирлыг арилгах үүргээс чөлөөлөхгүй.

5. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах

5.1. Энэ гэрээг дараахь нөхцөлд хугацаанаас нь өмнө цуцалж, түрээслэгчийг түрээсийн байрнаас гаргана. Үүнд:

- 5.1.1. Түрээсийн талбайг гэрээнд заасан зориулалтаар ашиглахгүй байх;
5.1.2. _____ хугацааны дотор түрээслэгч түрээсийн төлбөрийг төлөхгүй байх;
5.1.3. Түрээслэгч хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх;
5.1.4. _____
- 5.2. Түрээслэгч дараахь нөхцөлд энэ гэрээг цуцлах эрхтэй.
5.2.1. Түрээслүүлэгч хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх;
5.2.2. Түрээслэгчийн үл хариуцах нөхцөл байдлын улмаас байрыг ашиглах боломжгүй байдал бий болсон тохиолдолд;
5.2.3. _____
- 5.3. Нэг тал нь энэ гэрээг цуцалж байгаагаар бичгээр мэдэгдсэн үеэс энэ гэрээний 5.1, 5.2-т заасан үндэслэлээр нэг талын зүгээс энэ гэрээг цуцалсан гэж тооцно.
- 5.4. Гэрээг хугацаанаас өмнө нэг талаас цуцалж байгаа нөхцөлд түрээсийн талбайг _____ өдрийн дотор хүлээлгэн өгөх, хүлээн авах актын дагуу түрээслүүлэгчид буцааж өгөх ёстой.

6. Давагдашгүй хүчин зүйл

- 6.1. Давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, үймээн, бослого, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт)-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.
- 6.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.
- 6.3. Тухайн нөхцөл байдлын улмаас гэрээний үүргийн хугацаа _____
(тоогоор)
- хоногоор хойшлогдвол талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд хохирол төлүүлэхийг шаардахгүй.

7. Бусад нөхцөл

- 7.1. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурсан үеэс хүчин төгөлдөр болж 200__ оны __ дугаар сарын __-ны өдөр хүртэл үйлчилнэ.
